

**ТӨСВИЙН БОЛОН ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-72
1. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай/	7-50
2. Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	50-72

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороодын
хамтарсан 10 дугаар сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 56 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 53.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 00 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Мөнхсоёл, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: М.Нарантуяа-Нара;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа, А.Ганбаатар, Ж.Ганбаатар, М.Ганхүлэг, Ц.Даваасүрэн;

Тасалсан: Х.Баасанжаргал, Ж.Алдаржавхлан, Д.Батлут, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Д.Жаргалсайхан, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин.

Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Х.Энэбиш, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа 11 цаг 17 минутаас 11 цаг 44 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын иргэн Б.Номингоос нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан өргөдлийг Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг, нийтийн өргөдлийг

хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нар танилцуулав.

Нийтийн өргөдөл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ж.Батжаргал, Б.Найдалаа, Т.Мөнхсайхан, С.Зулпхар, Б.Бейсен, С.Эрдэнэбат, Х.Болормаа, О.Саранчулуун, Ч.Номин, Л.Энхнасан, Б.Хэрлэн, Ж.Галбадрах, Н.Алтаншагай, П.Ганзориг, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, нар хариулж, тайлбар хийв.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа 12 цаг 00 минутаас 12 цаг 28 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ц.Мөнхтуяа, Ц.Баатархүү, П.Ганзориг нар үг хэлэв.

Х.Ганхуяг: Монгол Улсын иргэн Б.Номингийн гаргасан нийтийн өргөдлийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт шилжүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	8
Бүгд:	37
78.4 хувийн саналаар дэмжигдлээ.	

Уг асуудлыг 13 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг,

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү, мөн банкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн захирал М.Батболд, Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын орлогч П.Мөнхнаст, Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал С.Энх-Ирээдүй, Төрийн банкны Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал Б.Амарсанаа, Монголын банкны холбооны Хууль, эрх зүй, хамтын ажиллагаа хариуцсан ахлах менежер Б.Солонго нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Х.Энэбиш, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа 14 цаг 00 минутаас хуралдааныг даргалав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, О.Саранчулуун, Б.Найдалаа, Ж.Баясгалан нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү, мөн банкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн захирал М.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа нар үг хэлэв.

Б.Найдалаа: Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт шилжүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 08 минут үргэлжилж, 56 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 66.1 хувийн ирцтэйгээр 15 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

ХҮНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 21-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 00 минут.

ТӨСВИЙН БОЛОН ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Эрхэм гишүүдийн амгаланг айлтгая. Байнгын хороодын хамтарсан хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Норовын Алтанхуяг, Тилеуханы Аубакир, Жигжидийн Батжаргал, Жадамбаагийн Баясгалан, Жанчивын Галбадрах, Сархадын Зулпхар, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Отгоны Саранчулуун, Ганбатын Хосбаяр, Доржзовдын Энхтуяа, Наранцэцэгийн Алтаншагай, Цэндийн Баатархүү, Отгоншарын Батнайрамдал, Буланы Бейсен, Пүрэвжавын Ганзориг, Тогтмолын Мөнхсайхан, Бадрахын Найдалаа, Мягмардашийн Сарнай, Бадарчийн Хэрлэн, Дашцэрэнгийн Энхтүвшин, Аюушийн Ариунзаяа, Ринчиндоржийн Батболд, Жамбын Батсуурь, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Пүрэвбаатарын Мөнхтулга, Чинбатын Номин, Ганзоригийн Тэмүүлэн, Лутаагийн Энхнасан, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Ирээгүй гишүүд Жуковын Алдаржавхлан, Дамбын Батлут, Шинэбаярын Бямбасүрэн, Гомбын Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Загджавын Мэндсайхан, Даваахүүгийн Пүрэвдаваа, Банзрагчийн Түвшин, Мөнхчулууны Энхцэцэг гадаад томилолттой, Хүрэлбаатарын Баасанжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа тасалсан байна. Жамбалын Ганбаатар, Даваасамбуугийн Ганмаа, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Баатаржавын Мөнхсоёл гадаад томилолттой байна. Дүгэрийн Рэгдэл, Даваагийн Цогтбаатар гадаад томилолттой байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Далайн Батбаяр, Дуламын Бум-Очир, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн өвчтэй байна. Мөнгөнцогийн Ганхүлэг, Батжаргалын Заяабал, Мөнхтөрийн Нарантуяа чөлөөтэй, Пүрэвжавын Сайнзориг, Баттогтохын Чойжилсүрэн нарын гишүүн өнөөдрийн хуралд ирээгүй байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хороодын гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ирэх ёстой гишүүдээс 56 гишүүнээс 30 гишүүн 53,6 хувьтай бүрдсэн тул 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Хэлэлцэх 2 асуудал байна.

1 дүгээр асуудал Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах талаар/

2.Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт гэсэн 2 асуудлыг хэлэлцэх нь байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё.

Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, 33,083 иргэдээс гаргасан эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдлийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсэг Жавхлан сайд, Наранбаяр сайд, Аубакир сайд, Чинбүрэн сайд, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Сангийн яам, Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Боловсролын яам Адьяасүрэн Санхүүгийн хэлтсийн дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга ирээгүй байгаа юм байна. Тэнд байгаа юм байна. Зарим ажлын хэсэг Өргөдлийн байнгын хорооноос бас орж ирээгүй байгаа юм байна.

Иргэн Б.Номингоос эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай өргөдлийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдөр байршуулсан байна. Тус нийтийн өргөдлийг 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар нийт 33,083 иргэн дэмжсэн бөгөөд уг нийтийн өргөдөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5.3-д заасан “тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах саналыг 33 мянга ба түүнээс дээш иргэн дэмжсэн бол Улсын Их Хурал хэлэлцэнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-д заасны дагуу холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн. Дээрх нийтийн өргөдлийг Өргөдлийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлт ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа.

Дээрх өргөдлийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат танилцуулна. Эрдэнэбат байгаа юм уу. Тэгвэл оронд нь Ганзориг гишүүн танилцуулчих уу.

П.Ганзориг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын иргэн Батсайханы Номин “Эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай” нийтийн өргөдлийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын цахим системд гаргасныг 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 33,083 иргэн дэмжсэн бөгөөд уг нийтийн өргөдөлд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5.3 “тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах саналыг 33 мянга ба түүнээс дээш иргэн дэмжсэн бол Улсын Их Хурал авч хэлэлцэнэ” гэсэн шаардлагыг хангасан байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанд уг нийтийн өргөдлийг танилцуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэгт заасны дагуу холбогдох Байнгын хороонд хуваарилсан.

Өргөдлийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа “Эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах

тухай” нийтийн өргөдлийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийг баримтлан хэлэлцлээ.

Нийтийн өргөдлийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа эмч, багш нарын цалинг нэмэхийг дэмжиж, багш нарын цалин 3,5 сая төгрөг болох асуудал дээр Боловсролын сайд ямар байр суурь баримталж байгаа талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг сайжруулах, цалингийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх замаар цалин нэмэх боломжтой эсэх, Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч, эмнэлгийн ажилчид, туслах ажилчдын цалингийн хэмжээ хоорондоо хэр зөрүүтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах залуу багш, эмчийн цалин 1,5 сая төгрөг хүрэхгүй байгаа дээр Сангийн яам тооцоолол хийсэн эсэх, ажлаас гарч байгаа иргэдийн дунд залуу багш, эмч нар хэдэн хувь эзэлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн эмч, багш нарын цалин нэмэх эх үүсвэр байгаа эсэх талаар Сангийн яамнаас, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн урсгал зардлын хэмжээ 30 хувь байхаар баталсан бөгөөд энэ хүрээнд цалин нэмэх боломжийг 2026 оны улсын төсвийн төсөлд тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт 2023-2025 оны улсын хэлэлцээрт тусгасны дагуу жил бүр нэмэх боломжийн талаар тус тус асууж, хариулт авсан болно.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Лувсанжамц, Рэгдэл, Ганмаа, Номинчимэг нар тус нийтийн өргөдлийг дэмжиж үг хэлж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлж цаашид хамтарсан ажлын хэсэг байгуулж, бодлогын хувилбар боловсруулан асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа эрүүл мэндийн салбарт бодлогын шинэчлэл хийх хэрэгцээ шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Төсвийн орлогын эх үүсвэр нэмэгдүүлэхэд Засгийн газар санаачилгатай ажиллах, тухайлбал, төрийн өмчит компаниудын зардлыг 15 хувиар бууруулах ажлууд хийгдэхгүй байгаа талаар тус тус үг хэллээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын иргэн Б.Номингийн гаргасан “Эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай” нийтийн өргөдлийг хэлэлцээд дэмжих эсэх санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон нийт гишүүдийн 73,3 хувь буюу дийлэнх олонх нь дэмжиж, Төсвийн болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороотой хамтарсан ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулан бодлогын шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын иргэн Б.Номингийн гаргасан “Эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай” нийтийн өргөдлийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Асуулт, санал цуг явж байгаа шүү. Нийтийн өргөдөлтэй холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгээс асуулт

асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Галбадрах гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүний микрофон өгье.

А.Ариунзаяа: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Цалин хөлсний бодлого ер нь нэгдсэн бодлого байвал илүү үр дүнтэй, илүү ухаалаг явна л даа. Тэгэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам цалин хөлсний бодлогоо шинэчилж чадсан уу. Яамнаас хэн байгаа билээ. Сангийн яамнаас хэн байгаа билээ. Хүмүүс орж ирсэн байна уу, орж ирээгүй байна уу. Хэнээс асуулт асуух билээ. Санжаа байна уу. Харагдахгүй байна. Сайн байна уу Санжаа. Санжаа би асуулт асуугаадахъя. Энэ орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой.

2024 оны 4 сарын 1-ний өдрөөс хөдөөгийн сумд ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төв болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын үндсэн цалингийн 20 хувиар, уг нэмэгдлийг аймаг, сумын ИТХ орон нутгийн төсөвтөө тусган хөдөөгийн сумд 60 хүртэл хувиар, аймгийн төв болон алслагдсан 3 дүүрэгт 80 хүртэл хувиар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн ийм бодлого гарсан байгаа юм. Тэгэхээр 1 жилийн хугацаанд яг энэ бодлогын хэрэгжилт маань хэрхэн үр дүнгээ өгч байгаа вэ гэдэг дээр дүгнэлт хийх хэрэгцээ, шаардлага байна гэж харж байна. Үнэхээрийн орон нутагт шилдэг, мундаг боловсон хүчин очоод байна уу. Тэндээ үнэхээрийн хүмүүсээ тогтоон барьж чадаж байна уу, үгүй юү гээд үр дүнг нь харахгүй бол бид зүгээр л төвлөрсөн нийслэл болоод бусад өндөр ачаалалтай газраа цалинг нь нэмж чадахгүй, цалин хөлсний сан хүрэлцэхгүй. Гэтэл яг хөдөөгийн нэмэгдэл гэдэг агуулгаараа жоохон буруу яваад байгаа юм биш биз дээ. Энийгээ нэг эргэж харахгүй л бол болохгүй байна гэсэн ийм бодолтой байгаад байна.

Яах вэ магадгүй манай төсөв, эдийн засгийн нөхцөл байдал сайжраад ирэх юм бол энэ бодлогыг үргэлжлүүлж явуулж болно. Гагцхүү яг одоо үнэхээрийн хүнд нөхцөл байдалд орчихсон байгаа энэ цаг үед энэ бодлогоо эргэн хараад, нэмэгдэл авч байгаа хүмүүсээ хохироохгүй, магадгүй өнөөдрийн түвшнийг нь хадгалаад харин бусад нэмэгдэл авахгүй байгаа албан хаагчдын цалинг нь нэмэгдүүлэх ийм цалингийн эх үүсвэр бий болгох боломж гарах уу, үгүй юу гэдэг талаас нь л энэ бодлогоо эргэж харахгүй бол хэдүүлээ ердөөсөө л тийм шударга бус нөхцөл байдлыг үүсгэчихсэн нь өөрөө буруу юм. Тэгэхээр Сангийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам цалин хөлсний нэгдмэл бодлогоо гаргаж чадаж байна уу. Гаргах бодол байна уу, үгүй юу. Ер нь улс төрчдийн шахалт гэхээсээ илүүтэй яг л шинжлэх ухаанчаар хандаж, мэргэжлийн яам л бодлогоо чанга хэлмээр байгаа юм. Тэгээд энэ дээр ямар бодолтой байна вэ гэдгийг Сангийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас асууя.

Б.Найдалаа: Хариулт Санжаадорж дарга уу. 6 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Цалин хөлсний бодлого бол өөрөө Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бодлого байгаа. Тэндээс бол илүү нарийвчилсан хариулт өгөх нь зөв байх. Зүгээр яг саяын хэлсэн таны орон нутгийн нэмэгдэл хэрэгжиж эхэлснээс хойш бол манай дээр ирж байгаа өргөдөл, гомдол гэдэг юм уу, тэгээд цэвэр төсвийн агуулга талаас нь харах юм бол энэ бодлогыг бас бид нар засаж сайжруулах шаардлагатай байна гэж бидний хувьд бол дүгнэлт хийх гээд байгаа юм. Шалтгаан нь юу вэ гэхээр 1 дүгээрт жишээ нь харилцан хил залгаа аймгуудын хувьд жишээ болгож хэлэхэд бол Өмнөговь аймгийн хувьд нөгөө нэмж болох 100 хувийн

нэмэгдлээ бүгдийг нь нэмээд тавьчихаж байгаа юм. Тэгэнгүүт Дундговь аймгийн хувьд хараахан тийм боломж байхгүй байгаад байгаа учраас арай бага нэмчхэж байгаа юм. Тэгэхээр Дундговийн төрийн албан хаагчид нь илүү Өмнөговь руугаа ингээд татагдах ийм боломж гараад, санхүүгийн нөөц боломжоосоо шалтгаалаад хүнээ алдах ийм бодлого гараад байна гэдгийг бол аймгийн дарга нь бидэнд бас хэлж байгаа.

Төсөв талаас нь хараад үзэх юм бол энэ маань өөрөө яг сонгуулийн үеэр өмнөх жилээс хэрэгжээд эхэлчихсэн учраас яасан бэ гэхээр энэ өөрөө бас нөгөө санал авахад илүү чухал байсан гэдэг агуулгаараа ч гэдэг юм уу, зарим аймгууд энийг боломжоосоо илүү өндрөөр ашиглаад явчихсан аймгууд байна. Энэ аймгуудын хувьд бол одоо төсөв нь үндсэндээ бүхэлдээ бараг дийлэнх хэсэг нь цалин болчихсон. Үлдсэн жаахан хэсэг нь болохоор байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болчихсон. Өөрөөр хэлбэл тухайн аймгийн хувьд хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, бүтээн байгуулалт хийх ийм төсөв бас жишээ нь Орхон аймгийн хувьд жишээ нь энэ асуудлыг зогсоох гэж үзсэн байна лээ. Ингэнгүүт нөгөө тэр эсэргүүцлээ бол дийлж чадаагүй ийм асуудал бол болсон. Яг цалин хөлсний хувьд бид цалингийн нэгдсэн сангаас хараад үзэх юм бол Орхон, Дорноговь, дээрээс нь Дархан тэгээд Өмнөговь аймгийн хувьд энэ бол маш сайн хэрэгжээд хүмүүсийн цалин бол аягүй өндөр болчихсон юм байна лээ. Тийм бусад хэсэг дээрээ бага байна гэдгийг нь хараад байгаа юм.

Сүүлд нь хэлэх зүйл гэвэл бас бид нар анхаарах ёстой асуудал нь бол аймаг дээр ачаалал өгч байгаа байгууллагууд байна. Жишээ нь аймгийн Засаг даргын харьяа байгууллагууд гэхээр жишээ нь боловсрол, эрүүл мэнд гэдэг ч юм уу энэ байгууллагуудаасаа гадна жишээ нь шүүхийн байгууллага бол энэ дээр бас нэмж орж ирчхээд байна. Гэтэл шүүхийн байгууллага маань бол өөрөө тусдаа цалингийн сүлжээтэй, өөр өөрсдийн цалинг тогтоодог ийм байгууллага. Тэгэнгүүт шүүх дээр байгаа захиргааны албан тушаалтнууд нь бол бид нар бас энэ нэмэгдлийг орон нутгаасаа авах ёстой гээд шүүхэд өгчихдөг. Өөрөөр хэлбэл шүүхийнхэн аймгаа шүүхэд өгчихсөн. Ингээд тэр дээрээс ялаад гараад ирчхэж байгаа ийм тохиолдлууд гарч ирээд байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл босоо байгууллагууддаа улсын төсөв талаасаа босоогоосоо өгөх, хэвтээ байгууллагуудыг нь бол орон нутагт талаасаа өгөх, шүүхийн байгууллага буюу Улсын Их Хурал дээр Хууль зүйн байнгын хороо дээр цалин хөлсийг нь бүгдийг нь хэлэлцээд гаргадаг ийм байгууллагын хувьд бол тэндээ тусдаа ингэж төсвөө гаргачихъя гэдэг юм уу даа ийм байдлаар бас хэмжээ заагийг нь тогтоохгүй бол болохгүй байна л гэдэг ийм дүгнэлтүүд бол гарч ирээд байна.

Тэгэхээр 1 дүгээрт бол бүсчилсэн байдлаар бол тухайн бүсийн тэр дээд хэмжээг бид нар заавал харгалзан тогтоох хэрэгтэй байна.

2 дугаарт бол босоо, хэвтээ энэ төсвийн ялгаануудыг гаргаж ирэх хэрэгтэй байна.

3 дугаарт бол аль байгууллага хамаарах, хамаарахгүй вэ гэдгийгээ бас их зөв нарийвчлах шаардлагатай байна л гэсэн дүгнэлт хэлэх байна.

Б.Найдалаа: Нэмэлт тодруулах юм уу. Хөдөлмөрийн яамнаас хэн байгаа билээ. Хөдөлмөрийн яамнаас хүн байна уу. Тэгвэл тодруулга. Ариунзаяа гишүүний микрофон өгье.

А.Ариунзаяа: Санжаадорж даргын сая хэлсэн хариулт дотор сонгуультай холбоотой гэдэг үг гарчихлаа шүү. Тэгэхээр хэдүүлээ энэ дээрээ дараа нь нөгөө улс төрийн элдэв янзын асуудал тан дээр сайд чинь яриад байх вий дээ. Ер нь бол алдаатай бодлогууд нэлээд явсан. Ийм учраас үүнийг засах тал дээр хэдүүлээ явах нь зүйтэй. Гагцхүү одоо хүрсэн байгаа түвшнийг болино гэхээр хэцүү шүү дээ. Тэгэхээр одоо хүрсэн байгаа түвшнийг царцаагаад, бодлогоо засаад, бусдыг нь дүйцүүлэх, дөхүүлэх тал дээрээ л хэдүүлээ явахгүй л бол болохгүй юм гэдгийг би энд хэлэх гээд байгаа юм.

2 дахь нь болохоор нөгөө Эрүүл мэндийн даатгалын сан дангаараа эмч нарын цалин хөлс, урсгал зардлыг даагаад байгаа нь өөрөө буруу юм гэдгийг бас дахин .../минут дуусав/

Б.Найдалаа: Эрүүл мэндийн даатгалын сан, Эрүүл мэндийн яам. Цалин, урсгал зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас даагаад байгаа нь буруу гэж үзээд байгаа байхгүй юу. Тэр дээр ямар шийдвэр гаргах вэ, энэ дээр ямар шийдэлтэй байгаа вэ гэж байна. Хэн хариулах билээ. 4 номерын микрофон дээр яваад оччих.

Д.Отгонбаатар: Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалтын газрын дарга Отгонбаатар. Ерөнхийдөө Эрүүл мэндийн даатгалын сан дээр одоогоор бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан 700 оношны хамааралтай бүлгээр бол санхүүжилтийг аваад явж байгаа. Ер нь 2023, 2024 онд нэмэгдсэн цалингийн сантай холбогдолтой эх үүсвэрүүд яг тухайн жилийнхээ төсвийн нэмэгдлийн хүрээ дээр бол сууж ирсэн боловч зарим эх үүсвэр бас учир дутагдалтай байсан. Ер нь 2026 он дээр цалинтай холбогдолтой нэмэгдлийн асуудал дээр бол хэмнэлтийн болон бусад чиглэлийн түвшнүүдээр явна. Гэхдээ эх үүсвэрийг 181,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхгүй бол цалингийн нэмэгдлийг яг тэр хэмжээгээр бол даагаад гарах одоогоор боломж бол бүрэн харагдахгүй байгаа.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүний асуулт бол Эрүүл мэндийн даатгалын сангаас цалин өгсөөр байх юм уу. Энэ дээр өөрчлөх юм уу. Хэвээр нь явах юм уу гэж асуусан шүү. 6 хариулах юм уу. Хэн хариулах юм. Тодорхой асуултад тодорхой хариулаарай.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Эрүүл мэндийн даатгалын сан бол өөрөө гүйцэтгэлийн санхүүжилтээр явж байгаа. Энэ дээрээс бол өөрөөр хэлбэл ямар өвчний онош байна, ямар өвчнийг хэр чанартайгаар хийсэн байна, чанар нь шаардлагадаа нийцсэн бол санхүүжилтийг нь өгөөд явж байгаа. Хэрэвзээ Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын төрийн эмнэлгүүдийн цалинг өгөхгүй гэж үзэх юм бол цалин нь бол хуучин шатлал руугаа буюу гүйцэтгэлийн биш тогтмол цалин руугаа орж таарна. Тэгээд эрүүл мэндийн ажилчдыг бол төрийн албан хаагчдын яг нөгөө бүртгэсэн орон тоогоороо яваад, цалингийн санг нь хатуу хянаад явчихна. Тэгэхээр гүйцэтгэлийн санхүүжилт маань хаана орж ирэх вэ гэхээр эм, эмнэлгийн хэрэгслийн тэр асуудал дээрээ л орж ирнэ. Өмнө нь бол яг тэгж явж байсан. Хувийн эмнэлгүүдэд зөвхөн гүйцэтгэлээр нь даатгалаас санхүүжүүлж байгаа онош дээр явж байснаас биш, улсын эмнэлгүүд бол буцаад төсвийн байгууллага руугаа орох тийм зүйл рүү явах нь гэж хэлье.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулъя. Бас хариулт бүрхэг л байна.

А.Ариунзаяа: Эрүүл мэндийн даатгалын сангаас цалин хөлсийг нь өгөх нь буруу. Төр өөрийнхөө төрийн албан хаагчдынхаа цалинг даах ёстой. Одоо бол сан хоосроод, цалингаа хүртэл тавьж чадахгүй байгаа. Юун цалин нэмэх. Цалингаа өгч чадахгүй байгаад байгаа байхгүй юу даа эрүүл мэндийн салбарын хувьд. Тэгэхээр чинь энэ дээрээ энэ бодлогоо эргэж харахгүй бол болохгүй. Чинбүрэн сайд мэдэж байгаа шүү дээ. Засгийн газар энэ асуудлыг мэдэж байгаа. Тэгээд ийм төсөв оруулж ирчхээд, эргээд галыг нь Улсын Их Хурал руу ирүүлээд байгаа байхгүй юу даа. Цалин хөлсний бодлогоо ч гэсэн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд одоо яаж энэ төсөв дотор чинь ийм орон зай гаргах юм. Нийгэм бухимдалтай байгааг бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Анхнаасаа яах гэж ийм төсөв өргөн барьсан юм. Тэгээд одоо энийг чинь яах юм. Сангийн сайд, Сангийн яам хэвээрээ л байгаа шүү дээ. Та нар бүгдээрээ л байсан шүү дээ. Одоо гэнэт шинээр гарчихсан юм шиг байж болохгүй шүү дээ. Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга.../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Тодруулга дууссан. Тэгээд саяын асуултад хариулт хариулт аваад цаашаа явъя. Эрүүл мэндийн даатгалын сангаас саяын тэр цалин өгдгийг болиулах юм уу. Хэвээр нь явах юм уу гэдгийг асуусан даа уг нь. Тэр дээр хариулж өгөөч. 3 дугаар микрофон.

Д.Очирбат: Байнгын хорооны гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Тэгээд зарчмын, бодлогын том асуудлууд л даа. Яг л цалин хөлсний эрүүл мэндийн салбарт тулгамдаж байгаа яах аргагүй манай эмч нар, сувилагч нар, багш нарын цалин бол маш доогуур байгаа. Бид энэ цалингийнхаа бодлого дээр яг саяын 2 асуудал дээр бодлогын шийдэл дээр тасалж, хагалж өгөхгүй бол жишээ нь Эрүүл мэндийн даатгалын сан дээр гүйцэтгэлээр нь санхүүждэг санхүүжилт дээр эмч, багш нарынхаа цалинг, эмч нарынхаа цалинг, сувилагч нарынхаа цалинг нэмнэ гээд явчих юм бол бусад даатгалаараа санхүүждэг, гүйцэтгэлээр санхүүждэг тэр нөгөө санхүүжилт нь дундаа л өөрсдөө цалингаа тогтоогоод л нэмэх боломжийг аваад явчхаж байгаа юм. Тэгэхээр эмч нар, сувилагч нар бол яг л адилхан төрийн албан хаагч. Төрийн албан хаагчийг бол төрөөсөө цалинг нь нэмэгдүүлж, цалинтай нь холбогдолтой асуудлуудыг төр өөрөө хариуцдаг байх нь л зүйтэй гэж харж байгаа юм.

Б.Найдалаа: Энэ тэгвэл Эрүүл мэндийн яамнаас барьж байгаа, хийж байгаа ажил, бодлого гэж ойлгож болох нь зөв үү. Баярлалаа. Дараагийн гишүүн Батжаргал гишүү.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хөдөлмөрийн үнэлэмж, цалин хөлсний улсын нэгдсэн бодлогынхоо асуудлыг бид эргэж харахгүй бол болохгүй байх. Энэ асуудал ер нь нэлээн тийм ужгираад байгаа юм шиг байгаа юм. Цаг хугацаа бид алдаад байгаа юм шиг байгаа юм. Бид бүхэнтэй зэрэгцээд нэлээн бүтээмж өндөртэй, баялаг ахиутай, чадамжтай улс орнууд байгаад байна. Тийм учраас тэр лүү чиглэсэн урсгалууд татрахгүй байна.

Дээр нь энэ нийгмийн салбаруудыг либералчлаад байгаатай холбогдуулаад бас гайгүй бэлтгэгдсэн, төрийн зардлаар бэлтгэгдчихсэн боловсон хүчнүүд хувийн хэвшил тал руугаа шилжилт яваад болж өгөхгүй байна. Тэгэхээр ер нь энэ төрийн өмчлөлтэй нийгмийн үйлчилгээний салбаруудыг хэрхэн чадамжтай байлгах вэ гэдэг асуудал бидний нэлээн том бодлого болж гарч ирэх ёстой асуудал. Тийм учраас би эндээс байгуулагдах ажлын хэсэг ер нь зүгээр зөвхөн 2 салбарын цалин юмыг өсгөхтэй холбоотой биш, энэ асуудал руугаа хандсан иж бүрэн судалгаа,

тооцоолол, өөрсдийнхөө энэ чиглэлээрээ мэргэшсэн гэдэг юм уу боловсон хүчнүүд бүх юмнуудаа татаж тэр нийгмийн зөвшилцлийнхөө хүрээнд нэлээн томоохон судалгаа хийж, нэг том шинэчлэл хийх ёстой байх. Энэ тал руугаа ажилласан нь дээр байх гэж би ингэж ойлгоод байна.

Орон нутгийн нэмэгдлийн тухай хөнддөг юм. Хөндмөөр ч юм шиг. Гэхдээ Монгол Улс өөрөө өргөн уудам нутаг дэвсгэртэй. Энэ засаг захиргааны нэгжүүд, түүнийг дагасан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна гэвэл тэнд бид бас нэлээн боломж чадамжийг бий болгох ёстой. Энэ орон нутгийн нэмэгдэл бол энэ рүүгээ чиглэсэн, үүгээрээ дамжиж хэт төвлөрлийг чинь задалж чадаагүй юм гэхэд хэрэгжсэнээсээ хойш сааруулж чадсан бол хурдыг нь гэж ингэж ойлгоод байгаа. Үүнийг энэ удаагийн үйлдлээр аваад хаячхаж болохгүй. Бодлого тогтвортой байж байж үр дүн нь гардаг. Үүнийгээ нэг бодмоор байна.

Нөгөө талд хэт ачаалалтай газраа бид асуудлаа орхигдуулсан нь үнэн. Тийм учраас энэ ачаалалд дүйцүүлсэн нэмэгдэл зардлын асуудал байгаад байгаа юм. Энийг нь шийдэх ёстой. Харин энэ жилийн улсын төсөв Их Хуралд өргөн баригдаж орж ирэхдээ боловсролын салбар энэ тэр дээр бол хувьсах зардлаар дамжуулж, энэ ачааллыг тэнцвэржүүлэх гэдэг юм уу, эсвэл цалин хөлсөөр нь дамжуулж шийдэх шийдлийг хийж өгсөн юм билээ. Ингэснээрээ тийм зохистой баланс руугаа ойртох юм байна гэж нэг .../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут нэмж өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр манай эрүүл мэндийн салбарынхан, боловсролын салбарынхан ер нь энэ дээр ямархуу тооцоо, судалгаа хийгээд байгаа юм бэ. Тэр ачааллыг зохицуулалттай холбоотой хувьсах зардлаар дамжиж очих зардлаар ер нь тухайлсан хүн дээр ямар хэмжээний нэмэгдэл цалингийн асуудал яригдаж байгаа юм.

2 дугаарт 20 хувийн тухай, 15 хувийн тухай яриад эхэлсэн. Үүгээр дамжиж хэдий хэмжээний юм очих гээд байгаа юм. Энэ тоонуудаа тодорхой болгож ярих шаардлага байна. Энэ дээр ямар тооцоолол судалгаанууд хийгдээд байна вэ. Бас тодорхой мэдээлэл, тооцоолол юмнуудыг урьдчилсан байдлаар авч үзсэн харсан. Бас тодорхой хэмжээний ярьж хүлээгдээд байгаа энэ тоо юм руу ойртож болохоор тийм тооцоо судалгаанууд гараад байгаа юм байна гэж .../минут дуусав/

Б.Найдалаа: Хариулт Боловсролын яам болон Эрүүл мэндийн яамнаас бас л тодорхой асуулт байна. Наранбаяр сайдын микрофоныг нээе.

П.Наранбаяр: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнөөдөр боловсролын салбарт олгогдож байгаа үндсэн цалин болоод нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нэмэлтийнх нь харьцаа нь 50/50 болчихоод байгаа юм. 50 хувь нь үндсэн цалин, 50 хувь нь яг энэ үндсэн цалинтайгаа бараг тэнцэх хэмжээний ийм нэмэгдэл хөлс ингэж олгогддог. Тэгэхээр энэ нөхцөл байдал дээр бид бас судалгаа хийж үзээд, энэ бүтцийг нь бол бас яг үндсэн цалинд нь зарим нэгэн нэмэгдлийг бол шингээж, хялбаршуулах замаар амьдралын гол баталгаа болсон үндсэн цалинг нэмэх ийм шаардлага байна гэж харж байгаа.

Түүний зэрэгцээ өнөөдөр багш нарын үндсэн цалин хэдийгээр 1 сая 483 мянган төгрөг байгаа ч гэсэн улсын дунджаар нь энэ бол олговол зохих цалин буюу НДШ, татвар, хүн амын орлогын албан татвар эд нарыг тооцоогүй, татахаас нь өмнөх

одоогийн дундаж цалинг харах юм бол нийслэлд дунджаар 2 сая 592 мянга, аймгийн төв дээр 2 сая 757 мянга, сум дээр 2 сая 938 мянга гэсэн ийм дундаж цалин гарч ирж байгаа юм. Бид үндсэн цалинг нь 20 хувиар нэмэгдүүлэх ийм тооцоо хийж үзсэн. Энийг нэмэхэд бол нийслэл дээр дундаж цалин 3 сая 50 мянгад, аймгийн төв дээр 3 сая 261 мянгад, суман дээр бол 3 сая 482 мянгад тус тус хүрэхээр байна. Дахин хэлье. Энэ бол дундажласан цалин шүү. Зөвхөн үндсэн цалингийн хэмжээ биш. Эндээс бид бас энэ ачааллын нэмэгдлийг бол хувьсах зардлаар дамжуулан олгохоор 100 тэрбум төгрөгийг өнөөгийн өргөн барьсан төсөв дотор оруулсан байгаа. Энэ 1 ангид оногдож байгаа хүүхдийн тоо 40-өөс дээш, мөн ачаалал ихтэй сургуулиуд дээр очих ийм хувьсах зардал. Эндээсээ нэг хэсэг нь бол багшийн цалин хөлсөнд ордог. Энийг тооцоод, ачааллын нэмэгдлийг нь тооцоод үзэх юм бол нийслэл дээр бол 3 сая 469 мянга, аймгийн төв дээр 3 сая 484, сум дээр 3 сая 485 мянга гэсэн ийм дундаж цалингууд орж ирж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр бас Монголын үйлдвэрчний эвлэлийн багш, ажилтан, Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүдийн шаардаж, жагсаж хэлээд байгаа 3,5 сая төгрөгийн цалин бол бас энэ 2026 ондоо бид хэрвээ үндсэн цалинг нь нэмэгдүүлж чадаж, ачааллыг нь тэнцүүлсэн энэ нэмэгдлээ өгч чадах юм бол нийслэл дээр бол 3 сая 469 мянга болохоор байна гэсэн тооцоо гарч ирж байна. Энэ бол даруй ер нь цалинг 33,8 хувиар нэмж байгаа гэсэн үг. Аймгийн төв дээр бас нэмэгдэл нь орж нэмэгдэж байгаа хувь хэмжээ нь 26,4, суман дээр 18,6 хувь ингэж нэмэгдэнэ гэсэн ийм тооцооллыг бол бид хийсэн.

Тэгэхээр цаашдаа үндсэн цалинг бид ингээд нэмэх ийм бодлогоо бол тууштай барина. 3 жилийн төлөвлөгөөгөө бас оруулж хэлэлцүүлж, Засгийн газраас бас Улсын Их Хурал руу тогтоол хэлбэрээр оруулахаар ажиллаж байна. Гагцхүү хэрвээ үндсэн цалин манай багш нарын шаардаад байгаа шиг 3,5 сая руу хэрвээ орвол өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал хүнд байна л даа. Хэрвээ орох юм бол өнөөдрийн энэ 50/50 гэсэн энэ харьцаагаар бодох юм бол даруй 7 сая төгрөгийн ийм улсын дундаж цалин гарч ирнэ. Ингээд ирэх юм бол одоогоор эдийн засгийн нөхцөл байдал бол үүнд хүрэх боломж байхгүй. Бид зориод явах ёстой. Өнөөдөр чадлаараа нэмлээ гэхэд бид энэ үндсэн цалинг 20 хувь нэмж, бусад ачааллыг тэнцүүлснээр 33,8 хувийн .../минут дуусав/

Б.Найдалаа: Батжаргал гишүүн тодруулах уу. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Ийм тооцоолол юмнууд урьдчилсан байдлаар бас авч үзсэн юм. Тэгэхээр одоо бидэнд нэлээн сайн анхаарах ёстой зүйл бол дөнгөж сургууль төгсөөд хөдөлмөрийн гараандаа орж байгаа хүмүүсийн цалингийнхаа асуудлыг л бид бодох ёстой. Дээр нь энэ нийгмийн салбаруудаа бид үр дүн дээр суурилсан цалингийн тогтолцоо руу шилжүүлчихсэн. Тэрийгээ бид үр дүнгүй урамшуулал гэж яваад байгаа. Тэгэхээр энэ нэмэгдлийнхээ зөв балансын тухай ойлголт байгаад байгаа юм. Үүнийг хэрхэн зөв тогтоох талаар бодлого чиглэл, тооцоолол юмнууд хийж байгаа зүйлүүд байдаг юм уу. Салбар салбарын хуулиар энэ эрүүл мэндийн салбар, боловсролын салбарыг чинь бол үр дүнгийн үзүүлэлтээр суурилсан цалин хөлсний тогтолцооны систем рүү шилжүүлээд .../минут дуусав/

Б.Найдалаа: Нэмж хариулах уу Наранбаяр сайд. Наранбаяр сайдын микрофон.

П.Наранбаяр: Тэгэхээр Батжаргал гишүүнтэй санал 1 байна. Яг дөнгөж ажилдаа орж байгаа, тэгээд орон нутгийн нэмэгдэлгүй нийслэлд бол анхны ажлынх нь гараа нь эхэлж байгаа багшийн хувьд эхний 5 жилдээ бол үнэхээрийн үндсэн цалингаараа л явж байна шүү дээ. Тэгээд энэ бол үнэхээр өнөөдрийн амьдралын нөхцөл байдалд нь таарахгүй болоод байгааг бол хэн хүнгүй мэдэж байгаа юм. Зүгээр энэ гүйцэтгэлийн үнэлгээг бид сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль дахь багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд бол харахад сургуулийн өмнөх боловсролд бол 13,5 тэрбум төгрөг, нийт багшийн 48 хувьд нь очсон. Ерөнхий боловсролын багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хувьд бол 50,3 тэрбум төгрөг, нийт багшийн 52 хувьд бол олгож байгаа. Гэхдээ бид энэ гүйцэтгэлийн үнэлгээг үндсэн цалин руу нь зарим хэсгийг шингээх замаар илүү хүртээмжтэй болгох ёстой гэсэн ийм байр суурь барьж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Тодруулга болсон байна Батжаргал гишүүнээ.

Наранбаяр сайд аа, энэ чинь үндсэн цалин бага, нэмэгдэл гүйцэтгэлээ тооцох юм бол зарим нь өндөр авч байна гээд байгаа шүү дээ. Дундаж нь 6 сая гэж дуугарч байсан. Дундаж нь 3 сая гэж дуугарч байх юм. Хэрвээ төсвийг бага шиг нэмээд, гүйцэтгэлийнхээ үнэлгээг сайжруулаад, дотор нь гүйлгэчих юм бол бага шиг юугаар тэгшитгэх боломж бас байгаа юм биш үү. Тэрийг бас та бодохгүй юу. Бусад нь тэр 3,5 сая болоод тусдаа асуудал байх. Дараагийн гишүүн Найдалаа.

Энэ их чухал асуудал. Багш нараас одоо мессеж ирээд байна. Өнөөдөр бол ялангуяа олон ирж байна. Товчхон үг хэлье.

Асуудал нь юу вэ, алдаа нь юу юм бэ гэдэг дээрээ дүгнэлт заавал хийх ёстой бид нар. Энэ бол бодлогын алдаа. Засгийн газрын алдаа ер нь бол үе үеийн. Төлөвлөгөө дээрээ эмч, багш нар чухал гэсэн хэр нь цалинг нь нэмэх төсвийг тавьдаггүй, шийдвэр гаргадаггүй, бодлого байдаггүй. Сүх далайтал үхэр амар гээд үг байдаг. Яг тэр шиг ингэж ганхаж, гунхаж явсаар байгаад сүүлдээ багш, эмч нараа жагсахад хүргэчихэж байгаа юм. Тэгээд энийгээ хэдүүлээ зөвшөөрөх ёстой. Бодлогын алдаа. Ийм бодлого цаасан дээр байгаа боловч яг Монгол Улсад бодитойгоор эмч, багш нарын үнэлэмжийг нэмье гэсэн бодлого хүсэл байхгүй. Тэгээд шийдэл нь яг эндээс гарах ёстой юм.

Бас 1 анхааруулж хэлэх юм өмнөх олон хэлэлцүүлгээр гарч байсан. Сангийн яамнаас ч юм уу, ялангуяа төсөв боловсруулж байгаа хүмүүсээс албан тушаалтнуудаас инфляц, төсөв хүрэхгүй байна гэсэн юм ярьж байгаа. Ийм юмыг Улсын Их Хуралд ярихгүй. Яагаад гэвэл бодлого нь байх юм бол эх үүсвэрийг олж болно, зохицуулж болно. Инфляц чинь бол энэ цалингаас биш өөр юмнаас болж байгаа шүү яг үнэндээ бол гэх мэтчилэн түүгээр ам хаадгаа одоо болих хэрэгтэй.

Шийдэл нь юу байх вэ гэхээр 2 хүрээнд хармаар байна. 2 хүрээнд. Энийгээ ялгаж харахгүй бол бид нар холион бантан болгоод, тэгээд бүгдээрээ толгой эргээд, улс төрийн тэмцэл болгоод, аль ч үгүй дуусгаад байна.

1 дүгээрт одоо яг гал унтраах гэдэг юм уу, өнөөдөр ярьж байгаа сэдэв, гадаа жагсаж байгаа багш нар, эмч нар шаардлагууд. Энд тааруулаад яг ирэх 2026 оны төсөвтөө хаанаас олдог юм байгаа юм, яаж зохицуулаад нэмэх боломж юу байна. Боломжоор нь нэмэх ёстой. Тэгээд энэ бол бид нарын яг богино хугацааны өнөөдрийн, маргаашийн, ирэх 2 7 хоногийн ажил байх болно. Энийг бол 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар санал, дүгнэлтдээ тусгаад, төсвийн ажлын хэсэг

рүү өгөх ёстой байх гэж бодож байна. Энэ бол төсвийн асуудал яг одоохондоо бол энэ богино хугацааны асуудал.

2 дахь нь хамгийн чухал нь дараа жил, ирэх 5 жилийн дараа ямар байх юм бэ гэдгийг түрүүн би хэлсэн бодлогын алдаа хийснийг одоо бодлогын алдаагаа Засгийн газар засах ёстой. Энэ дээр манай 2 Байнгын хороо бас эрх зүйн орчин талаас нь, бодлого чиглэл талаас нь дэмжих ёстой. Тэр нь юу вэ гэхээр жишээлбэл Боловсролын яам 3 жил биш шүү, 5-7 жил, сонгуулийн циклд баригдмааргүй байна. Багшийн цалинг хэд болгох юм гээд тов тодорхой бодлого гаргаад, баталчихмаар байна. Тэгээд тэр лүүгээ анхаараад, тэрийгээ Засгийн газар нь, Их Хурал нь за бол ёогүй төсвөө баталж өгөөд, дор дороо өөр өөрсдийнхөө ажлыг хиймээр байна. Цалинг ярьж, 1 нь жагсаж, 1 нь хариуцсан болж ингэж хамаг асуудлаа, үр хүүхдийнхээ ирээдүйг алмааргүй байна. Энэ дээр тодорхой бодлого гаргах хэрэгтэй байна.

2 дахь нь энэ дотроо миний микрофоныг нэмж байгаарай. Эмч нарынх бас адилхан. Түрүүн асууж байна. Эмчийн цалинг тэр Эрүүл мэнд даатгалын сантай холбож уяад, тэр Эрүүл мэндийн даатгалын сандаа чирэгдүүлээд ингээд яваад байх юм уу, хаяад яваад байх юм уу. Тусад нь гаргах юм уу. Энэ дээр болон Эрүүл мэндийн даатгалын сангийн шинэчлэлийн талаар тодорхой бодлого төлөвлөгөө бас хэрэгтэй байна. Эрүүл мэндийн яамнаас. Энэ бол сан. Эмнэлэг биш, Эрүүл мэндийн даатгалын сан. Энэ сан сайн байж байж эрүүл мэндийн салбар босож ирнэ. Тэгэхээр энэ шинэчлэлийг хийхгүйгээр, саяын шийдлийг гаргахгүйгээр багш, эмч нарын цалинг нэмэх боломжгүй. Тэгэхээр бас яг адилхан. Хамгийн багадаа 5-7 жилийн хугацаатай ийм хөтөлбөр баталмаар байна. Тэгээд тэрийгээ л дээр дооргүй мөрдөөд, төсвөө маргаангүй тавимаар байна.

Дараагийн асуудал байгаа. Тэрийг жич дахиад ярина. Тэтгэвэр бас яг адилхан шүү дээ. Зарчим нь яг адилхан. Нийгмийн даатгалын санг шинэчлэхгүйгээр тэтгэвэр нэмэх тухай асуудал яриад, яриад нэмэргүй. Ийм бодлогын болон ойрын хугацааны 2 шийдэл байгаа. Энэ дээр анхаарч ажиллах юм шүү.

Наранбаяр сайдаас болон Чинбүрэн сайд байхгүй байгаа юу. Очирбат Төрийн дарга хариулах юм уу. Яг саяын тэр 2 асуудал дээр багш нарын цалин 3 биш, 3 гэж байхад чинь сонгуулийн цикл сонсогдоод байна. Тэгээд улс төрийн намаас үл хамаараад, Монгол төрийн бодлого байх ёстой шүү дээ. Энэ дээр хэн ч үгүйсгэхгүй. Тэгэхээр 3 бол богинодож байна. Тэгээд 3 бол худлаа. Энэ бол бодлого биш зүгээр аргацаасан төлөвлөгөө болно. Тэгэхээр хамгийн багадаа 5 жил, 7 жилийн хугацаатай эмч, багш нарын цалинг тэд болгоно гэсэн яг шийдвэр хэрэгтэй байна. Яг салбарын яамны хариуцах асуудал шүү дээ. Энэ бол Их Хурлын шийдэх асуудал биш байгаа байхгүй юу. Засгийн газар, салбарын яамд нь ажлаа хийгээгүйгээс болоод өнөөдөр ийм асуудалд орчхоод байгаа шүү. Тэгэхээр энэ дээр Боловсролын яам болон Эрүүл мэндийн яамнаас яг ямар төлөвлөгөө, бодлого гаргах гэж байгаа вэ. Энэ тодорхой байх юм бол тэрийгээ л хэдүүлээ тал талаасаа хянаад, хэрэгжүүлээд, төсвийг нь тавиад, жагсахгүйгээр дор дороо ажлаа хийгээд явцгаая. Энэ 2 яамнаас нь товчхон хариулж өгөөч. Энэ дээр олон юм хэрэггүй. Зүгээр яг тийм байгаа, байхгүй гээд. Наранбаяр сайдын микрофон.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр яг энэ цалингийн асуудлыг жил, жилдээ яриад, жил, жилдээ жагсаал цуглаан, хэлэлцээ, янз янзын ийм улс төрийн нөхцөл байдал руу оруулдаг өнөөгийн ийм богино хугацааны ой санамжтай ажилладаг энэ нөхцөл байдлаа л бид арилгах ёстой. Тантай бол 100 хувь санал 1 байна. Бид 3

жилийн төлөвлөгөө гэж боловсруулж явж байгаа. Нэгэнт Засгийн газраас бас 5 жилийн төлөвлөлтийг оруулж ирж байгаа учраас энэ дээр нь ингээд оруулаад явах боломжтой гэж харж байна.

Урт хугацаандаа төлөвлөөд хийх тусмаа алдаа бол багасна, савлалт багасна, улс төржилт багасна. Зөвхөн цалин ярьдаггүй, цалингаа, төлөвлөлтөө тогтоосон ёсоороо аль аль тал нь өөрийнхөө үүргийг гүйцэтгээд явбал бидний боловсролын яриа, хэлэлцээ, бусад бодлогын чиглэлүүд илүү өндөр түвшинд хүрнэ гэж харж байна. Бүх юмны суурь цалин болоод байгааг бол хүлээн зөвшөөрнө. Гэхдээ бид цалинг нэмэгдүүлэх ийм шаардлага байгааг бол шууд хүлээн зөвшөөрч байгаа. Энэ рүүгээ л бид чиглээд явах учиртай. Тэгэхээрээ таны хэлсэнчлэн бид бас 5 жилийн төлөвлөгөөнд цалинг өсгөж, энэ боловсролын салбарт залуу хүмүүс олноороо орж ирж багшлах, багш болох, сургуульд ажиллах ийм боломжийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж харж байна.

Тийм учраас бид бас энэ 3 жилийн төлөвлөлтөө арай жоохон илүү алсыг хараад, өөрсдийнхөө өнөөдөр Эдийн засаг, хөгжлийн яамнаас гаргаж ирж байгаа эдийн засгийн өсөлтийн өөрийнх нь бас төсөөллийг хараад, энд нь тааруулж цалингийн өсөлтийг бусад салбартайгаа уялдуулан тавих нь зүйтэй гэж харж байна. Бас үүнтэй зэрэгцээд эрх зүйн орчинд сайжруулах зүйл бол манай энэ Төрийн албаны тухай хууль байна гэж би боддог.

Төрийн албаны тухай хууль бол төрд зүтгэж яваа бүх хүнийг 1 хуулиар ингээд нэг дор оруулаад зохицуулчихсан ийм хууль байгаа. Тэгэхээр ингээд салбарын шинжтэй асуудлууд үүсээд ирэхээр энэ хуульдаа төрийн үйлчилгээний албанд байгаа бүхий л хүнийг хамруулах ийм шаардлага гараад ирдэг. Энэ бол бас 30 гаруй жил төрийн албаны хууль өөрөө үүргээ гүйцэтгэлээ. Одоо энэ хууль дээр зоригтой шинэчлэл оруулаад, нийтийн алба, яг одоо төрийн захиргааныхаа албанд зүтгэж яваа төрийн захиргааны алба эд нар гэж энэ дээр нь бас нөхцөл байдлуудыг авч байгаа шалгалт юмнууд нь шал өөр шүү дээ. Өөр өөрсдийн онцлог, мөн орон нутгийн хөгжилд өөрт нь таарсан орон нутгийн төрийн албан хаагчдыг ч гэсэн бас ингэж хуулиар орон нутгийн бие даасан байдалтай нь уялдуулж бас явах ийм шаардлага үүсэж байгаа юм болов уу гэж харж байгаа. Тэгэхээр энэ бол нэлээн том бодлого болно. Ингэж явах юм бол бид зөвхөн цалин ярьдаг биш, бас цаана нь байгаа өнөөдрийн эрх зүйн нөхцөл байдалтай уялдуулсан томоохон шинэчлэл хийж чадна гэж харж байна.

Х.Ганхуяг: 3 номерын микрофон өгье.

Д.Очирбат: Найдалаа даргын саналтай санал 1 байна. Салбарын хүний хувьд олон жилийн адаглаад 4, 5 жилийн хугацаатайгаар салбарын эмч, ажилчдын цалинг нэмэгдүүлээд, үе шаттайгаар төлөвлөгөө гаргаад хийгээд явах юм бол адаглаад боловсон хүчин, манай салбарын ажилтан, ажилчид маань дараа жилдээ болон 5 жилийн урт хугацааны зорилтдоо ийм цалингийн түвшинд хүрэх юм байна гээд итгэл үнэмшилтэй болно.

Сүүлийн 5 жилийн байдлаар эрүүл мэндийн салбарт бол Засгийн газрын тогтоолоор 2022 онд 107, 48 дугаар тогтоолоор 8-13 хувиар 2 удаа, 2023 онд 241 дүгээр тогтоолоор 1 удаа 45 хувиар, 2024 онд 238 дугаар тогтоолоор 6-20 хувиар 2 удаа, энэ жил бас 15 хувиар гээд 181 тэрбумаар жил, жил болгон тавиад өгчхөөд байгаа. Тэгэхээр энийг бол түрүүний хэлсэнчлэн урт хугацааны зорилтдоо төлөвлөгөө .../минут дуусав/

Х.Ганхуяг: Мөнхсайхан гишүүний микрофон өгье. та бүхэнд бүг

Т.Мөнхсайхан: Та бүхэнд бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Бид нар нийгмийн салбартаа анхаарна, 2026 оныг боловсролыг дэмжих жил болгож зарласан мөртөө ингээд эмч, багш нар маань бүгдээрээ талбай дээр гарчихсан зогсож байна. Ийм хэмжээнд хүртэл нь бид нар зовоож байна л даа. Тэгээд өнөөдөр арга ч үгүй байна. Сая үг хэлж байгаа гишүүд, Байнгын хорооны дарга, тэгээд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нь юмаа ойлгоогүй байна шүү дээ.

Бид нар зардлын зүйл ангиар нь санхүүждэг байсан энэ тогтолцооноос шилжиж, гүйцэтгэлийн санхүүжилт рүү орсон байхгүй юу. Ингэснээр маш олон давуу талуудыг бий болгосон. Өнөөдөр асуудал юунд байгаа юм гэхээр манай энэ эрүүл мэндийн салбарт зарцуулж байгаа санхүүжилт чинь хаанаа ч хүрэхгүй гэдгийг л тогтоогоод байгаа юм. Гүйцэтгэлийн санхүүжилтийг бид нар зохиогоод, манай улс зөвхөн хэрэглээд байгаа юм биш. Олон улсдаа нотлогдчихсон, манай улсад судалгаа нь хийгдээд, хамгийн зөв санхүүжилтийн тогтолцоо нь энэ мөн гээд энэ салбар луу энэ тогтолцоо руугаа шилжээд өнөөдөр бид нар нэг үеэ бодох юм бол амжилттай явж байгаа. Одоо харин энэ дээр яалт ч үгүй эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө хаанаа ч хүрэхгүй 90 хувь нь цалингийн зээлтэй яваад байгаа юм. Энэ бол энэ салбарын санхүүжилтийг нь бид нар нэмэгдүүлэх шаардлагатайг л харуулаад байгаа юм. Манай улс ДНБ-ий дөнгөж 3 хувьд хүрч байгаа Олон улс 6 хувьд хүрэхгүйгээр энэ санхүүжилт хаанаа ч хүрэхгүй эрүүл мэндийн салбарын чинь асуудал шийдэгдэхгүй гэдэг нь тогтоогдчихсон байхгүй юу. Тэгээд Сангийн яаманд энийгээ ойлгуулахаар Сангийн яам бас тодорхой хэмжээний санхүүжилтийг шийдэж өгөөд байдаг юм. Гэхдээ сүүлийн үед Сангийн сайд, Сангийн яамныхан ярьж байгаа бол хэчнээн төсөв мөнгө нэмж өгч байна. Та нар их үрэлгэн байна. Энэ бол хүрэхээр төсөв гэдэг энэ буруу ойлголтыг бас яриад байгаа юм шүү. Энэ чинь хүрэхгүй гэдэг нь бүх түвшиндээ тогтоогдоод, судлагдаад гараад ирчихсэн юм.

Тийм учраас өнөөдөр эрүүл мэндийн салбарт үүсэж байгаа санхүүгийн доголдол бол энэ тогтолцооны шинэчлэлийн үед гарах ёстой. Харин энэ бүх салбараас хамгийн түрүүлж гүйцэтгэлийн санхүүжилт рүү шилжсэн энэ эрүүл мэндийн салбарыгаа Сангийн яам маань сайн дэмжиж өгөх хэрэгтэй. Энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн доголдол юунаас үүссэн гэхээр 2022 оноос үүсээд эхлэлтэй шүү дээ. 2022 онд эмч, эмнэлгийн ажилчдын цалинг 30 хувь нэмнэ гэдэг энэ шийдвэрийг Засгийн газраас гаргачихсан. Тэгсэн мөртөө Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрөх мөнгийг нь энэ 30 хувийн нэмэгдлийг нь нэмж өгөөгүй. Эрүүл мэндийн байгууллагад, эмнэлгүүдэд өртгийн жинг нь тооцоолохдоо энэ нэмэгдлийг нь тооцож нэмээгүй. Үүнээс үүдэлтэйгээр эмнэлгүүд нь эм ханган нийлүүлэх байгууллагууддаа өрөнд ороод, эмч, эмнэлгийн ажилтныхаа цалинг нэмээд, ингээд маш их санхүүгийн доголдолд орчихсон. 1 минутаа нэмээд авчихъя.

Х.Ганхуяг: 1 минутаа нэмээд өгчихье.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр миний бас айж байгаа зүйл юу гэхээр 2026 онд ирэх оны төсөв дээр эрүүл мэндийн салбарынхны цалин мөнгийг 15 хувь хүртэл нэмэгдүүлнэ гэж байна. Энэ бол асуудлын бодит шийдэл биш ээ. Тийм учраас бид нар 2027 оны төсөв дээр ямар хэмжээнд ер нь нэмэх боломжтой юм. Үүнийхээ тооцоо судалгаануудыг сайн хийх хэрэгтэй. Энэ нэмж байгаа 15 хүртэлх хувийн нэмэгдлээ Эрүүл мэндийн даатгалын сан дээр бодит тоогоор нь нэмэгдүүлээрэй. Тэгэхгүй бол яг 2022 оны алдаа дахин давтагдаж, эрүүл мэндийн салбарынхны

цалин мөнгийг 15 хувиар нэмэгдүүллээ гэхээд даатгалын санд энэ хэмжээнийхээ мөнгийг төвлөрүүлэхгүй бол эмч, эмнэлгийн ажилчид өнөөдрийн байгаа байдлаасаа илүү хүнд байдалд орох гээд байгаа шүү. Тэгэхээр Сангийн яамныхан минь энэ дээр онцгой анхаараад, энийг яг бодитоор нэмэгдүүлж өгөөрэй.

Тэгээд 2027 онд эрүүл мэндийн салбарын эмч, ажилчдын цалинг ер нь хэдэн хувь нэмэгдүүлэх боломж байна. Энийг сангийн .../минут дуусав/

Х.Ганхуяг: Асуулт асуусан уу. 3 номер.

Д.Очирбат: Юунд нь хариулах билээ. 2026 оныхоо төсөвтөө 181 тэрбум төгрөгийг бид төсөлд тавьсан. Энэ дээрээ нэмж тавихаар төлөвлөж байгаа. Жишээлбэл, аймаг, орон нутгийн хэмжээнд эмч нартаа нийтдээ 36,589 эмч, ажилтан, албан хаагчид байна. Эндээс эмч 10 мянга, сувилагч 15, захиргааны ажилтан 1500, 181 тэрбум төгрөгийг тавьж байгаа. Тэгээд аймагтаа бол 39 тэрбум, бусад ЗООНОЗ-ын өвчин судлалын төв дээр 1 тэрбум жишээтэй. Нийслэлд 25 тэрбум, СЭМҮТ гээд бус уламжлалт ӨЭМТ-үүдээ бас нийлээд 41 тэрбум гээд нийтдээ 181 тэрбумыг тавьж байгаа. Цааш цаашдаа жил болгон түрүүний хэлсэн Засгийн газрын тогтоолоор 15-20 хувь, 30 хувьтай нэмэгдлийг жил жил болгондоо Засгийн газар өнөөдрийн энэ жишгээр бол нэмэгдүүлээд явах боломжтой л гэж харж байгаа.

Ер нь гүйцэтгэлийн санхүүжилтээр түрүүн бас дурдагдана лээ. Гүйцэтгэлийн санхүүжилтээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилт гэж энэ чинь хуульдаа өөр анх гүйцэтгэл эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дээр энийгээ дотор нь эрүүл мэндийн салбарын санхүүжилт дотроо цалинг нь ч, тусламж үйлчилгээг нь ч, тоног төхөөрөмж ч, барилга байшингийн засварыг нь ч бүгдийг нь нийтэд нь оруулчихаад байгаа юм. Тэгэхээр болж өгвөл жишээлбэл Засгийн газрын тогтоолоор нөгөө Улсын Их Хурлаар тусламж үйлчилгээндээ, төрийн үйлчилгээ, төрийн тусламж үйлчилгээ, төрийн захиргааны гээд ялгаж салгаад ингээд тогтоолоороо шийдэж өгдөг бол эмч нарынхаа цалин, сувилагч нарынхаа цалинг бүр тусад нь гүйцэтгэлийн санхүүжилтээс тусад нь санхүүжүүлбэл ямар вэ гэж түрүүн асуусан асуултад би бас хариулсан. Тэгэх юм бол манай гүйцэтгэлийн санхүүжилт дээр адаглаад цалингийн 181 тэрбум гэхэд л эрүүл мэндийн тусламж өөр чиглэл рүү зарцуулагдах боломж нь нээгдэж байгаа л гэж харж байгаа юм. Саналд нь түрүүн хариулсан байгаа.

Х.Ганхуяг: Мэдээлэл өгөхөд өнгөрсөн 7 хоногт Засгийн газартай Эдийн засгийн байнгын хорооны дарга миний бие, Мөнхтуяа гишүүн болон холбогдох Байнгын хороодын гишүүд Засгийн газартай уулзалт хийсэн. Үүн дээр ярилцсан зүйл юу байгаа вэ гэхээр тухайн салбарын сайд нар бол боловсролын салбар дээр нэмэлт санхүүжилтийн дүн ярьж байгаа шүү. 500 гаруй тэрбум төгрөг. Энэ бол цалингийн нэмэгдэл дээр гэсэн үг. Багш нарын цалингийн нэмэгдэл дээр. Эрүүл мэндийн салбар дээр 200 тэрбум төгрөг, тэтгэврийн сангийн нэмэгдэл дээр 100 гаруй тэрбум төгрөгийн асуудлыг ярьсан. Энэ 3 асуудлыг шийдчих юм бол бид нар багш нартайгаа, эмч нартайгаа тохиролцоо хийх боломжтой байна гээд асуудлыг ярьсан. Манай Төсвийн байнгын хорооны зүгээс эх үүсвэр нь юу байж болох вэ гээд судалж байна. Гэхдээ энэ хугацаанд уг нь манай энэ салбарын яамнууд нь 3 талт хэлэлцээрт ормоор байгаа юм. Тэгэхгүй бол бид нар энэ чинь баахан ажил болдог. Тэгэнгүүт нь тэр нь болж байна, болохгүй байна, эсвэл тийм асуудал нь болж байна, болохгүй байна гээд ерөөсөө мэдээлэл байхгүй болчихоод байна. Тийм учраас Боловсролын яам багш нартайгаа, Үйлдвэрчний эвлэлтэй 3 талын хэлэлцээрт

ормоор байна. Эрүүл мэндийн яам мөн ялгаагүй. Нийгэм хамгааллын яам мөн ялгаагүй.

Тэгээд уг нь энэ 7 хоногоос бид нар Төсвийн байнгын хороо дээрээ ажлын хэсэг байгуулах, энэ төсвийн ирж байгаа саналуудаа хэлэлцээд явах ийм тов дараалалд санал хураагаад дэмжигдээд орсон байсан. Тэгээд өнөөдөр ингээд Улсын Их Хурлын Тамгын газраас манай Байнгын хорооны хуралдааныг дутуу хэвлэсэн үү, алдаа гарсан уу ингээд оруулаагүй байна. Тэгээд үүнээс болоод жишээ нь бид нар төсөв хэлэлцэх хугацаа ингээд дахиад л 7 хоногоор хойшилж байна. Энэ Их Хурлын Тамгын газар Их Хурлынхаа дээр байхаа болимоор байна. Дээр гар суучхаад л дэгийн хууль зөрчүүлээд, ер нь цэр нь цээжиндээ, бөөр нь бөгсөндөө баймаар байна шүү. Үг хэлчихлээ.

Мөнхсайхан гишүүн нэмэлт 1 минут.

Т.Мөнхсайхан: Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн та энэ санхүүжилтийнхээ тогтолцоо юмыг ойлгоогүй. Хэзээ Эрүүл мэндийн даатгалын сангаас засвар үйлчилгээний зардал гардаг болчхов. Тийм зардал хэзээ ч гардаггүй. Цалин мөнгө, урамшууллыг бид нар энэ нийт өртгийн жин дээрээ тооцоолоод эмч, эмнэлгийн ажилчдад цалин мөнгөө өгдөг юм шүү дээ. Энэ чинь бүтээмжтэй нь уялдуулж цалин мөнгөө өгч байж, авч байгаа эмч, эмнэлгийн ажилтанд ч сэтгэл хангалуун, үйлчлүүлж байгаа хүмүүстээ ч сайн тусламж үйлчилгээгээ хүрдэг, аль аль талдаа өгөөжтэй ийм тогтолцоо шүү дээ. Хэзээ ч эндээс тэгж засвар, үйлчилгээний мөнгө Эрүүл мэндийн даатгалын сангаас гардаггүй шүү дээ. 2021 оноос өмнө бид нар зардлын зүйл ангиар нь санхүүжүүлдэг байхад эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө тогтмол, тэрийг төрийн сангаас даадаг тийм тогтолцоо байсан шүү дээ энэ чинь. Энэ тогтолцооны шинэчлэл ойлгоогүй. Тэгээд яаж та цалин мөнгө нэмэх гээд байгаа юм. Тэрийг ерөөсөө ойлгохгүй байна.

Х.Ганхуяг: Ажлын хэсгийн 3 номер өрхийн.

Д.Очирбат: Эрүүл мэндийн байгууллагууд манайх анхан шатандаа өрхийн эрүүл мэндийн байгууллагууд байна. Энэ өрхийн эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэлийн санхүүжилт 1 иргэний гүйцэтгэлийн санхүүжилтээр цалин, гүйцэтгэл санхүүжилтээ авч байгаа. Сайн ажиллаж байгаа ч өрхийн эрүүл мэндийн байгууллагууд байна. Мөн сахилга бат, санхүүгийн зөрчил гаргаж байгаа ч анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд байдаг. Өнгөрсөн жил гэхэд гүйцэтгэлийн санхүүжилтээр 1 иргэний санхүүжилтээр санхүүжигдээд, тэр давсан орлогодоо он давж давсан орлогодоо 500 саяын орлоготой ч байсан өрхийн эрүүл мэндийн байгууллагууд байсан. Тэр болгон дээр Эрүүл мэндийн яамнаас тэр хөрөнгө оруулалтаас, тэр төсөв хөтөлбөрөөс өрхийн эрүүл мэндийн байгууллага, энэ олон байгууллага, 4 мянга гаруй нийт салбаруудынхаа хэмжээнд санхүүжилтийг өгч чадахгүй. Гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаа санхүүжилтдээ хуримтлал үүсгэх юм бол тэндээсээ цалингийнхаа нэмэгдэл, хүмүүсийнхээ нийгмийн урамшууллын асуудлыг дотооддоо бас машин тэрэг .../минут дуусав/

Х.Ганхуяг: Зулпхар гишүүний микрофон өгье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийнхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Их тодорхой асуултууд байна. Боловсролын сайдаас. Өнгөрсөн хугацаанд Боловсролын сайд бас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдтэй ажил хэргийн уулзалт хийх явцдаа бол энэ цалин хөлсний бодлоготой холбоотой бас дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн юм. Тэгээд тооцооллуудаа эхнээс нь хийгээд явж байгаа гээд. Өнөөдөр бас эхний мэдээллүүдийг бидэнд өгч байна. Ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн ажлын хүрээнд. Ингээд цалинг 20 хувиар багш нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотой тооцооллууд гарч байгаа юм байна. Та энийг бас бидэнд ахиад дэлгэрэнгүй хэлж өгөөч гэж байгаа юм. Нийслэл, аймгийн төв, сумд чинь энэ бас ялгаатай байгаад байгаа шүү дээ. Угаасаа энэ чинь анхнаасаа бодлого нь тэгээд явчихсан. Бүсчилсэн хөгжлийн зорилготой уялдуулаад. Одоо саяын тооцооллоор та бүхний танилцуулж байгаагаар хэрвээ ингээд цалин нэмэх юм бол нийслэлийн багш нарын үндсэн цалин 2 сая 592 мянга байгаа нь хэд болох юм бэ. Үүнээс гадна бид нэмэгдэл гэж ярьдаг. Цаашлаад бол ачааллын нэмэгдэл ч гэж зарим талаар авч үздэг. Үүнтэй уялдуулах юм бол хэд болох юм бэ. Нийслэлд, аймгийн төв дээр хэд болох юм. Сум дээр хэд болох юм гэдэг эхний асуулт байгаа юм. Энийг та их дэлгэрэнгүй хариулаад өгөөч. Багш нар энийг л хүлээж байх шиг байна.

2 дахь зүйл энэ гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой, үүнтэй уялдсан байдлаар нэмэгдэл цалин дээр бас цалин хөлсний бас ийм нэмэгдлүүд явдаг. Тэгэхээр үүний учир шалтгааныг ерөөсөө бид нэг л сайн ярихгүй байгаад байна. Энэ багшийн хувьд багшийн хөгжилд хэр нөлөөлөх ийм үнэлгээ юм бэ. 1 дүгээрт.

2 дугаарт боловсролын чанарыг дээшлүүлэхтэй уялдсан зорилттой хэр уялдсан ийм үнэлгээ юм бэ гэдгийг бас хэлээд өгөөч гэж байгаа юм. Цаашдаа энэ байх ёстой юм уу, үгүй юм уу гэсэн эргэлзээ төрөөд. Мэддэг хүмүүс болохоор зэрэг энэ гарцаа байхгүй чухал гэж хэлээд байдаг. Энэ Их Хуралд сууж байгаа бидний хувьд бол ямар ч нөхцөлд тодорхой салбарт гүйцэтгэлийн үнэлгээ бол байж байж, тухайн салбарын үйл ажиллагааны чанар сайжирдаг гэдэг ийм ойлголттой. Үүнтэй уялдсан байдлаар яам өөрөө энийгээ хэрхэн ойлгож, хэрхэн авч үзэж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна.

3 дахь зүйл энэ орон нутгийн нэмэгдэл, ялангуяа жишээ нь сургуулиуд дээр шүү дээ. Та бол асуудлаа маш нарийн мэдэж байгаа хүний хувьд орон нутгийн нэмэгдлүүдийг өгсөн. Сумд 40 хувь, аймгийн төв дээр 20 хувь гэж. Сая бас гишүүд асууж байна. Үүний үр дүн гарсан эсэхийг бас та бүхэн бидэнд тайлбарлаач. Санжаа сайн мэдэж байгаа. Анхнаасаа энийг гарна гэж бид нар энэ тооцооллыг хийсэн. Үр дүн гараад явж байгаа гэдэг тодорхой мэдээлэл байгаа. Энийг та бүхэн хэлээч. Тэгэхгүй бол энийг байхгүй болгох юм шиг бас ийм зарим нэг асуудал яригдаж байна. Ийм байж болохгүй шүү дээ. Өчигдөр бодлого нь зөв байгаад, өнөөдөр буруу болчихсон юм шиг ийм залгамж чанаргүй бодлогогүй төр юм шиг байж ерөөсөө болохгүй байх. Энийг бас тайлбарлаж өгөөч. Баярлалаа.

Б.Найдалаа: Хариулт Боловсролын сайд Наранбаяр.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр эхний 2 асуултад би хариулаад явъя. 3 дахь дээр манай Батжаргал бэлдэж байгаад яг орон нутгийн нэмэгдэл дээр чухам яг тоон үзүүлэлтээс нь харахад ямар дэвшил гарч байгааг хэлж өгөөрэй. Тэгэхээр өнөөдөр яг үндсэн цалин бол 1 сая 483 мянгаас эхэлж байгаа. Улсын одоогийн дундаж цалингаар нь авчихъя. Энэ нөгөө өнөөдөр цалингийн бүтэц бол 50 хувь нь үндсэн цалин, үлдсэн 50 хувь нь бол нэмэгдэл хөлс байгаа. Тэгэхээр энэ цалингийн бүтэц бол өөрөө нэлээн тийм савлалттай болсон нь бол өнөөгийн бас хүндрэлтэй

нөхцөл байдлыг үүсгээд байгааг бол хаана хаанаа хүлээн зөвшөөрч байгаа. Бид бас МҮЭ, БШУ-ны эвлэлтэй ярилцахад бас цалингийн бүтэц дээр өөрчлөлт хийх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Тэгээд одоогийн дундаж цалин нийслэл дээр бол 2 сая 592 мянган төгрөг байна. Аймгийн төв дээр 2 сая 757 мянган төгрөг байна. Сум дээр 2 сая 38 мянган төгрөг байна. Энэ дундаж цалинг нь хэлж байгаа. Энэ нь НДШ, хүн амын орлогын албан татвар татахаас өмнөх олговол зохих энэ дундаж цалин. Бид 20 хувь нэмэгдүүлсэн тохиолдолд нийслэл дээр 3 сая 50 мянган төгрөг болж өснө. Аймгийн төв дээр 3 сая 261 мянга, суман дээр 3 сая 482 мянган төгрөг болж өсөхөөр харагдаж байна. Мөн ачааллын нэмэгдлийг тооцож бид оруулж байгаа. Түрүүнд уучлаарай би 40-өөс дээш дүүргэлттэй бүлэг гэж ярьсан нь 35-аас дээш дүүргэлттэй бүлэг дээр бид тооцож үзсэн. Энэ үндсэн цалинг нь 20 хувь нэмээд, тэгээд ачааллын нэмэгдлийг бас оруулаад тооцох юм бол энэ нь бол хувьсах зардлаар дамжуулаад, 100 тэрбум төгрөгийг төсвийн өнөөгийн өргөн барьсан төсөв дотор бол шингээсэн байгаа. Энийг тооцоод үзэх юм бол нийслэл дээр 3 сая 469 мянган төгрөгийн дундаж цалинтай болох нь. Өнөөдөр багш нарын шаардаад байгаа 3,5 сая төгрөг рүү бол бараг дөхөж очно. Нийтдээ 33,8 хувийн нэмэгдэл болж байгаа. Аймгийн төв дээр 3 сая 484 мянга. Арай жоохон илүү. Энэ дээр орон нутгийн нэмэгдэл нь бас үйлчлээд байна гэсэн үг. Суман дээр 3 сая 485 мянган төгрөг болж, ингээд аймгийн төв дээр 26,4, сумын төв дээр 18,6 гэсэн ийм байдлаар нэмэгдэхээр бас тооцооллыг гаргасан. Зүгээр бид бас үндсэн цалин гэдэг энэ зүйл дээр бас ойлгох хэрэгтэй нь бол цаашдаа энэ харьцааг үе шаттайгаар үндсэн цалинг нь эзлэх хувь хэмжээг нь нэмж, нэмэгдэл нь бол өөрөө арай бага байхаар тооцохгүй бол үндсэн цалин өөрөө амьжиргааны шууд баталгаа болж чадахгүй. Цалингийн бүтэц өөрөө их нарийн төвөгтэй ийм болоод байгаа ю.

Гүйцэтгэлийн үнэлгээ бол би 2 талынх нь багш нартай бол уулзаж л байсан. 1 нь бол авч чадаагүй хэсэг нь бол шударга бус байна гэж үздэг, эсвэл шударга бусаар үнэлүүлсэн гэж үзсэн хүмүүс нь бол тийм үзэл бодолтой, нөгөө тал нь бол стандарт сургалтаа сайн хийж байгаад, энэ чинь нөгөө багшаас нь ч, сурагчаас нь ч, байгууллагаас нь ч үнэлгээ аваад явчхаж байгаа учраас энэ дээр нь бол түүврийн аргаар ингээд явчхаж байгаа учраас энэ дээр бас урам өгч байна, ажиллах урам зоригийг өгч байна. Бас энэ багш нарын дунд бол энэ илүү сайн ажиллая гэсэн урам зоригийг, илүү сайн ажиллая гэсэн инсентив юм өгч байна гэсэн ийм бас үнэлгээ байдаг. Одоо жишээлбэл энэ жилийн байдлаар гэхэд бол бид ерөнхий боловсролын сургуульд нийт багш нарын бол 50 гаруй хувийг нь 52 хувийг нь гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд хамруулж чадсан байна. Гэхдээ энэ үнэлгээг нь бид цаашдаа үргэлжлүүлэхдээ илүү шударга болгох, түүний зэрэгцээ үндсэн цалин зарим хэсэгт .../минут дуусав/

Б.Найдалаа: Хариулт хэнээс асуусан бэ. Микрофон 2.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Боловсролын яам Батжаргал. Орон нутгийн нэмэгдлийн тухайд 2024 оноос хойш гарсан үр дүнг нь зүгээр статистик дээр аваад үзэхэд орон нутгийн нэмэгдэл өгснөөс хойш бол багшийн хомсдол тодорхой хэмжээнд шилжилт, динамикууд өөрчлөлтүүд бол гарсан байдаг. Багшийн хомсдол улсын хэмжээнд бол 10 орчим хувь буюу 9,9 хувьтай байгаагаас нийслэлд 13,6 хувь, сум, орон нутагт бол 6,6 хувь байгаа нь бол энэ хомсдолын зөрүү бол арилсан байгаа. Гэсэн хэдий ч гэсэн багшийн хомсдол ялангуяа байгалийн ухааны чиглэл дээрээ бол хомсдол байгаа ч гэсэн ажлаас гардаг, хөдөлмөрийн зах зээл дээр өөр ажил руу шилжих энэ процесс бол үндсэндээ тодорхой хэмжээ, нэлээн үлэмж хэмжээгээр саарсан гэж ийм дүгнэлт бол харагдаж байгаа.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн нэмэх үү.

П.Наранбаяр: Наранбаяр сайд аа, их тодорхой мэдээлэл бид нар ярьчихлаа. Энэ хэвлэлээр ч гэсэн явах байх. Нийслэлд багш нарын цалин энэ нэмэгдэлтэй уялдсан байдлаар 33,8 хувь нэмэгдэх нь гэж ойлголоо. Аймгийн төвүүд дээр бол 26,4 хувиар нэмэгдэх нь үндсэндээ бол. Тэгэхээр энэ бол ямар нэгэн байдлаар энэ зүйлээ та бүхэн үйлдвэрчний эвлэлтэй нь ярих ёстой юм байна. Саяын бас Байнгын хорооны дарга хэлж байна. Энэ 3 талт хэлэлцээр лүүгээ ороход л энийгээ та бүхэн ярилцах ёстой юм байна шүү.

Дараагийн зүйл бол та бүхэн үндсэн цалингаа нэмэгдүүлнэ гэж байна. Энэ зөв. Тэгж байж тэр амьжиргаатай уялдсан байдлаар энийг бас та бүхэн олон нийтэд багш нарт бас мэдээлэх ёстой шүү.

3 дахь зүйл бол тэр гүйцэтгэл бол байсаар байх юм байна. Харин аргачлалыг нь сайжруулах юм байна. Боловсронгуй болгох юм байна. Энийгээ бас та бүхэн ярьж байж багш нартаа, олон нийтдээ энийг ойлгуулаад явахгүй бол болохгүй юм байна шүү. Тэгээд энийгээ та бүхэн цаашаа яриач ээ гэж байгаа юм.

Сүүлд нь бол мэдээж хэрэг орон нутгийн нэмэгдлийг бол үр дүнгээ өгч байгаа гэдгийг зарим зүйл нотолж байна. Зарим зүйл харуулж байна. Гэхдээ .../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут тодруулъя. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Гэхдээ энэ зөвхөн орон нутгийн нэмэгдлээс гадна урьд нь хэрэгжүүлж байсан Санжаа дарга бол сайн мэдэж байгаа. Энэ дээр юу гэхээр төрийн албан хаагчдын чинь ажилласан жилийн нэмэгдлийг жил болгоноор олгодог болгосон шүү дээ. Хуучин 5 жил хүлээж байгаад 5 жилийн дараа олгодог байсан. Энэ ч гэсэн төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах бас 1 нөхцөлийг хангахад чиглэсэн шинэчлэл байсан. Төрийн албан хаагчдын цалин хөлсний бодлого нэг талаар нэгдмэл, нөгөө талаар салбарын онцлогтой байгаа шүү дээ. Тэгэхээр энэ үүднээс энэ зүйлээ бас та бүхэн энэ хэлэлцээрүүд дээрээ яриад, цаашдаа магадгүй болж байгаагаа яриад, болохгүй байгаа зүйлээ нарийн хэлэлцэж байж энэ зүйлээ олон нийт болон багш нарын дунд хэлэлцүүлэгт оруулмаар байна гэж байгаа юм. Тэгэхгүй бол ерөөсөө ингээд Их Хурал дээр авчраад бүх юмаа шийдэх ёстой гэсэн шийдэл байгаа боловч нөгөө талдаа яг бодлогоо барьсан яам дээр бодлого нь гарчихсан явж байхад тэрийгээ ярихгүй яваад байгаагаас болсон ийм зөрүүтэй ойлголтууд явж байна шүү гэдгийг хэлье. Ингээд та бүхэн энэ дээр их идэвхтэй ажилламаар байна. Өнөө маргааш гэхэд бол энийг олон нийттэйгээ яримаар байна гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Зулпхар гишүүний санал яг зөв шүү. Бүх асуудал шийдэгдэхгүй байсаар байгаад Засгийн түвшинд салбарын яамд нь шийдэхгүй байсаар байгаад ужгируулаад, тэгээд Их Хурал руу шийдчихдэг. Их Хурал бол тэрийг шийддэг газар биш шүү дээ. Дараагийн гишүүн Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ өнөөдөр маш чухал асуудлыг ярьж байна л даа. Эмч, багш нар цалин нэмэх тэтгэвэр, тэтгэмж нэмэх талаар заавал жагсаал хийлгэж байж 15-20 хувь нэмэх юм. Түрүүн Сангийн сайд чинь боломж байхгүй гэсэн шүү дээ. Энэ 15-20 хувь чинь ч хангалтгүй. Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хүмүүсийг хар. Багш нарыг хар. Багш нараас илүү эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хүмүүс

чинь шөнө нойр, хоолоо хасаад ажиллаж байгаа шүү дээ. Жижүүрт тулган гарч байгаа. Асрагч, сувилагчгүй болсон. Эмч нар бас дутагдалтай байгаа. Тэгээд Эрүүл мэндийн яамныхан тэгээд алсын бодлогын 15, 20 хувь нэмнэ гээд хуураад яах вэ дээ. Сая сайд урьд нь бас тэгдэг байсан. Сая ойлгосон байна шүү дээ. Буусны дараа ойлгож байгаа шүү дээ энэ асуудлыг. Эмч, багш нарын цалинг үнэхээр нэмэх шаардлагатай. Тэтгэврийн хөгшчүүд 600 мянган төгрөгөөр яаж амьдрах вэ. Энэ дотроос эрүүл мэндийн салбарыг авч үзье. Бензин, шатахууны үнэ, халаалтын үнэ, цэвэр, бохир ус, цахилгааны үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ бүгд нэмэгдсэн. Их л бол 150-200 мянга л нэмэгдэх юм байна. Дээд хэмжээ нь сард. Сүүг хараарай. 1 литр сүү чинь 4600 шүү дээ. Тэгээд өдөрт 1 литр сүү авлаа гэхэд тэгээд бодоод үз л дээ. Бусад юмаа яаж нөхөх юм. Үнэхээр нөхцөл нь хүнд. Шээс, баас, цус нөжтэй ажилладаг. Үндсэн цалингийн сүлжээг 1 дахин нэмэхгүй бол ядахдаа 50 хувь нэммээр юм ерөөсөө. Арай л энэ эрүүл мэндийн байгууллагынхан энэрэнгүй учраас энэ жагсаалд гарахгүй байна л даа. Багш нар шөнө унтаж байгаа шүү дээ. Эмнэлгийн салбарынхан унтахгүй жижүүрт гарч байгаа шүү дээ. Эрүүл мэндийн салбарт анхан шатнаас ажилласны хувьд би сайн мэдэж байгаа. Гэртээ ч хонохгүй, хөдөөгийнхөн дуудлагад явж байгаа байхгүй юу. Дуудлагад явж ирчхээд дахиж хүн үзээд, эмчилгээ хийж байгаа юм. Энийг ерөөсөө энд анхаараад нэмэхгүй бол болохгүй нь ээ Сангийн яамныхан минь. Одоо эмнэлгийн дарга нарын цалин 1 сая 805 мянга байна шүү дээ. Үндсэн цалин. Шил угаагч гэхэд хамгийн бохир, шээс, цус бүгдийг нь угаадаг хүнийх нь 1 сая 166 мянга байна шүү дээ. Юунд ч хүрэхгүй шүү дээ энэ чинь. Арай ч дээ эрүүл мэндийн салбарыг онцгой анхаарахгүй байна. Боловсролын салбар 2-ыг.

Дээр нь эм эмнэлгийн хэрэгсэл нь байхгүй, дутагдалтай, хэвтэж байгаа өвчтөнүүд гаднаас эм авчирдаг. Эрүүл мэндийн салбарын төсвийг нэммээр юм байна. Үндэсний аюулгүй байдалтай ч холбоотой асуудлууд байна. Боломж байгаа мөртөө яагаад нэмэхгүй байна. Олон хулгайны мөнгийг бид нар харж байна шүү дээ. Өчнөөн тэрбум өчнөөн их наядаар нь .../минут дуусав/

Б.Найдалаа: Сангийн яамнаас. Сангийн сайд байхгүй байсан юм уу гишүүд асуугаад байна. Микрофон 5.

Ж.Ганбат: 2026 оны төсвийн төслийг Засгийн газар боловсруулан Улсын Их Хуралд хуулийнхаа хугацаанд бол өргөн мэдүүлсэн. Энэ өргөн барьсан төсөв дээр бол тэтгэврийн 6 хувиар нэмээд, цалин нэмэгдэхгүй байхаар төсвийн төслийг өргөн барьсан. Тэгээд өнгөрсөн 7 хоногт сая Төсвийн байнгын хорооны дарга Ганхуяг гишүүн ярилаа. Засгийн газрын тэргүүн, Байнгын хороодын дарга нар, зарим гишүүд энэ тэр уулзалдсан. Энэ хүрээнд бол багш нар, эмч нарын асуудлыг бас хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг талаар бол санал солилцсон байгаа. Тэгээд энэ солилцсон хүрээндээ бол 15-20 хувиар боловсрол, эрүүл мэндийн багш, эмч нарын цалинг нэмэгдүүлье. Үүнтэй холбоотой холбогдох эх үүсвэрийн тооцооллыг Сангийн яам хийж өг гэдэг үүрэг бол өгөгдсөн байгаа. Энэ дагуу бол Сангийн яам тооцооллыг бол хийж байгаа. Тэр тооцооллыг нь гаргаад ирэхээр бид бол төсөв дээр нэгэнт Улсын Их Хуралд өргөн барьчихсан, бид орлого нэмэгдүүлэхэд бол хүндрэлтэй нөхцөл байдал бас тийм амаргүй байгаа болохоор Улсын Их Хурал дээр өргөн барьсан төсвийнхөө хүрээнд л бид нар зардлыг 1 зардлаас бууруулж, нөгөө зардлаа нэмэгдүүлэх байдлаар бол тооцоог хийж байгаа. Тэнд тооцоог нь гаргахаар Төсвийн байнгын хороо болон холбогдох ажлын хэсгийн тооцооллыг бол танилцуулах ийм чиглэл дээр ажиллаж байна.

Б.Найдалаа: Бейсен гишүүн тодруулна.

Б.Бейсен: Энэ төсвийн асуудал дээр би бас саналаа урьд нь ярьж байсан. Эмнэлгийн бүтэц орон тоогоо шинэчил. Сонгууль болгон дээр орон тоо нэмсээр байгаад ингээд нэмэгдсэн. Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн салбар, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам гурвуулаа нийлж байгаад эмнэлгийн бүтэц орон тоог батал. Жишээлбэл 50 ортой эмнэлэг дээр чинь 8 эмч ажиллаж байна. 1 эмчийн бүтэц орон тоо гээд байдаг. Анагаахын шинжлэх ухаан үндэсний их сургуулийн зохион байгуулалтын танхимтай хамтарч байгаад энэ бүтэц орон тоог шинэчлэхгүй бол илүү орон тоонд цалин явж байна. Сонгууль болгон дээр 5-10 орон тоогоор нэмдэг юм шүү дээ. Ер нь би ажиглаж байгаа. Жинхэнэ эмнэлгийн бүтэц орон тоог шинэчлэхгүй бол энэ ерөөсөө зүгээр болохгүй. Энэ бүтэц орон тоог шинэчлэх боломж .../минут дуусав/

Б.Найдалаа: Асуулт уу. Бейсен гишүүн асуулт уу саяынх. Саяын энэ бүтэц орон тоог шинэчлэх төлөвлөгөө, төсөөлөл байна уу. Хэн хариулах вэ. Ямар ч байсан Сангийн яамнаас хариулах уу. Энэ чигээрээ төсөв яриад явах юм уу, эсвэл зүгээр дотор бүтэц зохион байгуулалтыг нь төсвийн бүтцийг нь өөрчлөх талаар бодлого байгаа юу л гэж байна. Микрофон 5. Та нэрээ хэлээрэй. Протоколд орж байгаа учраас.

Ж.Ганбат: Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат. Төсөв маань өөрөө дийлэнх нь бол цалин, тэтгэвэр, халамжийн зардал гээд энэ зардлууд ер нь яг төсвийн зарлагын, ялангуяа урсгал зардлын бүтцийг нь аваад үзэхээр дийлэнх нь бараг цалин тэтгэвэр нийлээд 60-аад хувь нь бол эзэлж байгаа. Бид бол энэ олон жил Сангийн яам яах вэ, холбогдох салбарын яамнууд, ялангуяа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ тэр хамтраад, төрийн албан хаагчдын цалингийн асуудал ер нь ямар бодлого бид ер нь баримталж явах вэ, яах ёстой вэ гэдэг дээр нэлээн ажиллаж байсан. Төрийн албанаас бид үе шаттайгаар төрийн албан хаагчдыг төсвөөс гаргах ингээд жишээ нь ТҮ-ийн ажилчдыг гаргах, яг төрийн албан хаагч гэдэг ямар ангиллын хүмүүс орох ёстой юм бэ гэдэг тал дээр бол нэлээн ажлууд хийгээд, зарим нь хэрэгжээд явж байгаа /минут дуусав/

Б.Найдалаа: Тодруулга болсон. Бейсен гишүүний ярьж байгаа санаа зөв. Олон гишүүдийн санааг би зүгээр тодруулаад хэлэхэд энэ яг юу байгаад байна л даа. Бид нар үр дүн багатай хэлэлцүүлэг хийгээд байна. Яагаад гэвэл бодлого нь байхгүй газар төсөв байна уу гээд тоо бодохоор тэрний хариу нь 0 л гарах байхгүй юу. Яг үнэнийг хэлэхэд Сангийн яамныхан буруу ч биш, Сангийн яамныхны ажил биш байгаад байгаа юм. Салбарын яамдын ажил. Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн бодлого байх юм бол төсөв нь олдоно. Хаа нэгтэйгээс заавал олдоно. Тэгээд тэр нь байхгүй болохоор хамгийн сүүлд тавьчихаар төсөв байхгүй, тоо байхгүй нь ойлгомжтой. Тэгээд одоо яг үнэнийг хэлэхэд асууж байгаа, хариулж байгаа нь үр дүн байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр яг энэ хурлын болон цаашдаа түрүүн би хэлсэн үр дүн нь бол салбарын яамдаас, Засгийн газраас яг энэ талын тов тодорхой бодлогыг 2 биш, 3 биш, 5-7 жилийн хугацаатай тов тодорхой гаргуулах ёстой юм байна. Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Өргөдлийн байнгын хорооноос бас зарчмын хувьд дэмжээд оруулж ирсэн санал. Засгийн газар ч гэсэн ард иргэдээс санал асуухад ард иргэдийн дийлэнх нь боловсрол, эрүүл мэндийнхээ салбарт анхааръя гээд санал өгчихсөн. Гэхдээ төсөв дээр бол анхнаасаа орж ирэхдээ цалинг нэмүүлэх тал дээр мөнгө орж ирээгүй. Тийм учраас энэ асуудал бол нэг талаар багш, эмч нарын итгэл жоохон алдарсан байх гэж би бодож байгаа. Үүний өмнө жил болгон боловсрол, эрүүл мэндийн буюу энэ суурь салбараа дор хаяж 30 хувиар нэмээд явъя. Тэгээд

үндсэндээ 2025 он дуусах, 2026 он гэхэд үндсэн цалин хөлс, орлого нь 3 сая руу дөхөх юм байна гэдэг ийм гэрээ хэлэлцээрүүд бий. Би өөрөө энэ үйлдвэрчний эвлэлд байж байсан хүний хувьд бол маш сайн мэдэж байна. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд энэ асуудлыг тавьсан хүний хувьд. 2023 онд жишээлбэл хөдөө орон нутаг, аймгийнхаа хүмүүст сар болгон 40 хувийн нэмэгдэл, 20 хувийн нэмэгдэл олгоё. Үндсэн цалингуудыг нь 20-30, 40 хувиар нэмсэн. Тэгэхээр яг ийм байдлаар бол уг нь жил болгон шийдээд явъя гэдэг л ийм л хүлээлт байсан л даа. Тэгэхээр одоо гэнэт тэр хүлээлт нь талаар болоод энэ жил 6 хувь гээд би үүний өмнөх Засгийн газарт ч гэсэн шаардлага тавьж, наад 6 хувь чинь олигтой нэмэгдэл болохгүй. Ядаж бүгдийг нь хамааруулж байсныхаа оронд энэ суурь 2 салбар дээрээ анхааръя. Ийм гэрээ хэлэлцээр, хүлээлт байгаад байгаа юм гэдгийг хэлж байсан.

Тийм учраас одоо бол би ажил хэрэгч байдлаар асуудалд хандъя. Засгийн газар, Их Хурлын гишүүд ямар ч байсан санал гаргаад, 40 гаруй гишүүд гарын үсэг зураад, ер нь бол энэ багш, эмч нар дээр анхаарал хандуулах хэрэгтэй юм байна. Тэр тусмаа боловсролын жил гэж байгаа бол энэ цалинг үе шаттай байна уу, ирэх жилдээ багтаагаад ямар ч байсан тэр 3,5 саяд нь хүргэх тал дээр бол санал 1-тэй байгаа. Би бол энэ гишүүдэд баярлаж байгаа. Зарим гишүүд нь болохоор нэмье нэмье гэххээд, яг гарын үсэг зуръя, шийдье гэхээр болохгүй гээд зугтаагаад яваад байдаг. Ийм 2 нүүртэй байж болохгүй. Тэгэхдээ олонх нь Их Хурлын гишүүд бол энэ тал дээр нааштай. Засгийн газар ч гэсэн тодорхой тоо яриад, эхэлж байгаад би бол баяртай байна. Тэгэхдээ 15-20 хувь гэдгийг чинь хүлээн зөвшөөрөхгүй. Магадгүй ирэх жил дахиад 6 хувь гэдэг рүү ороод ирэх вий гэдэг л ийм л болгоомж л байгаад байна л даа. Тийм учраас бол Засгийн газар Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо би Төсвийн байнгын хорооны даргад хэлмээр байна. Тэр хөрөнгө оруулалтаасаа хасаа. Өчигдөр хэвлэл мэдээллээр бол хөрөнгө оруулалт хасаж болохгүй, зөвхөн урсгал зардал гээд. Эргээд боловсрол, эрүүл мэндийнхээ эм тариа руу орох юм уу, эргээд хүүхдүүдийнхээ нөгөө дэвтэр ном, засвар үйлчилгээ, урсгал засвар луугаа орох юм уу. Ингэж бол дунд нь ингэж болохгүй. Тийм учраас би бол яг бодит байдал дээр хөрөнгө оруулалт, урсгал зардал аль адилхан ор. Адилхан 10, 10 хувь хасчих. Тэгэх юм бол 1,6 орчим их наяд төгрөг гарч ирэх гээд байх шиг байна. Тэгээд ирэх ондоо багтаад хамгийн доод тал нь ... 1 минутаа нэмээд авчихъя.

Б.Найдалаа: 1 минут нэмээрэй. Эрдэнэбат гишүүнд 1 минут.

С.Эрдэнэбат: Хамгийн доод тал нь боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын үндсэн цалинг улсын дундаж цалингийнхаа хэмжээнд хүргээд, оныхоо төгсгөл рүү байдаг юм уу, ирэх оны яг 1 сарын 1 гэхэд тэр 3 сая 500 мянган төгрөгт нь хүргэх гэдэг ийм тал руугаа яривал арай бодитой сонсогдоно. Тийм учраас үндсэн цалин шүү. Одоо ингээд цалингийн бүтцийг харахаар 70/30 байдаг. Ер нь бол зохистой бүтэц. Эсрэгээрээ болчихсон. Үндсэн цалин нь бараг 30 хувь, бусад нэмэгдэл нь бараг 70 ч гэдэг юм уу. Тэгээд нийт багш нарын чинь бараг үндсэндээ 50 хувь нь л гүйцэтгэлийн үнэлгээ авч байгаа. Тэрний 10 хувь нь үндсэндээ 30 хавьцаа авч байгаа байхгүй юу. Тэгэхээр энд чинь бол мэдээллийн, тооны зөрүү бол хол байна. Тийм учраас Боловсролын яам, Эрүүл мэндийн яам эд нар хэлэлцээрээ хийгээд, улсын 3 талт хэлэлцээрээ уг нь энэ намар, зун хийгээд, төсвөө 1 тоон дээр уулзаад оруулж ирэх ёстой байсан. Тийм учраас одоо бодит байдал бол ажлын хэсэг дээр бол аль, аль зардлаас орохоос өөр арга байхгүй гэж бодож байна. Тийм учраас ийм зарчмын саналыг бол гишүүд гаргана гэж бодож байгаа. Тэгэхээр уг нь бол .../минут дуусав/

Б.Найдалаа: Үг хэллээ. Эрдэнэбат гишүүн үг хэлсэн. Асуулт байхгүй биз дээ. Нэмээд 1 минут.

С.Эрдэнэбат: Тэгэхээр төсвийн тэр урсгал зардлын 24 хувь гээд нэг ийм тоо тавьчихаад, нэмье даанч энэ дээр тулчихаад байна. Болохгүй гээд байгаа юм. Маш тодорхой санд би бол хэлсэн шүү дээ. Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал чинь төсвийн урсгал зардалд орохгүй. Бие даасан сан. 6, 7 их наядын тэр зүйлийг 24 хувьд оруулж тооцох угаасаа утгагүй. Тэгээд бүртгэлийн өөрчлөлт шинэчлэл 3, 4 жилийн дараа л болно гээд байгаа юм. Үндсэн концепцын хувьд угаасаа худлаа юмыг бид нар оруулж ирчихээд, төсвийнхөө дээд таазыг тавьчихаад, тэгээд цалин тэтгэвэр нэмье гэхээр болохгүй. Тэгээд урсгал зардал дотор нь хаая гэхээр одоо гишүүд яах юм та таа тунгаадах юм уу. Урсгал зардал дотор тэрийг хас, энийг хас гээд. Тэгээд хөрөнгө оруулалт руугаа орохгүй гэххэж байгаа юм. Уул руу зам тавих, нуур луу зам тавих энэ мөнгө яг өнөөдөр багш, эмч нарын цалин хөлстэй зэрэгцүүлээд тавихад тийм чухал юм уу. Тэгээд яг ийм бодит байдал руугаа л хэдүүлээ ормоор байна. Тэгээд ийм боломжийг та бүгд, Засгийн газар маань 24 хувийг бол больё гэж ярьж байх шиг байна. Энэ дээр ямар санаатай байгаа юм гэдгийг асууя.

Б.Найдалаа: Хариулт Сангийн яамнаас байх. Эх үүсвэр нэмэх хэрэгтэй гэдэг хаанаас авах юм бэ. Сангийн яамны эрэмбэ юу юм бэ. Микрофон 5.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Төсөв бол өөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төслийг бол боловсруулдаг. Энэ дээрээ төсвийн төслийг боловсруулахдаа тусгай шаардлагууд байдаг. Тусгай шаардлагуудыг хангасны хүрээнд бид бол төсвийн төслийг боловсруулан Засгийн газар, Сангийн яамнаас танилцуулаад, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг. Өргөн мэдүүлэхэд Үндэсний аудитын газраас бол аудит хийдэг. Энэ дээр бол энэ тусгай шаардлагыг Засгийн газраас боловсруулсан төсөл нь нийцэж байна уу, үгүй юу гэдэг дээр нь дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд танилцуулдаг байгаа.

Тэгэхдээ Засгийн газар бол яг өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд энэ тусгай шаардлагуудыг төсвийн алдагдал нь ямар байх юм, орлого нь ямар байх юм, зарлага нь ямар байх юм, бүгд тусгай шаардлагуудтай. Энэ тусгай шаардлагуудаа бүрэн биелүүлж л өргөн барьдаг. Энэ тусгай шаардлагыг бол өөрчлөх ямар нэгэн боломжгүй. Өөрөөр хэлбэл Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэдэг маань өөрөө төсвийн гол үндсэн зарчим байгаа. Тэгэхээр бид энэ дээр энэ хуулийн дагуу л өөрчилсөн. Тэрнээс одоо бид үүнийг өөрчлөх, нөгөө талдаа бас төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж өргөн мэдүүлж ингэж боловсрогдож Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг байгаа. Тэгэхээр бид бол аль болох Төсвийн тогтвортой байдлын хуулийг уг нь өөрчлөхгүйгээр тогтвортой мөрдөж байж бид төсвийн сахилга батыг чанд мөрдөх нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг Сангийн яам бол нэлээн хатуу баримталж байгаа.

Б.Найдалаа: Тэр сахилга батыг ойлгож байгаа. Зүгээр Эрдэнэбат гишүүний асууж байгаа нь эх үүсвэр нэмж хэрэгтэй бол хөрөнгө оруулалтаас хасах юм уу, урсгал зардлаас хасах юм уу. Сангийн яам эрэмбэлэх юм бол ямар бодолтой юм.

Ж.Ганбат: Бид бол сая Төсвийн байнгын хорооны дарга Ганхуяг гишүүний хэлсэн дагуу одоо бол Засгийн газар төсвөө Улсын Их Хуралд өргөн барьчихсан. Одоо Улсын Их Хурлаас тодорхой чиглэл өгөөд, бид тооцооллыг нь хийгээд, ажлын

хэсэг болон Төсвийн байнгын хороонд танилцуулахад бэлэн. Яах вэ ер нь бол зүгээр бидний барьж байгаа зарчим бол хөрөнгө оруулалтын зардлууд бол эдийн засагт шууд нөлөөлдөг, бас эдийн засгийг дэмжих байдлаар зардлууд гардаг учраас бид урсгал зардлыг урсгал зардал дотор нь урсгал зардлын нийт дүнг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулбал эргээд энэ илүү үр дүнтэй юм гэдэг ийм байр суурийг л барьж байгаа. Энэ дагуу Төсвийн байнгын хорооны дарга бол өчигдөр урсгал зардлын дүнд нь багтаагаад зохицуулах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурь хэлсэн. Бид бол үүнтэй санал нэг байгаа.

Б.Найдалаа: Ойлголоо. Урсгал зардал юм байна. Дараагийн гишүүн Хөххүүгийн Болормаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Болормаа: Юуны өмнө та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Багш нарын, эмч нарын цалинг нэмэгдүүлэх асуудлаар өргөдөл гаргасан иргэн Номинд бас талархлаа илэрхийлэхийг хүсэж байна. Тухайн иргэний гаргасан саналыг зарчмын хувьд миний бие бас дэмжиж байгаагаа үүгээр илэрхийлье.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын 120 гаруй мянган ажилчдын цалинг нэмэгдүүлэх, тэднийг ядуурлаас хамгаалах асуудлыг бодлогын түвшинд цогц байдлаар авч үзэх шаардлагатай гэж үзэж байгаа. Боловсрол, эрүүл мэндийн салбарын ажлын цалинг тухайн салбарынхны шаардаж байгаа 3,5 сая төгрөг болгож өсгөхөд улсын төсвийн урсгал зардал огцом нэмэгдэх тул Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд энэ байдлыг ... тэгэхээр одоо ганц асуудал ерөөсөө 2026 оны улсын төсвийг нэгэнт өргөн бариад, энэ үед урсгал зардлыг нэмэгдүүлэх нь хуулиар хориотой буюу хязгаарлалттай байгаа тул эдгээр салбарын ажлын цалинг нэмэгдүүлэх эх үүсвэрийг хаанаас олж авах тухай хамгийн гол нь бид нар бас гарц гаргалгаагаа гаргах хэрэгтэй гэж би бодож байна.

Сүүлд авсан мэдээллээр Засгийн газраас урсгал зардлыг 10 хувиар танаж, эмч, багш нарын цалинг 15-20 хувиар нэмэгдүүлээд, 2026 оны төсөвт суулгахаар санал боловсруулж байгаа гэж хэвлэл мэдээллээс сонсож ойлгосон. Тэгэхээр энэ саналаа яаралтай оруулж, төсвийн хэлэлцүүлэгт нэгтгэж оруулах нь зүйтэй байна гэсэн энэ саналыг бас та бүхэндээ уламжилж хэлэхийг хүсэж байна. Би яг товч тодорхой 3 асуултыг Боловсролын сайдаас буюу эрх бүхий албан тушаалтнуудаас асууя. Уучлаарай хурал даргалагч аа, 1 минутаа ахиад нэмээд авчихъя.

Б.Найдалаа: Болормаа гишүүний 1 минутыг нэмье.

Х.Болормаа: 1 дүгээр асуулт Засгийн газар анх төсвийн төсөл боловсруулж оруулж ирэхдээ багш нарын цалинг нэмэгдүүлэхэд 100 тэрбум төгрөг төлөвлөж оруулж ирсэн. Ингэхдээ нийслэл, орон нутгийн багш нарын цалинг ямар зөрүүтэйгээр нэмэгдүүлэхээр тусгаж оруулж ирсэн бэ. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт одоо 20 хувь хүртэл нэмэхээр саналаа боловсруулж оруулж ирэх гэж байгаа гэж ойлгоод байгаа. Энэ нэмэгдлээ ачаалал, ур чадвар, гүйцэтгэл дээр суурилж, ялгавартайгаар нэмж тооцож оруулж ирсэн үү.

Дараагийн 3 дахь асуулт 2026 оны Боловсролын яамны нийт зардал 4,3 их наяд төгрөг байсан. Үүнээс урсгал зардал нь 3,8 их наяд, хөрөнгийн зардал нь 448 тэрбум байсан. Бид өнөөдөр 2026 оныг боловсролын жил болгон зарлаад явж

байна. Тэгтэл өнөөдөр бодит амьдрал дээр эмч нар, багш нар маань аргаа бараад ажлаа хаяад, энэ асуудал үнэхээр Монгол Улсын .../минут дуусав/

Х.Ганхуяг: 1 минут нэмье.

Х.Болормаа: Баярлалаа. Ингээд явж байна. Тэгэхээр 2028 он гэхэд 95 цэцэрлэг, 108 сургууль шинээр барьж ашиглалтад оруулна. Тоног төхөөрөмжтэй буюу бусад хэрэглэлтэй нь хамт гэсэн байгаа юм. Тэгэхээр 2026 оны яамны хөрөнгө оруулалтын зардал 448 тэрбум байна. Тэгэхээр энэ 2028 он хүртэл үе шаттайгаар хийх 95 сургууль, 108 сургуулийн хэд нь энэ 2026 онд ашиглалтад орох вэ. Энэ 448 тэрбум төгрөгийн хэд нь 2026 оны хөрөнгө оруулалт руу ... юу уучлаарай миний асуулт буруу болчихлоо. Тэгэхээр 2026 онд нийт хэдэн сургууль, цэцэрлэг ашиглалтад орох вэ.

Х.Ганхуяг: 2 номерын микрофон өгье. Ажлын хэсэг.

Х.Батжаргал: Болормаа гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Батжаргал. 2026 оны төсвийн төсөл дээр Боловсролын сайдын багцад тусгасан 100 тэрбум төгрөг урсгал зардал буюу хувьсах зардлаар дамжуулж нэмэгдүүлсэн байгаа. Тэгэхээр бид нарт тулгамдаад байгаа гол асуудлын 1нь бол ялангуяа Улаанбаатар хотод аливаа нэгэн нэмэгдэлдээ хүрч амжаагүй байгаа, үндсэн цалингаараа ажиллаж байгаа 1 сая 484 мянган төгрөгийн цалингаа авч байгаа энэ хэсгийг яаж цалинг нь нэмэгдүүлэх, ялангуяа орон нутгийнх нь түвшинд нь дөхүүлэх буюу хүрэх вэ гэдэг энэ гол бодлогын тооцооллыг хийж үзсэн байгаа. Энэ үндсэн дээр тэгэхээр гол ялгаа нь болохоор Улаанбаатар хотод бол 1 багшид ноогдох хүүхдийн тоо хамгийн өндөр байдаг. Ялангуяа бид нар бас тооцоод үзэхээр 35-аас дээш 1 ангид сурч байгаа, бүлэг дүүргэлттэй байгаа хүүхдүүдийн ачааллыг багш дээр нь тооцоод энэ нэмэгдлийг бол хувьсах зардлаар нь дамжуулж 100 тэрбумыг хуваарилсан байгаа.

Тэгэхээр энэ үндсэн дээр юу гарах вэ гэхээр зэрэг 2 үе шаттай бид нар тооцоолол хийсэн юм.

1 дүгээрт нь энэ 100 тэрбум төгрөгийнхөө ачааллын нэмэгдлийг 35 хүүхэдтэй бүлэг дүүргэлтээс илүү ачаалал авч байгаа багш нар дээр тооцож үзэхэд үндсэндээ бол орон нутагт улсын дундаж 2,9 сая төгрөг байгаа. Тэгэхээр энэ үндсэндээ бол 2,5 сая төгрөгт хүрч, энэ ачааллын далимдуулсан ачааллаар дамжуулж олгож байгаа үндсэн дээр бол ялгаа нь арилах юм.

2 дугаарт нь таны 2 дугаар асуултад хэлсэн 20 хүртэлх хувийн нэмэгдлийн тооцооллыг бас хийж үзэхээр орон нутгийнхаа болон нийслэлийн энэ ачааллаар дамжуулсан энэ ялгаа 1 дүгээрт энэ 100 тэрбумаараа бас арилчхаж байгаа юм. 20 хувийн нэмэгдэл, түүн дээр дүйцүүлээд бас тооцогдоод давхар явагддаг 10 төрлийн нэмэгдэл нь ингэж тооцогдоод, нийслэл Улаанбаатар хотод бол үндсэндээ дунджаар нь шүү улсын дундаж 3,4 сая төгрөг, аймгийн төвүүдэд бас 3,4 сая төгрөг, сум бас 3,4 сая төгрөгт ингэж хүрч, ялгаа нь 1 дүгээрт арилаад, 2 дугаарт 3,4 сая төгрөг олговол зохих цалин нь хүрч байгаа ийм тооцооллыг хийсэн юм.

Тэгэхээр үндсэндээ бол улсын дундаж одоо бол 2,7 сая төгрөг байгаа нь үндсэн цалинг нэмэгдүүлээд дээр нь энэ ачаалалд дүйцсэн ялгааг бас арилгаад 3,4 сая төгрөг хүрч байгаа гэсэн ийм тооцоолол байгаа юм.

3 дугаар асуулт энэ улсын хөрөнгө оруулалт дээр бол 2028-2030 он хүртэл 108 сургууль, 95 цэцэрлэг шаардлагатай байгаа гэсэн хүн амын өсөлт, хүүхдийн тооны хэрэгцээ шаардлагыг дагасан ийм судалгааны дүн байгаа юм. 448 тэрбум төгрөгийн энэ хөрөнгө дээр тавьж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалт бол ер нь 2026 онд шилжин хэрэгжиж байгаа 198 төсөл арга хэмжээ дээр хэрэгжиж, үргэлжлүүлж зарцуулагдах ийм тооцоолол байгаа. Тэгэхээр шинээр баригдах хөрөнгө оруулалтыг бол гадаад зээлийн эх үүсвэрээр буюу 41 сургууль, цэцэрлэгийн байгууламжийг барих ийм тооцооллоор 2026 оны төсөв дээр хэлэлцэгдээд явж байгаа.

Х.Ганхуяг: Минут дуусчихсан юм байна. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу. 2 асуулт тодруулъя.

Эрүүл мэндийн салбарын зардалтай холбоотой эмч, эмнэлгийн ажилтнуудын зардалтай холбоотойгоор тодруулъя. Өртгийн жингийн тооцоог ер нь хэзээ шинэчлэх гэж байгаа вэ. Ер нь тэр жил болгон шинэчлэгддэг үү. Энэ дээр нөгөө цалингийн асуудалтай уялдаатай юмнууд бас байгаа болохлоор гэж асуумаар байгаа.

Дараа нь нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг ер нь өртгийн жингийн ижилхэн аргаар тооцох тогтолцоо систем та хэд маань ярьж байгаа юу. Би ийм бодлогын шинжтэй юм асууж байна.

3 дугаарт нь саяын миний асуултууд чинь нөгөө Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэгдэлтэй холбоотой. Тамхи, архи, чихрийн агуулгатай ундааны татвар эрүүл мэндийн нэмэлт онцгой албан татвар авч байгаа шүү дээ. Тэр ер нь манай Эрүүл мэндийн даатгалын санд хэчнээн төгрөг оруулж ирдэг юм бэ. Тэрийг нэмэгдүүлэх боломж ер нь байгаа юу гэдгийг бас тодруулъя.

Хамгийн сүүлд нь энэ эмч, сувилагч нарын цалингийн асуудал бол юутай холбоотой гэхээр төвлөрөлтэй холбоотой байгаа. Тэгэхээр эмнэлгийн орон тооны бүтцийг хүний нөөцийн асуудлуудыг төвлөрлөө ер нь багасгах ямар бодлого менежмент та нар төлөвлөж байна гэдэг дээр бас нэлээн ойлгомжтой 1, 2, 3-аар нь тодорхой хариулаарай. Эрүүл мэндийн салбарт тэвчиж болох зардал юу юу ордог вэ гэдгийг асууя.

Хамгийн сүүлд нь боловсролын салбарын асуудлыг би тодруулах гээд байгаа юм. Багш нарын цалингийн асуудал дээр Ерөнхий сайд мэдээлэл хийхдээ Бортээгийн ордыг ашиглалтад оруулж цалин нэмнэ гэсэн байгаа. Энэ та хэдийн тооцоонд яг яаж тусаж байгаа вэ. Сангийн яамнаас бас тодруулъя. Боловсролын сайд ч гэсэн хариулаарай.

Мөн Рио Тинтогийн хүүгийн төлбөрт өгч байгаа гэрээг шинэчилж байгаад мөн цалингаа нэмбэл яасан юм бэ гэсэн асуудлыг улс төрчид удаа дараа ярьж байгаа. Энэ асуудал дээр 2 яам ямар хариу өгөх вэ гэдгийг асуугаад, дараа нь тодруулъя.

Х.Ганхуяг: Ажлын хэсгийн 5 номер. Чинбүрэн сайд дараа нь гүйцээгээд хариулчхаарай.

Ж.Ганбат: Бид ирэх оны 2026 оны төсвийн төсөл дээр төсвийн орлогыг тооцохдоо манай гол экспортын нүүрс дээр бид нар 90 сая тонн нүүрс экспорт

гаргана гэж тооцсон. Үнийг бол бид нар дунджаар 70 ам.доллараар 1 тонн нүүрс гэж тооцож ингэж төсвийн орлогыг бол тооцсон байгаа.

Х.Ганхуяг: Чинбүрэн сайдын микрофон өгье.

Ж.Чинбүрэн: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Өртгийн жин хэзээ шинэчлэх вэ гэж байгаа юм. Өртгийн жин бол одоо гүйцэтгэж байгаа гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдахгүй байгаатай санал 1 байна. Бид өнгөрсөн хугацаанд олон бодлого оруулж, цалин нэмэх 4 ч удаагийн тогтоолууд гарсан. Энэ хугацаанд бол цалин нэм гэж хэлсэн болохоос даатгалын сангийн өөрийнх нь дүн өсөөгүй. Дүн өсөөгүй учраас одоогийн байж байгаа байдал бол даатгалын сангийн 2,2 их наяд төгрөг бол ихэнх нь ерөөсөө л цалин, 80 хувь нь цалинд явчхаж байгаа учраас өнөөдрийн энэ нөхцөл байдал бол ингээд ийм хүнд байдалд ороод байгаагийн нэг шалтгаан нь энэ. Тусламжийг, өртгийн жинг тооцдог техникийн хороо гэж байгуулагдсан. Тэгтэл одоо даатгалын үндэсний зөвлөл дээр техникийн хороо нь одоо хүртэл цалингүй байж байгаа. Цалингүй хүмүүс ажиллаж байна. Тэгэхээр цалинг хүртэл тодорхойлж өгөхгүй болохлоор тэр тогтвортой, суурьшилтай технологиудыг үнэлэх түүний орц /минут дуусав/

Х.Ганхуяг: Чинбүрэн сайдын микрофон нэмээд өгье. Байж байгаарай Сараа гишүүн нэмээд тодруулчих. Тэгээд гүйцээгээд хариулуулчихъя. Тэгэх үү. Саранчулуун гишүүний микрофон өгье.

О.Саранчулуун: Тийм Сангийн яам, Боловсролын яам энэ тэр тодорхой хариулчхаарай. Хэсэгчлээд хүмүүстээ мэдээлэл өгье. Миний асуусан асуултууд дээр. Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг өртгийн жинлэлд нэвтрүүлэх цаг манайд ирж байгаа юу, ирээгүй юу, болоогүй байгаа юу. Ер нь жоохон хол байна уу тодруулъя.

Х.Ганхуяг: Гишүүний асуултад гүйцэд хариулна шүү. Чинбүрэн сайдын микрофон өгье.

Ж.Чинбүрэн: Эхний хариулт болсон юм шиг байна.

2 дахь хариултдаа оръё. Нийгмийн эрүүл мэндийн өртгийн жин бол хагас хийгдэж байгаа. Ялангуяа анхан шатын тусламж, үйлчилгээ дээр нийгмийн эрүүл мэндийн тусламж хэсэг бол орчихсон. Энийг үнэлээд, тэгээд анхан шатын тусламж үйлчилгээ дээр санхүүжилт нь ороод явдаг. Харин бид эрүүл мэндийн ажилчид гэхээр зөвхөн эмнэлгийн тусламжийг гүйцэтгэдэг ажилчид биш, мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ажилчид, тэдгээрийн үнэлэмжийг бас дээшлүүлэх нь яг энэ таны хэлж байгаа өртгийн жинг нэмэгдүүлэхтэй холбоотой болно. Энийг яахын тулд та бүхэн бас энэ ажлын хэсэг байгуулаад, нийгмийн эрүүл мэндийн ажилчдын үнэлэмжийг дээшлүүлэх тал дээр бас Саранчулуун гишүүн таныг бас илүү анхаарч ажиллаж өгөөсэй гэж хүсэж байна.

Архи, тамхи хэдэн төгрөг ордог вэ гэсэн. Эрүүл мэндийг дэмжих санд бол ойролцоогоор бид жилдээ 9 орчим тэр /минут дуусав/

Х.Ганхуяг: 5 номер дээр гүйцээгээд хариулчхаарай. Ажлын хэсэг 5 номер.

Ж.Ганбат: Уг нь бид төсвийн төсөл боловсруулахдаа орлогоо тооцохдоо салбарын яамнуудаас мэдээллийг нь авдаг. Дэлгэрэнгүй. Одоо жишээ нь 2026 онд

хэчнээн сая тонн нүүрс ямар ямар уурхайнууд дээр, аль аль компаниудаар гарах вэ гээд бүр 1 бүрчлэн деталь гаргаж, тэрнийхээ үндсэн дээр бол тооцдог. Тэр ирсэн тооцоо дотор саяын таны асуугаад байгаа Бортээгийн асуудлыг жишээ нь Уул уурхайн яам дээр эдийн засгийн эргэлтэд оруулах, Эрдэнэс Тавантолгой компаниас эдийн засгийн эргэлтэд оруулах ийм нарийвчилсан юмнууд байгаа. Уг нь Эрдэс баялаг, уул уурхайн яамнаас энэ талаар бүр дэлгэрэнгүй асуувал илүү зохилтой байх гэж ингэж бодож байна.

Бид бол нийтдээ 90 сая тонн нүүрс, дундаж үнэ нь 70 ам.доллараар тооцож төсвөө .../минут дуусав/

Х.Ганхуяг: Хариулт авч дууссан уу. Дахиад тодруулчих Саранчулуун гишүүнд микрофон өгье.

О.Саранчулуун: Яах вэ, тусгагдаагүй гэж ойлголоо. Уул уурхайн яамнаас асуугаарай гэж хариулж байна гэж ойлголоо. Зөв үү. Тэгэхээр улсын төсөв хийсэн хүмүүс нь наадах чинь энэ дээр байхгүй байна гэж хэлээд байгаа юм уу. Эсвэл чи асуултаа тэр газраас очиж асуу гээд байгаа юм уу. Тэрийг нь бас би ойлгохгүй байгаад байна.

Дахиад асууя. Онцгой албан татварыг ер нь хэдүүлээ энэ дээр жоохон нэмээд Чинбүрэн сайд аа, хэдүүлээ энэ дээр жоохон ажиллаж байгаад энэ сангаа арвижуулах дээр ажиллавал яасан юм бэ. Энэ дээр ер нь бодлогын хувьд та юу гэж бодож байна гэдгийг тодруулмаар байгаа юм.

Түрүүний нөгөө эмнэлгийн төвлөрөл дээр би ерөөсөө хариулт авч чадсангүй. Мөн тэвчиж болох зардал гэдэг дээр хариулт авч чадсангүй. Сангийн яам тэвчиж болох зардлыг эрүүл мэндийн салбарт юу гэж хардаг юм.

Х.Ганхуяг: 5 номер. Чинбүрэн сайд хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Архи, тамхины онцгой татвар бол орж ирэх ёстой. Ер нь бол Сангийн яамнаас үүнтэй дүйцэхүйц хэмжээгээр 9 тэрбум төгрөгийг бид эрүүл мэндийн дэмжих санд орж байгаа. Үүгээр дамжуулаад бид шинэ технологи мөн нэмээд гадаадад эмчлүүлсэн хүүхдэд 50 хувийг нь, насанд хүрсэн хүнд 25 хувийг нь зардлыг нь дааж байгаа энэ үйл ажиллагаа явж байгаа. Одоо энэ Тамхины тухай хяналтын тухай хууль хэрвээ батлагдвал энэ татвар нэмэгдээд илүү их мөнгө орж ирэх талтай. Тийм учраас энэ дээр хэдүүлээ хамтарч ажиллах ёстой бай. Т

Төвлөрлийг багасгахтай холбоотой ямар бодлого хэрэгжиж байна гэж байна. Засгийн газраас орон нутгийн нэмэгдэл гэдэг маш чухал санхүүжилтийг ялангуяа нөгөө сайн эмч нарыг орон нутагт ажиллах боломжийг нь хангах зорилгоор сумд 40 хувь, аймагт 20 хувийг нь өгдөг. Энэ бол төвлөрлийг сааруулах гэж байгаа бодлого бол бид худалдан авах үйл ажиллагаагаараа харин орон нутагт анхан шатад болон дүүрэг, аймгийн эмнэлэгт эмчлүүлж байгаа хүмүүсийн тарифыг коэффициент. /минут дуусав/

Х.Ганхуяг: Мөнхтуяа гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Багш, эмч нарын ажил хаялт, жагсаал цуглаантай холбоотой гэхээс илүү ер нь энэ боловсролын салбар, эрүүл мэндийн салбарын багш, ажилтнуудын цалин хөлсийг зохистой түвшинд

хүргэх эдийн засгийн нөөц боломж итгэлцүүрийг хуульчилж өгөх хэрэгтэй байна гэдэг нь ер нь харагдаж байна. Тэгээд л жилийн жилд гарч ирээд жагсдаг, тэмцдэг. Тэгээд 6 хувь, 5 хувиар аргацаагаад ингээд явахгүй нь бол амьдралаараа батлагдаад харагдчихлаа.

Тийм учраас миний хувьд Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачилж, 42 гишүүний хамт өргөн барьсан байгаа. Энэ хуулийн төсөл дээр бол мэдээж багш нарын цалин хөлс бол хамгийн 1 дүгээрт эрэмбэлэгдэх асуудал учраас багшийн цалин ДНБ-ий хэдэн хувьтай байх вэ. Эсвэл төсвийн нийт зардлын хэдэн хувийг эзлэх вэ гэдэг дээр гол ач холбогдол поинт өгөөд ингээд оруулчихсан байгаа. Тэгээд бид нарын энэ өдөр тутамдаа ярьдаг нөгөө ажил муутай хурал их гэдэг шиг байнгын л нэг ийм тулга тойрсон юм ярьдгаа одоо болимоор байна. Ер нь энэ багш, эмч нарын нийгмийн асуудлыг бид нар хуульчилж өгөх хэрэгтэй байна. Хуулиар хамгаалахгүй бол Засгийн газар, үйлдвэрчин, ажил олгогч гээд 3 талт хэлэлцээр гээд гуйлгачин болгодог нэг ийм явцгүй ийм балай тогтолцоотой их олон жил явж ирсний хар гайгаар өнөөдөр багш, эмч нарын цалин ийм бага байгаа. Жил бүр зохистой түвшинд нь нэмээд, бодитой нэмсэн бол өнөөдөр багшийн цалин 5 сая төгрөгт тэнцэхээр ийм байх ёстой. Гэтэл бид нар гал унтрааж аргацааж бодлогогүй явсны хар гайгаар өнөөдөр багшийн цалин, эмчийн цалин, ахмадын тэтгэврээ яриад, тулга тойроод сууж байна. Шийдэл байхгүй. Шийдэл ярья гэхээр бүгдээрээ зугтаадаг. Түрүүн Эрдэнэбат гишүүн хэлсэн шүү дээ. Тэгье, тэгье боловсролын салбарын багш нарынхаа цалинг нэмэлгүй яах вэ гэххээд гарын үсэг зурах болохоороо зугтаадаг. Ингэж болохгүй гээд айгаад гүйдэг. Бид нар үнэнтэйгээ нүүр тулж, бодит асуудлаа л яримаар байна. Энд зүгээр худлаа зарим нэг хүмүүс нь ярьсан болж, сонссон болж суумааргүй байна. Хуульчилж өгмөөр байна эмч, багш нарын цалинг.

Миний хувьд бол энэ Боловсролын ерөнхий хууль дээр багшийн цалинг ДНБ-ий 6 хувьд хүргэе. Төсвийн зардлынхаа 20 хувьд хүргэе гэж байгаа юм. Энэ юунаас гарсан санаа вэ гэвэл Инчоны тунхаглал гээд 2015 онд дэлхийн 160 гаруй орны боловсролын сайд нар үүрэг хүлээчихсэн. Энэ үүргээ өнөөдөр 10 жил өнгөрч байхад хийгээгүй. Өнөөдөр ДНБ-ий 4 хувьтай л байгаа. Эрүүл мэндийн салбар 3 хувь гээд сая Мөнхсайхан сайд хэлж байна. Тэгэхээр энийгээ ярья. Би минутаа нэмье. Тэгээд ерөөсөө 1 ийм гал унтраасан, аргацаасан ... /минут дуусав/

Х.Ганхуяг: Мөнхтуяа гишүүний микрофон нэмж өгье.

Ц.Мөнхтуяа: Шийдэлгүй ийм маягаар 1 жилийг өнгөрөөлөө. Одоо жоохон ажлаа хиймээр байна. Бид нар өнөөдөр хууль санаачилж, боловсруулж ард иргэдийнхээ төлөө ажиллая гэж энэ Их Хуралд орж ирсэн гэж би ойлгож байгаа. Тэрнээс төсөл, тендер цохиж, өөрсдийгөө баяжуулж, кармагаа түнтийлгээ гэж ороогүй байх. Өнөөдөр яг ард иргэд чинь шийдлээ хүлээсэн өчнөөн олон асуудал байна. Тэтгэвэр, багш, эмч гээд энэ асуудлаа шийдлээ ярихгүй зүгээр л ингэвэл болохгүй, ингэвэл тэгнэ гээд 5, 6 хувийн нэмэгдэл ярьж суухаасаа ичих хэрэгтэй байна. Зоригтой шийдэл хийж энэ эмч, багш, ахмадуудынхаа тэтгэвэр цалин хөлсөө бодитой нэмэхгүй бол жил бүр л энэ асуудал чинь явна. Тийм учраас энэ 20 хувь, 10 хувь гэж гонгиноцгоохоо боль. Яг тэр хэлээд байгаа, шаардаад байгаа цалин руу нь явъя. Тэр тэвчиж болох зардлуудаа танаач ээ. Хэний эрх ашиг хөндөгдөх гээ, ямар хүнийх нь тендер нь ажиллахгүй болох .../минут дуусав/

Х.Ганхуяг: Үг хэлчихлээ. Номин гишүүний микрофон өгье.

Ч.Номин: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын төсвийг тухайн ондоо хэрхэн тодорхойлж орж ирснээр тухайн Засгийн газар, тухайн салбарын сайдын бодлого бодитоор харагдаж байдаг. Манай Засгийн газрын хувьд бол 2026 оныг боловсролын жил болгож зарласан. Мөн Засгийн газрын хамгийн том мега төсөл бол хүний хөгжил гээд тодорхойлсон. Гэтэл төсөв анхнаасаа тодорхойлогдож орж ирэхдээ багш, эмч нарын асуудлыг огт яриагүй орж ирсэн. Огт тодорхойлоогүй орж ирсэн. Тэгээд гал унтраах байдлаар 7 хоног, 2 7 хоногийн өмнөөс багш нар, эмч нар жагсаал цуглаан хийсэн учраас 10-20 хувь нэмье гэдэг ийм саналыг гаргаж ирсэн. Бид бүхэн мэдэж байгаа. 3 талт хэлэлцээрийг Засгийн газар, Үйлдвэрчний эвлэлтэй хийх ёстой.

1 дүгээр асуулт яагаад энэ хэлэлцээр Засгийн газрын төсөв тодорхойлогдохоос өмнө хийгдэж орж ирээгүй вэ. Одоо ингээд төрийн албан хаагч нараас бас асуухад яг үнэндээ төсвийн бодлогыг тодорхойлж байгаа хүмүүс биш, олгогдсон цар хүрээндээ л ажлаа хийж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бас яг бодитой асуултдаа хариулт авна гэж харахгүй байна.

2 дугаарт цалин хөлсөө нэмэгдүүлье гээд багш нараас юу ирж байгаа, мессежүүд ирж байна. Өнөөдрийн байдлаар надад 1 цагт 100 мессеж ирж байна. Эндээс ингээд уншаад танилцуулахад бол ерөөсөө л 3,5 сая төгрөгийн цалин хүргэж өгөөч ээ. Өнөөдрийн оруулж ирж байгаа нэмэгдэл чинь бол хүрэхгүй байна гэдэг ийм зүйл гарч ирж байна. Ингээд энэ хэлж байгаагаар нь 2 дахин нэмэгдүүлэхэд миний тооцооллоор 3-4 их наяд төгрөг хэрэгтэй. Та нарын нэмэгдлийг бол хүлээж авахгүй гэж байна. Манай Байнгын хорооны дарга бол сайд нарынхаа багцаас 10 хувиар бууруулаад нэмнэ гэдэг шийдэл байна Улсын Их Хурал дээр гэдгээ хэлчихсэн. Гэтэл эхнээсээ сайд нар нь ингэж бууруулах юм бол бид нар ажлаа хэрэгжүүлж чадахгүй гэдгээ хэлээд эхэлчихсэн. Тэгэхээр би 2 асуулт асууя. 1 дүгээрт энэ хэлээд байгаа хөтөлбөр арга хэмжээнээс 10 хувь бууруулахад хэдэн төгрөгийн цалин нэмэгдүүлж болох гээд байгаа юм бэ. Багш эмч нарын цалин дээр хэдэн төгрөг яг нэмэгдэх гээд байгаа юм. Одоо энэ хүсээд байгаа хэмжээнд 3,5 сая төгрөг болгоход бид нарт ямар нөөц бололцоо байгаа юм бэ. Үүнийг хэлж өгөөч.

3 дахь асуулт бол яагаад үйлдвэрчний эвлэлтэйгээ урьдчилж 3 талт хэлэлцээрээ хийхгүйгээр одоо ингээд Улсын Их Хуралд аль хэдийн өргөн барьчихсан төсөл дээр бид нарыг хэлэлцүүлэг хийлгээд байгаа вэ. Яагаад вэ гэхээр энэ бол үр дүнгүй. Бид нар хөрөнгө оруулалтаасаа авч чадахгүй. Хуульдаа захирагдана. Энэ урьдчилсан хэлэлцүүлгээ яагаад хийгээгүй вэ гэдэг ийм 3 асуулт байна.

Х.Ганхуяг: Номин гишүүн маш зөв л асуулт асуулаа. Тэгээд 3 талт хийцээрээ хиймээр байна. Энэ урсгал зардал чинь бүгдээрээ хуультай зарлалууд байдаг. Хэн хариулах юм. Нийгэм, хамгааллын яам хариулах уу. Ажлын хэсгийн 4 номер.

Л.Мөнхзул: Нийгмийн 3 талт зөвшлийн улсын хэлэлцээр 2025 онд дуусна. Энэ хэлэлцээрийн үндсэн заалт бол инфляцын түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг жил бүр нэмэгдүүлнэ гэсэн ийм үндсэн заалттай явж байгаа. Тэгэхээр өнгөрсөн жилийн тухайд бол инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмсэн. Өмнөх жилүүдэд дундаж нэмэгдлүүдийг хийгээд явсан. Үүнээс гадна эрүүл мэндийн салбар мөн боловсролын салбар, салбарын хэлэлцээртэй. Энэ салбарын хэлэлцээр дээр хэлэлцээрийн хугацаа одоо бол хүчин төгөлдөр байгаа. 3 жилийн хугацаанд хийсэн. Тэгэхээр энэ хэлэлцээрийн дүнд бол дундаж цалинг 3,5 саяд хүргэнэ гэсэн ийм зорилттой. Тэгэхээр энэ зорилтынхоо дагуу бас Эрүүл мэнд,

боловсролын яам салбарын бодлогоо боловсруулаад, холбогдох төсвийг улсын төсөв дээр тусгуулах чиглэлээр ажиллах нь салбарын яамдын үндсэн чиг үүрэг гэж хэлж болно.

Х.Ганхуяг: Хариултыг нь гүйцэж өгье. 4 номер.

Л.Мөнхзул: Үндсэндээ эмч, багш нар мөн шинжлэх ухааны салбарт ажиллаж байгаа ажиллагчдын цалинг 15-20 хувиар нэмэгдүүлэхэд нийт үндсэн цалинг нэмэгдүүлэхэд, тэгэхээр үндсэн цалин 15-20 хувь нэмэгдэнэ гэдэг маань түүнийг дагалдан олгож байгаа ажилласан жилийн нэмэгдэл, мэргэжлийн зэргийн нэмэгдэл, мөн ур чадварын нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл 20-40 хувь гэх мэт дахиад нэмэгдлүүд бол нийт цалингийн хэмжээ үндсэн цалингийн хэмжээтэй тэнцэх хэмжээний нэмэгдлүүд ихэнх төрийн албан хаагчдын үйлчилгээний төрийн албан хаагчдын хувьд авч байгаа. Тэгэхээр гар дээр авах дүнгээс наана буюу НДШ болон татвар төлөх цалингийн дүн оны эцэст 3 сая нэлээд гаруй болно гэсэн тооцооллыг бас салбарын яамнууд бол хийгээд байгаа. Боловсролын яамнаас.

Х.Ганхуяг: Номин гишүүн тодруулъя.

Ч.Номин: Надад Сонгинохайрхан Мөнхзул гээд 29 жил ажилласан багшаас ирсэн мэдээлэл яг одоо би энд уншаад сууж байна. Юу гэж байна вэ гэхээр 29 жил ажиллахдаа 1,6-1,8 сая төгрөгийн цалин авч байна. Одоо таны хэлээд байгаа олон жилийн нэмэгдэл урамшуулал юу байдаг юм бүгдийг нь нэмээд ингээд авч байна гэдэг чинь энэ хүмүүс цалингаа 2 дахин нэмэгдүүлье гэж хэлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би Сангийн яамнаас бас асууя. Энэ хэлээд байгаа 2 дахин нэмэгдэл буюу 3,5 сая төгрөгийн цалинг татвар нийгмийн даатгалын өмнө авдаг болгоё гэхэд яг улсын төсвөөс нийт хэдэн их наяд төгрөгийн санхүүжилт хэрэгтэй байгаа вэ. Энэ санхүүжилтийг яагаад анхнаасаа бодлогоо суулгаж оруулж ирээгүй вэ. Хэрвээ боловсролын жил гэж зарласан юм бол боловсролын жилийн бодлого тодорхойлогдсон юм бол төсвөөрөө энэ илрэх ёстой. Тэгэхээр салбарын сайд болон Сангийн сайд бодлоготоо хэрхэн энийг тусгаж оруулж ирсэн бэ .../минут дуусав/

Х.Ганхуяг: Асуулт уу, санал уу. 2 номер хариулъя.

Х.Батжаргал: Номин гишүүний асуултад нэмж тодруулъя. Тэгэхээр боловсролын салбарын хувьд бол одоо авч байгаа цалин тооцоолол нийт цалингийн сан бол 2,8 их наяд байгаа. Тэгэхээр яг яригдаад байгаа үндсэн цалинг 3,5 сая төгрөг болгоход дагаад бас үүн дээр үндэслээд бусад нэмэгдлүүд нь тооцогдоод, ингээд 3,3 их наяд шаардлагатай буюу нийт боловсролын салбарын цалингийн багц 6,1 их наяд шаардлагатай гэсэн тооцоолол байдаг. Таны асуусанчлан гар дээр олговол зохих цалинг 3,5 сая төгрөг болговол гээд сая бас гишүүдийн асуултад хариулж байх үед бас хэлсэн. Үндсэндээ бол энэ 20 хувийн нэмэгдлийн тооцооллоор бол гар дээрээ үндсэндээ бол гар дээрээ биш олговол зохих цалин бол .../минут дуусав/

Х.Ганхуяг: Тодруулъя.

Ч.Номин: Ингээд бид нарт 3,3 их наяд зөвхөн багш нарын цалинг 3,5 сая хүргэхэд хэрэгтэй юм байна. Миний гол тавиад байгаа асуудал бол Улсын Их Хурлын хашаа давуулаад шидчихсэн, аль хэдийн өргөн барьсан зүйлийг чинь бид нар хуульдаа захирагдаад, хөрөнгө оруулалтаас урсгал зардал руу оруулна ч юм уу

ийм зүйл бол байхгүй. Манай Байнгын хорооны даргын хэлээд байгаа төсвийн ерөнхийлөн захирагч болгоноос 10 хувийг бууруулаад хүрэхгүй нь байна. Анхнаасаа бодлогоо тодорхойлохдоо нэгэнт боловсролын жил гэж тодорхойлсон юм бол нэгэнт энэ Засгийн газрын мега төсөл нь хүний хөгжлийн асуудал гэж тодорхойлсон юм бол Засгийн газар, цаашлаад Сангийн сайд яагаад энэ асуудлаа тодорхойлж оруулж ирж төсвийнхөө бодлогод уялдуулаагүй вэ. Энэ бол хууртсан төсөв байна гэж үзэх гээд байна шүү дээ. Бодлого нь өөр юм яриад, төсвийн бодлого нь шал өөр гарч ирж байна. Тэгэхээр энэ 2 чинь хоорондоо огт нийцэхгүй ажил, ам 2 чинь нийцэхгүй ийм төсөв оруулж ирчхээд одоо Их Хурлыг зас гэж байгаа чинь бол .../минут дуусав/

Х.Ганхуяг: Санал хэлсэн үү. Санал хэлчихлээ. Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Сангийн яамнаас болон салбарын сайдуудаас асуух асуулт байна. Эмч, багш нарын цалинг өнөөдөр ярьж байна. Тэгэхэд бусад төрийн албан хаагчийн дундаж цалинтай харьцуулсан ийм судалгаа байна уу.

Ерөнхийдөө эмч, багш нарын цалинг тодорхой хугацаанд тэгээд үе шаттай нэмэхийг дэмжиж байгаа. Зарчмын хувьд. Өнөөдөр багш, эмч нарын цалин гэж ярьж байгаа. Тэгэхдээ энд сургуулийн ажилтан болон эмнэлгийн ажилтны бас цалин нэмэгдэхээр байгаа юу. Тэр ажилтны цалин дунджаар хэд вэ. Ер нь тэрийг тооцоолсон тооцоолол байна уу.

2 дугаарт нөгөө эмч нарын цалинг нэмнэ гэхээр түрүүн Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлийн санхүүжилт орсноос хойш ингээд Эрүүл мэндийн даатгалын сангаас гарч байгаа гэж ярьж байна. Сайд бол сангийн бараг 80 хувь нь цалинд зарцуулагдаж байна гэж. Энэ яг үнэн үү. Тэгээд цаашдаа 10-20 хувь хэрвээ эмч нарын цалин нэмнэ гэж тооцож байгаа бол энэ хэмжээгээр Эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэр нэмэгдэх үү. Энийг та нар тооцоолсон уу.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм. 6 номер дээр.

Б.Алимаа: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Алимаа. Статистикийн хорооны цалин хөлсний дундаж цалин хөлсний статистикийн мэдээллээр бол боловсролын салбарын ажиллагсдын дундаж цалин 3 сая 379 мянга, эрүүл мэндийн салбарын ажиллагсдын дундаж цалин 3,4 сая төгрөг гэсэн ийм статистик дүн байгаа. Салбар салбараараа бол үндсэн цалинг Засгийн газраас цалингийн сүлжээ болон цалин хөлсний доод хэмжээний тогтоолоор бол баталж, мөрдүүлж байгаа. Тухайлах юм бол одоогийн байдлаар их эмчийн цалин бол 1 сая 484 мянга үндсэн цалин. Эндээс бол нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцогдоно. Эрүүл мэнд, боловсролын салбарт ялангуяа 40-60 хувийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал тооцогдож байгаа. Одоогийн байдлаар Засгийн газраас өнгөрсөн 7 хоногт бас цалин хөлс нэмэгдэх асуудлаар тухайлаад хэлэлцсэн. Боловсролын салбарт 20 хувь, эрүүл мэндийн салбарт 15 хувийн нэмэгдэл нэмэгдэхээр ийм тооцоолол гарсан байж байгаа. Нийтдээ тэтгэвэр, тэтгэмж цалин хөлсний нэмэгдэлд 831 тэрбум төгрөг нэмж шаардлагатай гэсэн тооцоог бол салбарын яамнуудтай хамтран хийгээд байна.

Х.Ганхуяг: Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Би түрүүн хэллээ. Тийм ээ. Энэ цалин хөлс нэмэхтэй холбоотой бодитой тоо нэмэгдэхгүйгээр гүйцэтгэлийн санхүүжилттэй гэдгээр нэмээд байгаа нь өөрөө Эрүүл мэндийн даатгалын санд бол том ачаа болоод байгаа. Тэгэхээр энэ 70-80 хувь болж байгаа нь үнэн үү, худлаа юу гэдгийг та ажлын хэсэгт ороод тэгээд тооцооллыг нь харахаар танилцуулъя. Тэгэхээр энэ бол зохиосон зүйл биш. Энэ нь өөрөө гүйцэтгэлийн санхүүжилтийн утгыг алдагдуулаад байгаа 1 том чухал зүйл байгаа шүү дээ. Тийм учраас сая Ерөнхий сайд, Засгийн газарт үүрэг өгөхдөө Сангийн яаманд үүрэг өгөхдөө гол хэлдэг 830 тэрбум гэдэг маань бодитой тоо нэмэгдэж байгаа байхгүй юу. Бид энэ Засгийн газар ямар ч байсан бид цалин нэмж байгаа бол тэр үндсэн цалинг нэмэх нь өөрөө маш чухал. Үндсэн цалинг бид нар 15 хувь нэмээд энэ бол эрүүл мэндийн салбарт 181 тэрбум төгрөг. Ингэснээрээ нийт авч байгаа цалингийн хэмжээ 400-800 мянган төгрөгөөр нэмэгдэх боломж нь бүрдэж байгаа юм. Нөгөө бусад нэмэгдлүүдээ үндсэн цалингаасаа .../минут дуусав/

Х.Ганхуяг: Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Түрүүн төрийн албан хаагч гээд зөвхөн их эмчийг ярилаа. Яг эмнэлгийн ажилтан, жолооч, сургуулийн харуул гэх мэтчилэн төрийн албан хаагч ямар цалин авч байгаа юм.

Х.Ганхуяг: Хэн хариулах вэ. 6 номер.

Б.Алимаа: Цалин хөлсний тухайлсан мэдээллийг Энхнасан гишүүнд салбар болгоноор нь нэг бүрчлэн мэдээллийг бол бэлдэж өгье. Яах вэ, зүгээр товчхон хариулахад төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин бол 980 мянга орчмоос хамгийн бага цалин эхэлж байгаа. Энэ бол төрийн үйлчилгээний бага тушаалын албан хаагчдын тухайд 980 мянгаас эхэлж байна. Тэгээд үндсэн цалин дээр нэмэгдэл түрүүний хэлдэг ажилласан жилийн, ур чадварын гэх мэтчилэн нэмэгдлүүд бол нэмэгдээд ингээд тооцогдоно. Хамгийн бага цалин бол 980 мянга орчмоор эхэлж байна.

Х.Ганхуяг: Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Би одоо бол асуулт гэхээсээ илүү Сангийн яаманд санал хэлмээр байна. Нэгэнт цалингаа боловсролын жил болж байгаа учраас энэ багш нарын цалин, сургуулийн ажилчдын цалинг хүсэж байгаагаар нь нэмэх шаардлагатай. Харин энэ дээр ажил хэрэгч хандаад, зүгээр урсгал зардлыг нь 10 хувиар бууруулах гэхээр биш, яг шаардлагагүй гэсэн хөрөнгө оруулалтыг эрэмбэлээд, тэгээд урсгал зардлуудыг ч бас эрэмбэлээд энэ дээр бас саналаа оруулж ирээч ээ. Тэгээд Байнгын хорооны дарга бас энэ тал дээр чиглэл өгөөч гэж хүсэж байна.

Х.Ганхуяг: Асуулт асуусан уу. Үг хэлсэн байна. Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Яг тэгэхээр цалин хөлсийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэдэгтэй би санал нэг байгаа. Ер нь бол өнөөдөр улсын дундаж цалин бол 2 сая 621 мянган төгрөг, үүнээс төрийн албан хаагчийн цалин бол 40 орчим мянган төгрөгөөр арай бага байгаад байгаа юм. Тэгээд нийгмийн үйлчилгээний салбар буюу эрүүл мэнд, боловсрол, соёл, урлагийн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн цалин хөлс бол түүнээс бараг 200-100 мянган төгрөгөөр арай бага байгаад байгаа. Тэгэхээр энэ нийгмийн үйлчилгээний салбарт ажиллаж байгаа хүмүүсийн цалин хөлсийг нэмэх гэдэг бол яах аргагүй тулгамдсан асуудал болоод байгаа юм. Энэ дээр бол би бас санал 1 байгаа. Үүний шийдэл гаргалгааг 2 янзаар яриад байна л даа. 1 нь болохоор

төсвийн ерөнхийлөн захирагчдын зардлаас 10 хувиар суутгаад, тэгээд нэмэгдлийг хийе. Их удаж боловсролд бол 20 хувиар, эрүүл мэндэд бол 15 хувиар нэмээд явах ийм шийдэл гаргалгаа ярьж байна. Энийг харахдаа би бол энэ их дорвитой нэмэлт, өөрчлөлт болж чадахгүй гэж би бодоод байгаа юм.

Тэгэхээр бас өөр 1 байр суурь яригдаад байгаа. Тэгэхээр энэ дээр би Сангийн яамнаас тодруулж ахиж асууя. Тэгэхээр ер нь бол ДНБ-ий 24 хувийг л урсгал зардалд зарцуулна гэсэн. Яг энэ босгондоо, яг эндээ баригдчихаад бид нар урсгал зардлыг ер нь бага байлгана гэсэн энэ ойлголтдоо баригдчихаад хүмүүсийнхээ цалин мөнгийг нэмж чадахгүй байгаад байх юм. Энэ 24-ийг 25 болгох хуулийн заалтдаа өөрчлөлт оруулаад энийг зохицуулах арга тал байдаггүй юм уу. Энийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт ер нь бид нар бол цалин хөлсний тогтолцоогоо шинэчлэх цаг нь болчихсон. Салбарын хувьд харьцуулаад аваад үзэхэд харилцан адилгүй. Өнөөдөр уул уурхай, тэгээд л цахилгаан, хөрөнгийн зах зээл энэ салбарынхан бол хамгийн өндөр цалин аваад явчихдаг. Ахиад саяын нийгмийн үйлчилгээнийхэн бол хамгийн бага цалинг нь аваад явчихдаг. Аймгуудын хувьд хэрвээ үйлдвэртэй, уурхайтай бол цалин нь ахиад явчихдаг. Хөдөө орон нутгийн хувьд ч гэсэндээ бас харилцан адилгүй ийм болчихсон. Тэгэхээр бид нар цалингийн тогтолцоо дээр эргэж харах хэрэгтэй байна. Ахиад бүүр цаашлах юм бол цалингийнхаа бүтэц дээр бид нар эргэж харах хэрэгтэй байна. Үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсний харьцаа алдагдчихсан. Энийгээ бид нар эргэж харахгүй бол өнөөдөр шулуухандаа хэлэхэд шинэ тутам яг хөдөлмөр дээр гараад л шинэ тутам ажил хөдөлмөрт орж байгаа залуучуудын цалин хамгийн бага. Олон жил ажиллачихсан хүмүүсийн цалин хамгийн өндөр болоод явчихаад ийм харилцан адилгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр яаж залуучуудын орон гэхээд дөнгөж хөдөлмөрийнхөө гараагаа эхэлж байгаа цалин нь жишээлэх юм бол багш гэхэд чинь 1 сая 480 мянган төгрөгөөр, эмч байлаа гэхэд чинь 1 сая 460 мянган төгрөгөөр яаж ажлынхаа гарааг эхлээд амьдралаа аваад явах вэ. Тийм ээ. Тэгэхээр бид нар бол цалингийн бүтцээ зайлшгүй өөрчлөх болчихоод байгаа юм. Энэ дээр гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ цалингийн тогтолцоог шинэчлэх тал дээр ер нь ямар бодлого баримталж байгаа юм. Би энэ .../минут дуусав/

Х.Ганхуяг: Чинбүрэн сайдын микрофон өгье.

Ж.Чинбүрэн: Ер нь бол Их Хурлын гишүүдээс эмч, багш нарын цалин, эмнэлгийн байгууллагын ажилтны, эрүүл мэндийн салбарын ажилтны цалинг нэмэхгүй гэсэн 1 ч хүн байхгүй нь бол ойлгомжтой. Бүгд дэмжиж байгаа. Тэгээд та бас чухал зүйлийг хөндлөө.

Энэ ДНБ-ий 24 хувийн ийм хязгаарыг 30 хүртэл байх хуулиар боломжтой төсвийн тухай хуулиар. Тэгэхээр өнөөдөр энэ төсөв хэлэлцэж байгаа Их Хурлын өөрийн бүрэн эрхийн хүрээнд бид бас Засгийн газрын хэмжээндээ Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Зарлагын хяналтын дэд хороо зэрэг дарга нартай ярилцаад, Занданшатар дарга бас хамтарч ярилцаад хэдүүлээ яаж энэ 24 гэдгийг дээшлүүлэх вэ гэдгийг ярилцаж тохирсон. Энэ хүрээндээ боловсрол болон эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин мөн тэтгэвэр авч байгаа ахмадуудын тэтгэврийг 2 хувь нэмж байгаа шүү дээ. Нийтдээ 8 хувь болж байгаа инфляцтай уялдуулаад. Энэ бүх тоонууд эндээс гарсан шүү. Тэгэхээр одоо Их Хурал дээр бид

энэ босгоо нэмэгдүүлж чадвал энэ хэмжээгээрээ бас өшөө ч бас тэлэх боломж. Тэгэхдээ нөгөө талдаа бас орлогоо .../минут дуусав/

Х.Ганхуяг: 4 номер.

Л.Мөнхзул: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. Ганцхан эмч, багш гэлтгүй нийт төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх үндсэн шаардлага бий. Тухайлбал соёлын салбарт ажиллаж байгаа төрийн албан хаагчид хамгийн бага цалин хөлс авдаг. Улсын хэмжээнд. Бид төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэхийн тулд бүтээмжийн асуудал 1 дүгээрт, 2 дугаарт төрийн албан хаагчийн нийт тоог зохистой хэмжээнд байлгах асуудлыг 1 дүгээрт шийдвэрлэх ёстой.

2 дугаарт мөн таны хэлсэнтэй бол санал нэг байна. Төрийн албан хаагчийн цалин хөлсний үндсэн бүтцэд үндсэн цалин илүү бага хувийн 50 хувь нь болчхоод бусад нэмэгдлүүд төдийлөн өндөр хувь болчхоод байна. Тэгэхээр бусад орнуудын жишгээр бол ерөөсөө хөдөлмөрийн хөлсний хэмжээг цагийн хөлсөөр тооцоод, нийт ажилласан хугацаанд ноогдох цалин хөлс маань л аваад явдаг /минут дуусав/

Х.Ганхуяг: Нэмээд 1 минут өгье.

Л.Мөнхзул: Тэгэхээр цаашид бид яах ёстой юм бэ гэхээр нийт төрийн албан хаагчдын тоог зохистой түвшинд барих асуудал, бүтээмжийг нь нэмэгдүүлэх асуудал, 2 дугаарт төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдыг нийтлэг үйлчилгээний төрийн үйлчилгээний албан хаагчдаас тусад нь ялгаатай авч үзэж, цалин хөлсний ялгаатай бодлогыг баримтлах шаардлага илүү байгаа юм. Тэгэхээр энэ энэ маань Төрийн албаны хуулийн шинэчлэл рүү орж байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр ажлын хэсэг байгуулагдсан. Нийт төрийн албан хаагчдын нэгдсэн цалин хөлсний хуультай болох, салбар болгон тухайлсан зохицуулалтаар нэмэгдүүлэх байдлаар цалингаа хэн илүү өгөх хөөцөлдсөн нь өндөр болгохоос илүүтэй, илүү хөдөлмөрийн үнэлэмжид нийцсэн байдлаар цалин хөлсний тогтолцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа. Дээрээс нь энэ дурдагдахгүй байгаа асуудал бол хоол, унааны мөнгө гэж төрийн албан хаагчид авдаг. Энэ мөнгөний хэмжээ харилцан адилгүй байдаг. Энэ нь бас цалин хөлсний ялгаатай байдлыг бий болгож байгаа. Тэгэхээр хоол, унааны зардал гэх зардлыг бол цаашдаа үндсэн .../минут дуусав/

Х.Ганхуяг: Галбадрах гишүүний микрофон өгье.

Ж.Галбадрах: Энэ өдрийн мэндийг та бүхэндээ хүргэе. Юуны түрүүнд талбай дээр жагсаж, ажил хаясан эмч, багш нараасаа уучлалт гуйж байна. Цалинг нэмэхийг, ажлын хэсэг байгуулахыг бол бүрэн дэмжиж байгаа. Гарын үсгээ ч зурсан байгаа. Гишүүдийн хэлж байгаачлан цалингийн нэгдсэн бодлогыг Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хангамжийн яам, Боловсролын яам, Сангийн яам хамтраад, сайн сууж байгаад гаргах хэрэгтэй. Энэ олон жил ингээд угшиж явж ирснээс л энэ асуудал маань ийм болчхоод байна. Инфляцынхаа хурдыг гүйцэхгүй цалин нэмээд ч амьдралд нь ямар ч өөрчлөлт авчрахгүй ийм л юм болчхоод байна.

Тийм учраас бид нар одоо яг энэ яригдаж байгаа үед бол нийгмийн салбаруудыг бас сайн нэмье гэдэг тал дээр бол байж байна. Тэгээд цалингийн талаар олон хүнтэй санал давхацсан. Та бүхэн маань тооцоогоо сайн гаргаад, 3 талаасаа суугаад, тэр багш нарт, эмч нарт, үйлдвэрчний эвлэл, холбооныхонд

тайлбарлаж ойлголцоод, яаралтай шийдэлд хүрэх хэрэгтэй байна гэдгийг юуны түрүүнд хэлмээр байна. Тэр гарцаа олсон уу. Яаж ярих гэж байна вэ гэдгийг би бас асууя гэж бодож байна.

Нөгөө талаас боловсролын салбарт тулгамдаад байгаа асуудлуудаа эрэмбэлсэн үү гэдгийг Боловсролын яамнаас ахин асууя. Эрэмбэлээд 5-ыг хэлээд өгөөч. Тэгээд бид бол цалинг л өнөөдөр их ярьж байна. Үнэхээр ярих ёстой сэдэв. Тэгээд цалинг нэмчихвэл бүх асуудал шийдэгдэх үү гэдэг байдлаас нь та бүхэн бас нэг тайлбар өгөөч. Бид уг нь 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгож зарлуулсан. Тэгээд тэр үедээ асуудлыг бол бид нар их цогцоор нь авч үзэж ярьж байсан. Сургуулийн хүртээмжийн асуудал ярьсан. Багшийн хомсдолыг ярьсан. Сурагчдын төлөвшил хүмүүжлийн асуудлыг, сургуулийн соёл, сургуулийн бие даасан байдал, багшийн үнэлэмж, нэр хүндийн асуудал, мэргэжил дээшлүүлэх, эцэг эх олон нийттэй харилцах гээд бүх талаас нь бид нар ярьж байсан. Тэгээд энийгээ бас энд давхар ярьж явах хэрэгтэй байна. Тэгж байж цогц бодлого болно. Тэгж байж боловсролыг дэмжих жил болгосны маань хэрэг гарах ёстой. Даанч энэ талын зүйл бол төсөвт огт суугаагүй байгаа шүү. Тэгээд үр дүнгүй яриа л болоод байна гэсэн үг байна. Ийм байхад салбар бол шинэчлэгдэхгүй, улмаар Монгол орон хөгжихгүй. Бид нар хүнээ хөгжүүлж байж боловсролоо чанаржуулж байж л шинэчлэлд хүрэх учиртай. Энийг бас тайлбар авъя гэж бодож байна.

Тэгээд бид нарын бас маш том ярих ёстой нэг зүйл бол Монгол Улсын иргэд маань хүүхэд багачууд гэлгүй томчуудаасаа эхлээд бүгдээрээ ёс суртахууны доройтолд орсныг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Тийм ёс зүй, ёс суртахууны доройтлоос юу гарах вэ гэвэл боловсролын салбар /минут дуусав/

Х.Ганхуяг: Хариултаа авч дууссан уу, дуусаагүй байна уу. Баярлалаа. Баатархүү гишүүн. Өө дуусаагүй байгаа юм уу. Хэн хариулах юм. Гараа өргөөрэй. 2 номер.

Х.Батжаргал: Боловсролын яам Батжаргал. Гишүүний сүүлийн асуултаас хариулъя. Тэгэхээр бодлогын арга хэмжээ тулгамдсан асуудлыг бас эрэмбэлээд үзвэл мэдээж хүний хөгжил дотроо багшийн асуудал тэр дотроо цалингийн асуудал бол мэдээж яах аргагүй эрэмбийн хамгийн эхний асуудал. Ер нь бол чанар ба хүртээмжийн асуудал боловсролын салбарт бол ер нь яг хосоор нь хоёуланг нь зэрэгцээ авч явах зайлшгүй шаардлагатай. Хүртээмж талдаа бол мэдээж хөрөнгө оруулалтын асуудал бол зайлшгүй хүртээмж байж байж хангалттай тэгш хүртээмжтэй байж чанарын асуудалд бас шууд нөлөөлнө. Сургалтын орчин нөлөөлнө. Тэгэхээр шинэчилсэн Боловсролын багц хуулийн үр дүнд бол хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр бол мэдээж засаглалын асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлээд, хэрэгжилт хангагдаад явж байна. Санхүүжилтийн механизм үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн энэ асуудлыг улам боловсронгуй болгох асуудал байгаа.

Мөн түүнчлэн хөтөлбөрийн шинэчлэлийн асуудал бас тулгамдсан асуудлын нэг бол яах аргагүй мөн. Энэ хүрээндээ бас хөтөлбөрийн шинэчлэлийг бол шат болгонд нь үе шаттайгаар шинэчлээд, хэрэгжүүлээд ингээд явж байна. Үнэлгээний асуудал байдаг. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээний асуудал бол бас аргачлалыг илүү боловсронгуй болгох, илүү технологид суурилсан шинэ технологийг ашиглах энэ асуудал бол бас тулгамдсан асуудлын нэг яах аргагүй мөн. Энэ хүрээндээ бас цахим шилжилт, цахим шилжилтийн хүрээнд бас багш нарынхаа ачааллыг бууруулах, хөнгөвчлөх, нөгөөтээгүүр бас орчин цагийн

техник технологийг бас чадамжийг суурилж эзэмшүүлэх асуудлууд бол тулгамдаж байгаа. Ингээд эхний таны хэлсэнчлэн 5 асуудал бол энэ хүрээнд байна.

Х.Ганхуяг: Болчихсон уу. Хариулт хангалттай юу. Нэмж хэн хариулах юм. Хариуг нь гүйцэд өгнө шүү. Нэмээд Галбадрах гишүүний микрофон өгье.

Ж.Галбадрах: Төрийн нарийн бичгийн даргад баярлалаа. Тэгээд сая би яг төгсгөлд нь асууж байлаа. Монгол Улсын иргэдийн маань, ялангуяа суралцагчид, багш нарын ёс суртахууны асуудал дээр бид нар ямар ажлууд хийж байна. Энийг удирдаж авч явах тэр салбарын хүний нөөцийг хэрхэн бэлдэж байна. Тэр хүмүүсийн цалин зардал сэтгэл зүйч, нийгмийн ажилтнаас эхлээд энэ цалин зардал нь төсөвт хэр туссан байгаа вэ. Хангалттай орон тоогоороо тусаж чадсан байгаа юу гэдэг асуудлыг асууя.

Тэгээд ирэх жилийн боловсрол би энийг бас яг бүр энд бичүүлж авмаар байна. Ирэх жилийн боловсролын жил, боловсролыг дэмжих жил болгосны хамгийн гол одоо бид нар энэ багш нарын асуудлыг шийдье, тэр хөрөнгө оруулалтаар зүйл шийдье гэхээс гадна боловсролд хийгдэх томоохон шинэчлэл нь яг юу байж болно гэж үзэж байгаа вэ гэдгийг асууя.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм. 2 номер.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж хариулъя. Тэгэхээр энэ боловсролын салбарт зөвхөн багш нараас гадна ажиллаж байгаа албан хаагчид, сэтгэл зүйчид, нийгмийн ажилтан гэх мэт бусад албан хаагчдын бас цалин тэтгэмжийн асуудал хувьсах зардлаараа дамжуулаад олгогдохоор бол тооцоологдсон байдаг. үүн дотроо ёс зүй, хүүхдийн хамгаалал, сургалтын орчин дахь дээрэлхэл, ялангуяа сүүлийн үед яригдаад байгаа цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал гэх мэт зардлууд бол хувьсах зардлынхаа хэмжээнд ангилал дотроо бол багтаад тааруулагдаад явж байгаа. Тэгэхээр үндсэндээ бол хувьсах зардал маань 1 хүүхдэд ноогдох буюу 2,3 сая төгрөг байгаа. Тэгэхээр энэ хэмжээндээ хүүхдийнхээ тоогоор үржигдээд төсвийн төсөлд туссан байгаа.

Х.Ганбаатар: Баатархүү гишүүн асуултаа асууя.

Ц.Баатархүү: Сайн байцгаана уу. Би 3 зүйлийг л асуух юм уу, хэлэх юм уу. Ер нь энэ хариулж байгаа Төрийн нарийн бичгийн дарга нар, энэ яамнууд 1 зүйл дээр анхаармаар байгаа юм. Энэ салбар энэ цалин хөлсний бодлогын бичиг баримт гэж угаасаа байсан байлгүй дээ. Ингээд байгаагүй юм шиг ингээд өөр өөрийнхөөрөө хариулаад байдаг.

Миний ойлгож байгаагаар хөдөлмөрийн бодлого, төрийн санхүүгийн бодлого энэ 2 нийлээд төрийн албаны бодлого болоод явж байгаа гэж бодож байна. Одоо Төрийн албаны хууль ингээд шинэчлэгдэнэ. Төрийн албан хаагчдын цалингийн бодлого шинэчлэгдэнэ шүү дээ. Тэгээд бодлогын хүрээнд хэзээ, ямар үед цалин хөлсөө нэмэх юм бэ гэдгээ ярихгүй бол нэг ийм сонгуулийн циклээр нэмдэг энэ байдлыг таслан зогсоох хэрэгтэй. Ийм хариулт өгч байна.

2 дугаар өгч байгаа хариулт бол жил болгоны инфляцтай уялдуулна гэдэг энэ үгээ боль. Инфляц гэдэг бол мөнгө үнэгүйдэж байгаа хэлбэр байхгүй юу. Худалдан авах чадвар буурч байгаа хэлбэр гэдэг ийм ойлголт руу явж байна шүү дээ. Тэр тэтгэврийн философи ч гэсэн буруу байна лээ шүү дээ. Инфляцтай уялдуулж

тэтгэвэр нэмнэ гэдэг чинь мөнгө үнэгүйдэх юм бол таны тэтгэврийг нэмнэ. Нэмээд ч үр дүнгүй гэдэг философи явж байгаа байхгүй юу. Тэгэхээр хөдөлмөр, ажил эрхлэлтийн философи гэдгийг бид нар ойлгомоор байна л даа. Тэгээд 3 янзын философи байна.

1 дүгээрт энэ төрийн албаны цалинг тухайн салбарын дундажтай харьцуулах Азийн улс орны бодлого байна. Өнөөдөр Монголын хамгийн шилдэг мэргэжилтнүүд гаднын компанид ажил хийхээр гадагшаа явж байна. Тархи урсаж байна. Төрийн албанд ажиллаж байгаа чадварлаг эмч нар, инженерүүд, багш нар хувийн хэвшлийн сургууль руу ажиллаж байна л даа. Энэ юу илэрхийлж байна вэ гэхээр бодлого буруу байгааг илэрхийлж байгаа. Тэгэхээр яадаг вэ гэхээр үндсэн цалин гэдгийг бол төрийн албаны цалингийн индексээр бодоод, тэр нэмэгдлүүдийг тухайн салбарын хувийн хэвшлийн дундажтай уялдуулах хэрэгтэй шүү дээ. Өнөөдөр хамгийн өндөр цалинтай зах зээл дээр уул уурхай, IT-ийн инженерүүд байна шүү дээ. Яг төрийн албаны цалингаар энэ хүмүүс ажилд орохгүй шүү дээ. Кибер аюулгүй байдлыг яам болгон дээр ийм мэргэжилтэн ав гэхээр орохгүй шүү дээ. Зах зээлийн дундаж цалин чинь тухайн салбарт өөр байхаар төрийн албанд ирж ажиллахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр тухайн салбарын зах зээлийн хувийн хэвшлийн дунджийг яаж тооцох юм бэ гэдэг энэ бодлогыг оруулж ирж байж төрийн албанд, төрийн сургуульд, эрүүл мэндийн байгууллагад хамгийн сайн эмч нар ажиллах энэ боломж бүрдэнэ.

Тэгэхээр өнөөдрийн энэ гарч байгаа ажлын хэсэг бол асуудлыг гал унтраах биш, цогцоор нь харсан төрийн албаны реформ Төрийн албаны хуультай уялдуулж энэ цалингийн бодлогыг оруулж ирээсэй гэж бодож байгаа.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм. Тодруулъя. 1 минут.

Ц.Баатархүү: Дараагийн зүйл нь Хэрлэн гишүүнтэй бас санал 1 байна. Залуучууд шинээр төрийн албанд орох боломж, залуучуудыг татах бодлого ерөөсөө байхгүй байна. Өнөөдөр нийслэлийн сургуулийн багш нарын авч байгаа цалин дээд цалин, доод цалин 2-ын зөрөө нь 2,5 дахин зөрүүтэй байна. 1 сая 480 мянгаар сургуульд багшаар шинээр орох хүмүүс олдохгүй байна. Тэгэхээр шинээр энэ эрүүл мэндийн салбар, боловсролын салбарт шинэ хүний нөөцийг татах бодлогыг энэ цалингийн бодлого дээр оруулах хэрэгтэй байна гэдгийг хэлье.

Тэгээд цалин нэмэгдүүлэх энэ эмч нарын, багш нарын энэ шаардлага бол зөв. Тэгээд энийг гэнэтхэн ингээд сонгуультай уялдуулж нэмдэг биш, тогтвортой индекс, зах зээл, хувийн хэвшил, хөдөлмөрийн бүтээмж .../минут дуусав/

Х.Ганхуяг: Үг хэлчихсэн үү. Баярлалаа. Алтаншагай гишүүнийн микрофон өгье.

Н.Алтаншагай: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тодруулах, асуух хэдэн зүйлүүд байна. Төсөв ярихаар л энэ цалин, тэтгэвэр нэмэх гээд нэг ийм улирлын шинж чанартай болчихсон юм байгаа юм. Тэгэхээр энэ бодлого ерөнхийдөө цаашдаа маш тууштай явж байж энэ цалин тэтгэвэр, нийгмийн хүртээмжийн асуудлууд шийдэгдээд явна. Засгийн газраас боловсролын салбарт 20 хувь, эмч нарын цалинг 15, тэтгэврийг 8 хувь нэмэх саналтай байна гэж ойлгосон. Хэрвээ ийм шийдэл гаргаж байгаа бол бусад салбарынхаа цалин, орлогыг яаж нэмэгдүүлэх юм бэ. Шинжлэх ухааны байгууллага, соёл, спортын салбар байна. Цэрэг хүчний цагдаа, төрийн захиргааны байгууллагуудын цалин нэмэгдэж байгаа юм уу яг бодитоор. Энэ дээр онцгойлон анхаарч хариулт авъя.

Дараачийнх нь Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн захиргааны энэ төрийн албан хаагчдын цалин дээр нэмэгдэл гэж салбараасаа хамаараад 3-8 төрлийн нэмэгдлийг олгож байгаа. Энийгээ зарим нэмэгдлүүдээ эргэн харж цалин дээр нь шингээж, үндсэн цалинг нэмэгдүүлэх тийм боломж хэр байгаа юм бэ. Энэ гишүүд яриад байна. Дөнгөж сургуулиа төгссөн энэ залуучууд маань ажлын байранд гараад энэ олон нэмэгдлүүдийг авч чадахгүй. 1 сая 480 мянган төгрөгөөр цалинжаад л явна. Тэгэхээр энэ дээр бас харгалзаж үзэх нь зүйтэй байх.

Засгийн газраас энэ олон төрлийн иргэдийн бухимдалтай холбоотой цалин, тэтгэвэртэй холбоотой уулзалтууд хийсэн бол ахмадуудын гол хүсээд байгаа юм бас энэ тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх гэж байгаа юм. Хувь тэнцүүлж нэмэгдүүлэхээсээ илүү тэтгэврийнхээ доод хэмжээг нэмэгдүүлэе гэсэн ийм бас саналтай ахмадууд их байгаа шүү гэдгийг бас та бүхэнд уламжилъя. Тэгээд саяын дээр дурдсан зүйлүүд дээр хариулт авъя.

Х.Ганхуяг: Чинбүрэн сайдын микрофон өгье.

Ж.Чинбүрэн: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Ялангуяа эрүүл мэндийн салбар бол нэмэгдлүүд олон төрлийн нэмэгдэл байдаг. Үүгээр дамжуулж бид үйл ажиллагаа хийх, тэдгээрт урам зориг өгөх энэ гол үнэлэмжийг нэмэгдүүлэх асуудал нь орж байдаг. Тухайлах юм бол ажилласан жилийн нэмэгдэл, тэгээд жижүүрт хоносон, илүү цаг, хортой нөхцөл, тэгээд орон нутгийн нэмэгдлүүд гээд энэ болгон бол салбарын гол асуудал. Тэгэхээр бид өнөөдөр 15 хувь үндсэн цалин нэмэгдүүлнэ гэдэг нь эдгээрийг хувилаад бодохоор нөгөө дагалдах нэмэгдлүүд нь нэмэгдээд ойролцоогоор 400-800 мянган төгрөгөөр нэмэгдэхээр байгаа юм. Зүгээр энэ олгож байгаа нэмэгдлийг нь яагаад ч бид хасаж болохгүй. Яагаад ч хасаж болохгүй. Харин үндсэн цалинг нь нэмэгдүүлж, дагалдах нэмэгдлүүд нь өшөө улам их байгаасай л гэж зорьж байгаа. Гэхдээ энд бол бас та бүхэн өөрсдөө мэдэж байгаа Их Хурлын гишүүдийн хувьд. Ер нь бол бид орлоготой байх. Орлого эх орныхоо эдийн засгийг нэмэгдүүлээд, орлого нэмэгдэх л юм бол энэ олон зүйлүүд нэмэгдэх боломжууд байгаа. Тухайлах юм бол бид эрүүл мэндийн салбарт Эрүүл мэндийн даатгалаар дамжуулж цалин олгодог учраас даатгалын нэмэгдүүлэх бас нэг боломж бол энэ баялгийн сантай холбоотой баялгийн хуримтлалын сангаас Эрүүл мэндийн даатгалын хувийг нэмэгдүүлэх боломж байгаа талаар бас судалгаанууд хийж, энд бол яалт ч үгүй л Их Хурлын гишүүд та бүгдийн хууль шинэчлэх, өөрчлөх, нэмэлт оруулахтай холбоотой үйл ажиллагаа гарах учраас энэ дээр бас анхаарахаас өөр аргагүй болох юм.

Тийм учраас эрүүл мэндийн салбарын ажилчдын энэ олон төрлийн нэмэгдлүүд нь нөгөө талаасаа бас урам зориг өгч, ажлын үнэ цэнийг нэмэгдүүлж, дээр нь туршлага илүү болгох, бас түрүүн Саранчулуун гишүүн ярьж байсан. Орон нутагт ажиллах эмчийн хүслийг нэмэгдүүлэх энэ чиглэлд хүртэл нөлөөлж байгаа. Тухайлах юм бол өнгөрсөн хугацаанд аймагт ажиллахад 20 хувь, орон нутагт ажиллахад 40 хувь гээд хувьчилж нэмэгдүүлсэн нь өөрөө орон нутгуудад ажиллах эмч дутагдаж байгаа эмнэлгийн ажилчдын бид ганцхан эмч биш шүү энэ бол эмнэлгийн ажилчид, сувилагчид, ялангуяа тэр дотроо сувилагчийн асуудал бол бүр онцгой тулгамдаж байгаа асуудал байгаа. Тийм учраас сувилагч нарын цалинг нэмэх асуудал бол Эрүүл мэндийн яамны том бодлогын нэгээхэн хэсэг байгаа юм.

Тэгээд энэ нэмэгдлүүдийг нэмэх том гаргалгаа бол ерөөсөө л үндсэн цалин нэмэгдүүлж, энэ тооцоолж пропорцолж бодож байгаа зүйлүүд нь нэмэгдэх нь л чухал.

Х.Ганхуяг: Ганзориг гишүүн асуултаа асууя. Тодруулах юм уу. Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Бусад салбарын цалин нэмэгдэж байгаа юу гэж би асуусан шүү дээ. Хүчний байгууллага, төрийн захиргааны байгууллагуудын цалин хөлс нэмэгдэж байгаа юу гэж. Энэ дээр тайлбар авъя. Дараа нь үг хэлнэ.

Х.Ганхуяг: Бусад төрийн албан хаагчдын цалинг 4 номер хариулах уу.

Л.Мөнхзул: Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөл дээр бол төрийн албан хаагч, нийт төрийн албан хаагчдын цалинг нэмэхгүйгээр төсвийн төсөлд орж ирсэн. Зөвхөн тэтгэврийн доод хэмжээ болон бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөл өргөн баригдсан.

Х.Ганхуяг: Нэмээд 1 минут өгье.

Н.Алтаншагай: Ингээд л яг орхигдож л байгаа юм. Цагдаа, онцгой, төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчид ингээд л яг урдаас нь гарсан юм уу, ардаас нь гарсан юм уу гэдэг шиг ингээд л орхигдож байгаа асуудал үүсэж байгаа юм. Ингээд хувийн сургуулиудын багш нарын цалин ер нь 3,5-аас дээш байна шүү. Захын гэр хорооллоор байгаа энэ хими, физикийн аль олигтой, өөдтэй, чадалтай багш нар нь бүгд хувийн сургууль руу шилжсэн. Хими, физикийн багш байхгүй ийм сургуулиуд ч байж байгаа. Энийгээ эргэн харахгүй бол Боловсролын яам. Дээр нь нөгөө 5, 3 жилийн нэмэгдэл орон нутагт гээд байдаг. Энийг бас Нийслэлийн багш нарт олгооч ээ гэж бас хүсэж байгаа. Би өмнө нь бас илэрхийлж л байсан. Ачаалал нь яг адилхан шүү дээ. Хөдөө орон нутгаас бараг л илүү шүү.

Х.Ганхуяг: Ганзориг гишүүний микрофон өгье.

П.Ганзориг: Нэмэлт минут авч байгаад хэдэн үг хэлье. Ер нь өнгөрсөн хугацаанд Монгол Улсын төр засаг бодлогын том алдаа гаргаж, хүний хөгжлийн асуудлаа орхигдуулж ирсэн. Өнөөдөр багш, эмч нарын цалинг нэмэх гэж байгаа асуудал ярьж байгаа хэдий ч цаанаа Монгол Улс хөгжлийнхөө бодлогыг яаж харж байгаа юм, хүн рүүгээ хөрөнгө оруулалт хийх юм уу, үгүй юу, хүнийхээ хөгжлийг анхаарах юм уу, үгүй юу. Эрүүл Монгол хүн, Боловсролтой Монгол хүн байх юм уу, үгүй юу. Монгол Улсын хөгжлийг цаашид хэн авч явна, юу авч явна гэж харж байгаа юм. Үүнтэй шууд холбоотой асуудал. Тэгэхээр өнгөрсөн хугацаандаа бол яалт ч үгүй энэ хүний хөгжлийн асуудлууд, хүн рүүгээ хийх хөрөнгө оруулалтууд хаягдаж, бид нар нөгөө уул уурхайгаа л ярьсаар ирсэн. Асар их баялагтай 3,5 сая хүн амтай. Тэгэхдээ 3,5 сая хүн ам нь маш олон асуудалд амьдарч байгаа.

Нөгөө байгалийн баялгаа гаднынханд үр ашиггүй ашиглуулна. Тухайлбал Оюутолгойн гэрээ гэхэд байгалийн баялгаа ашиглуулаад, дээр нь өрөнд ороод сууж байгаа шүү дээ Монгол Улс. Зээлийн хүүгийн дарамтад ороод сууж байгаа. Жилд 1,3 тэрбум долларын өр нэмэгдэж байгаа. Энэ гэхэд чинь 5 их наяд төгрөг. Жил болгон 5 их наяд төгрөгийн өр нэмэгдэж байгаа. Энэ хүүг буурууллаа гэхэд багадаа л 500 сая доллароор хүүг буурууллаа гэхэд л жил болгон 30 хувиар бүх багш нар, эмч нарын цалинг нэмээд шийдчих боломжтой мөнгө.

Тэгэхээр ийм байдлаар бид нар бол хүний хөгжлийн асуудлаа хаяж ирсэн. Өнгөрсөн хугацаанд бас мөн байгалийн баялагтай холбоотой ЖДҮ хулгай, Хөгжлийн банкны хулгай, Нүүрсний хулгай, оффтейк гээд хэдэн 10, 100 их наядаар

бид нар төсвийн мөнгөө хулгайлж ирсэн. Тэгээд үүгээрээ цалингаа хэд дахин өсгөчих, 1 мянган доллар биш шүү. 2, 3 мянган доллар хүргэчих ийм боломжууд байсан. Өнөөдөр хүсээгүй болохоор хийгээгүй.

Тэгээд энэ Монгол Улсын чинь цаашид гол баялаг, эрхэм дээд баялаг нь хүн юм бол, хөгжил дэвшлийг бүтээгч нь хүн юм бол, энэ эх орны эзэд нь хүн юм бол энэ хүн рүүгээ чиглэсэн хөрөнгө оруулалтаа анхаарч явах ёстой. Тэгээд ганцхан жилийн төсөв дээр ярих биш, ер нь бол зоримог шийдэл гаргаж, урт, дунд хугацаанд энэ хүний хөгжлийн асуудлуудаа, хүн рүүгээ чиглүүлсэн хөрөнгө оруулалтуудаа яаж хийх юм бэ гэдгээ шийдэх нь чухал байна. Тэгээд бүгд гишүүд дэмжиж үг хэлж байна. Тэгэхдээ 1 шийдэл хэрэгтэй энэ дээр.

Тухайлбал, Засгийн газар сая 2026 оны төсөв оруулж ирэхдээ уул уурхайн салбар хүндэрч байна гээд тодорхой цөөхөн хэдэн компани дээр АМНАТ-ийн хөнгөлөлт гээд л хэдэн 100 тэрбумаар үзүүлэхээр тогтоол гаргаад л явж байгаа шүү дээ. Тэгээд 1 компанид, 1 хэсэг компанид болохоор хэдэн 100 тэрбумын хөнгөлөлт үзүүлж болоод, 90 мянган хүн ажиллаж байгаа энэ салбарт яагаад цалин хөлс, цаана нь хэдэн 100 мянган хүний аж амьдралтай холбоотой асуудал дээр шийдэж болдоггүй юм бэ. Энэ дээр бол Засгийн газар бас өөрсдөө бодолцож хандах ёстой гэж бодож байна.

Х.Ганхуяг: 2 гишүүний дараа санал хураалт хийгдэнэ. Гишүүдээ дуудаарай ажлын албаныхан. Тэгээд Засгийн газраас Улсын Их Хурлын мэдэлд төсөв ирчихсэн байгаа. Тэгэхээр тийм учраас ажлын хэсэг дээрээ санал хураалтуудаа, саналуудаа дэвшүүлээд явна шүү гишүүд ээ. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Би бас яг л Ганзориг гишүүн шиг бас юмыг жоохон далайцтай харъя л гэдэг санал хэлэх гээд байгаа юм. Баахан боловсролын жил гэж ярьсан, хүн бол Монгол хүний асуудал бол бид нарын мега төсөл гэсэн мөртөө дээрээс нь төсвийг өргөн барихдаа олон нийтээр хэлэлцүүлж, боловсролын асуудлыг тэргүүн ээлжид тавьж байна гэсэн мөртөө энд оролцож байгаа багш нарын асуудал дээрээ цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй гэдэг бодлогыг барьж орж ирсэн нь ерөөсөө л зүгээр улс төрийн лоозон, пи ар байжээ л гэдгийг харуулаад байгаа юм.

Тэгэхээр энийг бодитой, бас тогтолцооны хувьд бас авч үзмээр байгаа юм. Тэгээд яах вэ, ингээд багш, эмч нар буюу 2 тусдаа зүйлийг өргөдөл гаргагч маань 1 тавьчихаж. Тэгэхдээ энийг Төсвийн байнгын хороо руу шилжүүлэх юм байна гэж ойлголоо. Тэгэхгүй бол 2 тусдаа явах ёстой. 1 нь бол гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаа Эрүүл мэндийн даатгалын сангаас явж байгаа. Сан маань одоогоор бол төсвөөс буюу Улсын Их Хурал хэрхэн мөнгө тавьж өгөхөөс гадна ер нь зүгээр Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогоор явж байгаа шүү дээ. Гэтэл багш нарын асуудал бол цэвэр улсын төсвөөс хамааралтай байхгүй юу. Хэрэв энэ асуудлуудыг хольж ажлын хэсэг гаргаж байгаа бол болохгүй шүү гэдэг санал байсан. Би сая Ганхуяг даргаас тодруулсан. Төсвийн ажлын хэсэг рүү шилжүүлнэ гэж ойлгосон. Энийгээ та баталгаажуулаад хэлээрэй.

1 удаагийн шийдэл яах вэ, 1 удаагийн шийдэл ч гэсэн таалагдахгүй байгаа. Одоо бүх сайд нарын урсгал зардлаас 10 хувийг танана гэж байгаа. Тэгээд энэ дунд нь бас 1 салбарын асуудал нь хохирчих вий дээ. 1 асуудал шийдэх гэж байгаад нөгөө асуудал. Тэгэхээр ерөөсөө юмыг ултай суурьтай шийдэх асуудал үүний цаана харагдаад байгаа юм.

2 дугаарт яах вэ сая Ганхуяг дарга 3 талт хэлэлцээр буюу хэлэлцээрийн асуудлаа шийдээд ороод ир. Ганхуяг дарга аа, мөнгө байхгүй. Мянга хэлэлцээр хийлгүүлээд яах гэж байгаа юм. Тийм учраас яаж үүний санхүүжилтийг хаанаас олох вэ гэдэг эх үүсвэрүүдийг маш бодитой бид нар яримаар байна. Би бол энэ багш нарын асуудал дээр бол тийм тусдаа Засгийн газрын тусгай сан гэхээр бас сангийн асуудлаас бүгд айдаг болчихоод байна. Ер нь бол тодорхой хэмжээний Үндсэн хуулийн эрх зүй талаасаа яг сая Ганзориг гишүүний хэлж байгаа шиг хүн бол Монгол Улсын үндсэн хөгжлийн тулгуур үндэс, тэгээд ер нь капитал юм байна гэж үзвэл энэ дээр яг төсвийн хэдэн хувь зарцуулах юм бэ гэдэг яг тодорхой бусад салбаруудтайгаа барьцахгүйгээр шийдчихмээр байна.

Тэгээд энэ дээрээ ямар ч эдийн засаг хүндэрч байсан үед түрүүгээрээ асуудалд хандаад явдаг. Субъектив байдлаар 3 талт хэлэлцээрээр цалин тогтоодог биш, энэ тодорхой яг арга зүйгээр тогтоодог юм байна. Яг хөдөлмөрийн зах зээлийн дүйцүүлж болох тэр салбарын юутай дүйцүүлээд арга зүйгээр цалин хөлсний асуудлаа ярьдаг. Ингээд л 3 талт хэлэлцээр гээд, хэлэлцээр хийж байгаа хүмүүс нь очков авах гээд ч байгаа ч юм шиг эсвэл хэлэлцээр хийж чадсангүй гээд л хамт олондоо загнуулаад л ерөөсөө ингээд л гурвалжин, дөрвөлжин хэрүүл болоод байна шүү дээ. Тэгэхээр түрүүн бас Сангийн яам хариулж байсан. Зарим аймгуудад бол багш нартаа нэмэгдэл олгох бололцоонуудыг өөрсдөө илэрхийлж байгаа гэж байгаа юм. Энэ ямар ямар аймгууд байгаа билээ. Давтаж нэг хэлээч. Ямар эх үүсвэрээс, ямар менежментээр энэ орон нутаг гаргаж ирээд байна. Энийг бусад аймгууд нь яагаад олж харахгүй байна.../минут дуусав/

Х.Ганхуяг: Нэмээд 1 минут өгчихье.

П.Сайнзориг: Сангийн яам маань хариулж өгөөч.

2 дугаарт, жишээ нь хими, физик, байгалийн шинжлэх ухааны багш нар хүрэлцэхгүй бол хэд хэдэн сургууль дээр хөдөлмөрийн гэрээгээр нэгэн зэрэг ажиллаж багшлах боломжийг нь олгомоор байгаа байхгүй юу. Тэгээд “А” гэдэг багш зөвхөн 1 дүгээр сургуулийн л багш байх ёстой юм шиг л хандаад байна. Үнэхээр тэр эрэлттэй багш нарыг тойруулж явдаг, тэр багшийн хичээлүүдийг онлайн байдлаар худалдаж аваад, өнөөдөртөө улсын төсвөөс мөнгийг нь тавиад багш нарынхаа асуудлыг шийдвэл энэ цалин хөлсний ачаалал, дарамтаас бас цэгцэрч чадна даа.

Тэгээд ерөөсөө тогтолцооны хувьд буюу далайцтай юмаа хийхгүй бол ингээд өнөөдөр ингээд шийдэлгүй хэдүүлээ яриад л байдаг. Нөгөө хэд маань гудамжинд, хүйтэнд хэцүү байна шүү дээ. Багш нар маань Тэгээд хий хүлээлтийг үүсгээд байна. Тэгэхээр яг одоо шийдэл яримаар байна хүмүүсээ. Тэрнээс биш энд 20, 30 гишүүн энд үг хэлээд нэмэр алга байна. Шийдлээ ярья. Тийм учраас үнэхээр тэр өндөр ур чадвартай багш нарын мэдлэгийг хуримтлагдсан хичээлүүдийг онлайнд байрлуулах асуудлыг бодитой болгоод худалдаж авах зардлыг нь тавья /минут дуусав/

Х.Ганхуяг: Энэ санал хураалт бол төсвийн ажлын хэсэг рүү шилжүүлэх санал хураалт хийгдэнэ. Энэ дээр тусдаа ажлын хэсэг гаргаад ажиллаж амжихгүй болов уу. Төсөвтэй холбоотой асуудал дээр саналуудаа оруулж амжихгүй болов уу гэж бодож байна. Төсөв бол цаг хугацаатай асуудал байгаа.

Саяын Сайнзориг гишүүний ярьж байгаа асуудал Боловсролын хуулийг бас хөндөх ёстой гэсэн асуудал хөндөгдөж л байна гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бас анхаарна биз Боловсролын сайд. Ганмаа гишүүн асуултаа асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу. Энэ цалин хөлс нэмэхтэй холбоотой 9 сарын 29-нд бид нар Өргөдлийн байнгын хороогоор ярьсан. Өргөдлийн байнгын хороо дээр ярьсан асуудал нь бол бид нар өргөдлөөс буюу Номин гээд иргэнээс цалин нэмэх асуудал байсан. Цалин нэмэх асуудал дээр цалин нэмэх жишээлбэл боломж бололцоо нь юу вэ. Ямар бодлого явж байгаа вэ. Ялангуяа эмч, эмнэлгийн ажилчдын дунд үндсэн цалин нь хэд вэ, голч нь хэд юм бэ гэж асуусан. Тийм ээ. Тэр голч дээрээ би хариултаа авмаар байгаа.

Дээрээс нь би юу гэж хэлсэн бэ гэхээр энэ цалин нэмэгдэхгүйтэй холбоотой эмч, эмнэлгийн ажилчдын нөгөө яаралтай burnout effects байна. Ажлаа хаях асуудлууд гараад байна. Үүнээс болоод ажилчид гарч ирээд суувал яах вэ гэдэг асуулт ярьсан. Тийм ээ. Үүнээс болж нэлээн ч дайралтад өртсөн. Заналхийлэлд. Тэгээд ярилцсаны дараа яг 7 хоногийн дараа эмч нар гадагшаа гараад талбай дээр гарч ирээд суусан. Тухайн үед 9 сарын 30-нд цалин огт нэмэх боломжгүй. Энэ боочихсон төсөв гэж хариулж байснаа, эмч нар гарч ирж заавал сууж байж, ажил хая зарлана гэдэг дээрээ тулж байж 10 хувь нэмэх боломжтой гэдгийг маргаашаас нь эхлээд шууд сайд ярьсан. Тэрний дараа 7 хоногийн дараа болохоор ер нь 10-15 хувиар нэмэх боломжтой гэж ярьсан.

Тэгэхээр эхлээд цалин нэмэх боломжгүй ээ гэж ярьж байсан үндэслэл чинь юу байсан бэ. 10 хувиар нэмнэ гэсэн тооцоолол чинь юу байсан бэ. 15 хувь гэсэн тооцоолол судалгаа чинь юу байсан бэ. Үүнийхээ үндэслэл тооцоог тус бүрд нь хэлж өгнө үү. 1 дүгээрт.

2 дугаарт 10-15 хувиар нэмж байгаа тохиолдолд асрагчийн цалин хэд болох юм. Сувилагчийнх хэд болох юм. Эмч, эмнэлгийн ажилчдынх хэд болох вэ. Үндсэн цалин нь гэсэн утгаар. Түүнээс биш нөгөө тулаа хийж байгаа ч юм уу, 10 жил ажиллачихсан хүмүүс ч юм уу, эмч, эмнэлгийн ажилчдын зөвхөн цалингаар нь яримааргүй байна бүгдээрээ.

Ер нь эцсийн эцэст би яамнаас бодлого л асуугаад байдаг юм. Хүний нөөц буюу энэ эрүүл мэндийн тогтолцооны 6 блокийн 1 чинь энэ хүний нөөц нь өөрөө. Тэд нарын цалин хөлс, бүтээмж, яг энэ дээр ямар бодлого барьж ажиллаж байгаа юм бэ. Энэ цалин хөлсний сүлжээ дээр бодлогын өөрчлөлт орж ирэх үү. Мэдлэг, ур чадвар, мэргэжлийн эрсдэлд суурилсан цалин хөлс рүү шилжих тогтолцоогоо. бодлогоо яаж бодож байгаа юм бэ гэдэг асуудлыг асуугаад байгаа юм. Ялангуяа 3-5 жилийн хугацаанд иргэн бүсийн ойролцоо байгаа юу гэдэг юм бусад улс орныхтой манай эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө нь хэдээс хэдэн хувь дээрээ очоод дөхөх юм бэ гэдэг асуудал дээр эхлээд хариулт авчихъя.

Х.Ганхуяг: Чинбүрэн сайд хариултыг өгье. Түрүүн Сайнзориг гишүүний асуусан асуултад 5 номер нэмээд хариулчхаарай. Чинбүрэн сайдыг микрофон өгөөрэй.

Ж.Чинбүрэн: Төсөв өргөн барих үед бол Засгийн газраас бүх л нөөц боломжоо дайчлаад, орлогуудаа, зарлагуудаа тооцоод, тэгээд төсвийн урсгал зардал, ДНБ-ий 24 хувьд хүргээд ингээд ямар ч байсан бид 2026 ондоо Эрүүл мэндийн даатгалын сан өмнөх жилээс 1 төгрөг ч нэмэгдээгүй. Гэхдээ бид 2025 оныг бодвол 2026 онд 316 тэрбум төгрөгийн даатгалын өнгөрсөн оныхоо өрийг дарахгүйгээр явахад бол бид 10 хувь нэмчихнэ гэсэн ийм тооцоолол надад байсан. Тэрийг би танд хэлсэн.

Тийм учраас бид 2025 оноо өргүй давах, энэ дуусаагүй байгаа учраас бид энэ санхүүгийн сахилга баттай, илүү зардал гаргахгүйгээр яг л шаардлагын тусламж үйлчилгээндээ зөв зохицуулалтаа хийгээд явж чадвал өнгөрсөн оных шиг 400 хэдэн тэрбум төгрөгийн өнгөрсөн оныхоо өрийг дарахгүйгээр явъя л гэсэн ийм зорилго. Тэр дотроос хэмнэж чадах юм бол бид цалин нэмэх боломжтой гэдэг.

Дараа нь бол эрүүл мэндийн ажилчид, үйлдвэрчний эвлэл, багш нартай холбоотой Ерөнхий сайдтай уулзалт хийсэн. Ерөнхий сайдтай уулзалт хийгээд, Ерөнхий сайд ямар ч байсан энэ 2 салбараа дэмжье. Засгийн газарт бусад урсгал зардлаасаа 10 хувийг танаж, цалин хөлсөө нэмэх чиглэл дээр анхаараач ээ гэдэг тооцооллыг хийгээч гэсэн үүрэг өгөөд, энэ үүргийнхээ хүрээнд бас Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, дээрээс нь Зарлагын дэд хороо энэ тэртэй бол уулзаж бид бас ярилцаад, ямар ч байсан 830 тэрбум төгрөг багш, эмнэлгийн ажилчид, ахмад настнуудын цалин, тэтгэврийг нэмэхэд зарцуулъя гэдэг тооцоолол гараад, 181 тэрбум төгрөг эрүүл мэндийн салбарт үндсэн цалин шүү, үндсэн цалин. Тухайлах юм бол таны асууж байгаагаар бол ТҮМ-1 зэрэглэлийн хүмүүс 1 ангилалд байгаа ажилчид үндсэн цалин бол 1 сая 166 мянган төгрөг байгаа. Энэ 15 хувиар нэмэгдэнэ. Дагаад ажилласан жил, дээрээс нь хортой нөхцөл, хаана ажиллаж байгаагаасаа хамаараад нэмэгдлүүд нь үндсэн цалингаасаа уялдаад явахаар ойролцоогоор 200-400, зарим тохиолдолд бүр 800 мянган төгрөг хүртэл нэмэгдэх ийм боломж байна. Энэ тооцооллуудыг ингээд тооны машин дээр хийгээд үзэх юм бол 1 сая 400-1 сая 500 мянга болох нь гэж харагдаж байна. Яг таны асуусан ТҮМ-1 ангиллыг би сая хэлсэн шүү. Зэрэглэлийг хэлсэн шүү. Ийм байна.

Ер нь бол бид гүйцэтгэлийн санхүүжилт гэдэг маань зөвхөн гүйцэтгээд зогсохгүй үр дүнд тулгуурласан гүйцэтгэл байх ёстой. Энэ утгаараа энэ өртгийн жинг дарж байгаа хэд хэдэн чухал зүйл байгаа.

Тухайлах юм бол эмийн өртөг, нөгөө эмийн үнийг төлбөрийг нь төлөхгүйгээр бүтэн жил үргэлжилдэг учраас эм ханган нийлүүлдэг байгууллагууд бүтэн жилээр тооцож, бүр хүүгээ хүртэл бодож эмийн үнэ нэмэгдээд байна. Тийм учраас энэ эмийн үнийг буулгах чиглэлд бас дорвитой, төлбөрийн тооцоог нь тухай бүрд нь хийж чаддаг байх явдал. Дээрээс нь эмнэлгийн менежерүүдийн ажил бас их зөв зохион байгуулалттай байх нь чухал юм гэдэг энэ сахилга батыг бид бас яриад байгаа.

2 дахь эмнэлгийн хэрэгсэл бас их үнэтэй. Хэрэгслийн үнийг бас бодит болгох. Жишээлэх юм бол бид и-баримт систем дээр эмийн үнийг ил тод болгоод, эмийн сангууд дээр үнэ нь ямар байгааг харуулж чадсанаараа өнгөрсөн 14 хоногт аптекууд дээр зарагдаж байгаа эмийн үнэ 4 хувиар багассан байна. 1 ёсондоо иргэн таны хяналт тогтоогоод эхлэхээр эмийн сангууд ижил .../минут дуусав/

Х.Ганхуяг: 6 номерын микрофон өгье.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсөвт бол нийтдээ 7 аймаг бол улсын төсөвт төвлөрүүлэхээр буюу олж байгаа орлого нь бол зарлагаасаа давж гарсан байдлаар байгаа. Эдгээр аймгуудын хувьд бол орон нутгийн нэмэгдлийг тогтоож өгсөн хэмжээнээс нэмэгдүүлэх боломж гарч ирж байгаа. Ер нь бол Сангийн яамны хувьд 2 байдлаар аймгуудад зөвлөж байгаа.

1 дүгээрт ИТХ буюу бас ард түмнээс сонгогдсон, мандат авсан гишүүд, төлөөлөгч нар маань төсвөө батлахдаа 1 дүгээрт үр ашгаа сайжруулаач ээ. Төсөв дээрээ зүй зохистой тэр зардлыг хэмнэх замаар төрийн албан хаагчдынх нь цалинг нэмэх боломжийг гаргаач ээ. Тэгсэн тохиолдолд Сангийн яамнууд татна.

2 дахь нь орлогоо дайчлаач ээ. Орлого дээрээ дайчлах боломжийг бол бид нар аль болох орон нутагт орлогыг чиглүүлж байгаа. Жишээ нь хамгийн сүүлд хийсэн зүйл бол аж ахуйн нэгжийн 40 хувийг орон нутагт нь үлдээдэг болсон.

Х.Ганхуяг: Энэ өргөдлийг төсвийн ажлын хэсэг рүү шилжүүлнэ. Тэгээд маргааш Төсвийн байнгын хороо хуралдана. Тэгээд энэ 3 салбар ямар ч гэсэн маргаашдаа багтаад үйлдвэрчний эвлэл, тухайн салбарын ажиллагсадтайгаа уулзаж, 3 талт хэлэлцээрийн асуудлаа дахиж ярилцах хэрэгтэй. Дүнгүүдээ тохирох хэрэгтэй. Тэгэхгүй бол ажлын хэсэг дээр бид нар чинь бол одоогийн байдлаар тодорхой тооны дүнгүүд авчихсан байдаг. Тэгээд тэр нь болох юм уу, болохгүй юм уу яг ний нуугүй бол хэлж мэдэхгүй байна. Санал хураалтад бэлдье.

Ганмаа гишүүний микрофон өгье. Тодруулах юм байна.

Д.Ганмаа: Сайд аа, маш тодорхой л 2, 3 асуулт асуугаад байгаа юм шүү дээ. Одоо та ТҮМ-1 гээд яриад байх юм. Уг нь энэ гадаа зогсоод, жагсаад байгаа хүмүүс чинь асрагчийн цалин гэж би асуусан шүү дээ. Асрагчийн цалин, сувилагчийн цалин, эмч нарын цалин үндсэн цалин нь хэд байж байгаад хэд болох вэ. Асрагч чинь 1 сая хүрэхгүй шүү дээ. Өөрсдийнх нь хэлж байгаагаар бол 900 мянга ч хүрэхгүй цалинтай юм байна. Тэгэхээр энэ нэмэгдэл нь хэд болоод байгаа юм бэ. 1 дүгээрт.

2 дугаарт энэ хүний нөөцийн бодлого дээрээ яаж явах гээд байгаа юм бэ. Зөвхөн цалин хөлс, хангамж дээр биш, энэ бүтээмж дээр яг ямар бодлого барьж байж энэ хүмүүсээ ажил дээр нь байлгах юм бэ. Яаж ажилтай нь байлгах юм бэ. Яаж энэ хүмүүсээ нөгөө burnout effects халах юм бэ. Энэ дээр бодлого байгаа юу л гэж асуугаад байгаа юм.

3 дугаарт энэ хүмүүсийн цалинг 10-15 хувь нэмснээрээ нөгөө ажлаа хаяад байгаа эмч нар, сувилагч нар, гадаадад, энд тэнд очиж ажиллаад байгаа сувилагч нар ч юм уу, эсвэл төгсөнгүүтээ бүгд гадаад явна гэж бараг АШУҮИС-ийн сувилахуйн.../минут дуусав/

Х.Ганхуяг: Чинбүрэн сайд гүйцээгээд хариулчих.

Ж.Чинбүрэн: Ерөөсөө л гол юм бол ажлын үнэлэмж сайжруулах ёстой. Тухайлах юм бол эрүүл мэндийн салбарын ажилчдын том чухал зүйл бол олон жил сурч мэдэж авдаг мэргэжил, дээрээс нь туршлага хуримтлагддаг. Тэр утгаараа үнэлэмж нь өндөр байх ёстой. Ачаалал жигд байх ёстой. Тэр утгаараа бид бодлогын хувьд бол эрүүл мэндийн шатлал бүр дээр тусламж, үйлчилгээг хаалга барих тэр зарчмыг барих тогтолцоог илүү түлхүү болгох, ялангуяа анхан шатын тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэх, тогтолцоог нь сайжруулах, одоо энэ 7 хоногт өрхийн эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 25 жилийн ой болох гэж байна. Энэ дээр бас бид бодлогуудаа танилцуулна, ярина. Тэгэхээр бодлогын хувьд ерөөсөө л хаалга барьдаг энэ тогтолцоог илүү сайн болгох, дээрээс нь даатгалын тогтолцоо маань өөрөө олон олон ирж байгаа нэхэмжлэгүүдийг хянадаг систем нь өөрөө илүү цахимжсан нээлттэй болох шаардлагатай байна. Ингээд эрүүл мэндийн салбарын даатгалын .../минут дуусав/

Х.Ганхуяг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт. Энэ чинь болохгүй байна шүү дээ. Байж байгаарай. Уншигдахгүй байна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Алтанхуяг гишүүн ороогүй байна. Аубакир гишүүн ороогүй байна. Ганмаа гишүүн ороогүй байна. Минийх болчихлоо. Мөнхсайхан гишүүн болоогүй байна. Номин гишүүнийх ороогүй байна. Тэмүүлэн гишүүн ороогүй байна. Энхтүвшин гишүүн ороогүй байна. Энхтуяа гишүүн ороогүй байна. Эрдэнэбат гишүүн ороогүй байна шүү. Дахиад ороодохье. Ганмаа гишүүн оржээ. Бусад нь байхгүй байгаа юм байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5.3-д заасан “Тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах саналыг 33 мянга ба түүнээс дээш иргэн дэмжсэн бол Монгол Улсын Их Хурал хэлэлцэнэ.” гэж заасны дагуу дээрх өргөдлийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт шилжүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 37 гишүүнээс 29 гишүүн дэмжсэн байна. 78,4 хувиар.

Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, 33083 иргэдээс гаргасан эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдлийг хэлэлцэж дууслаа.

13.49 цаг.

2 дахь асуудалдаа орцгооё. 2 дахь асуудал.

Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Чинбүрэн эрүүл мэндийн сайд, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга ирсэн үү, ирээгүй юу. Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Рэнцэнханд Нийгмийн даатгал, хуримтлалын байгууллагын газрын дарга, Энхтөр Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Алимаа Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга, Отгонбилэг Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Отгонбаатар Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга, Наранпүрэв Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Нармандах Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Отгонбаатар Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга, Ууганбаяр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга,

Борхүү Банкны бүтцийн өөрчлөлтийн бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн дарга, Монголбанк. Батболд Мөнгөний бодлогын газрын макро зохистой бодлогын хэлтсийн дарга, Батсайхан Хууль, эрх зүйн газрын Банк санхүүгийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, иргэний төлөөлөл Сүхбаатар Монголын ахмадын холбооны Ерөнхийлөгч ирсэн байсан тийм ээ. Алтанзул өргөдөл гаргагч иргэдийн төлөөлөл, арилжааны банкны төлөөлөл Мөнхнаст Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч, Энх-Ирээдүй Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал, Амарсанаа Төрийн банкны Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал, Солонго Монголын банкны холбооны Хууль, эрх зүй, хамтын ажиллагаа хариуцсан ахлах менежер, Төр-Энх Төрийн банкны Бизнес бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл гуай танилцуулна.

Д.Рэгдэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын удирдлага болон гишүүдэд хандан 2025 оны 9 дүгээр сарын 10, 15, 16, 19-ний өдрүүдэд ахмадуудын зөвлөлийг төлөөлөн иргэн Алтанзул болон нэр бүхий ахмадуудаас ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, ахмад настны эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар шаардлага ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцэж, судлан үзэж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбатаар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтулга, Рэгдэл нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

Ажлын хэсэг энэ хугацаанд 3 удаа хуралдаж, Монголбанк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнууд, Монголын банкны холбооны төлөөлөл болон шаардлага ирүүлсэн иргэдийн төлөөллийг оролцуулан талуудын байр суурийг сонссон бөгөөд төрийн байгууллагуудад хуулийн хүрээнд боломжит хувилбараар санал танилцуулах үүргийг ажлын хэсгийн ахлагчаас өгсөн юм.

1. Ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх талаар

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд ахмадуудын тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ гэж заасныг зөрчсөн байна. Учир нь Монголбанкны мэдээллээр өнөөдрийн байдлаар инфляц 8,8 хувьтай байгаа ба оны эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 8,6 хувьтай байна гэж тооцоолсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн “Аргачлал батлах тухай” 75 дугаар тогтоолоор тэтгэвэр нэмэгдүүлэх аргачлалыг баталсан. Дээрх аргачлалд заасны дагуу 2025 онд тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Үндэсний статистикийн хороо нь 2024 оны инфляцын жилийн дундаж түвшин 6,8 хувь гэж

зарласан бөгөөд зөрүү 0.8 хувь, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2025 оны хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг 9,5 байхаар баталж, аргачлалын дагуу 2026 оны тэтгэврийн хэмжээг уг зөрүүг нэмж 10,3 хувиар нэмэгдүүлэхээр анх төсвийн төсөлд санал өгсөн байна. Үүнд одоо төсвийн төсөлд туссан байгаа 333,5 тэрбум төгрөг дээр 267,1 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардагдаж байна.

Иймд одоогийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчны хүрээнд ахмадын тэтгэврийг хамгийн багадаа 10,3 хувиар нэмэх нь зүйтэй гэж үзэж байна.

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхдээ адил хувь, адил мөнгөн дүн буюу нийтдээ 6 хувиар нэмэгдүүлсэн дээрээ саяын хэлсэн нэмэгдэл 267,1 тэрбум төгрөгөөр тогтмол дүнгээр, дунджаар 1 хүнд 42 мянган төгрөг дүнгээр тэтгэврийг нэмэгдүүлэх нь тэтгэврийн ялгаа ихсэхээс сэргийлэх ач холбогдолтой боломжит хувилбар гэж мөн ажлын хэсгийг гишүүд үзлээ.

Ахмадуудын өргөдөлд дурдсан тэтгэврийн доод хэмжээг 1,5 сая болгоход 4,3 их наяд төгрөг шаардлагатай бөгөөд Сангийн яамнаас энэ төсвийн ачааллыг даах боломжгүйг мэдэгдсэн. Өнөөдрийн байдлаар нийт тэтгэвэр авч буй иргэдийн 92,9 хувь нь 1,5 сая төгрөгөөс доош тэтгэврийг авч байна. Цаашид жил бүр ахмадуудын тэтгэврийг инфляцын түвшнээс дээш байхаар бодитоор нэмэгдүүлэх, доод тэтгэврийг 1 сая 500 мянгад хүргэх шаардлагатай байна.

Ахмадуудын тэтгэврийг буруу бодсон, итгэлцүүр тооцоогүй, шударга бус алдсан гэх гомдлууд Байнгын хороонд нэлээд ирдэг ба сайн дурын даатгуулагчдаас 2024 онд 3845 даатгуулагч, 2025 оны эхний 5 сарын байдлаар 4036 даатгуулагч өндөр цалингаар төлсөн байгаа зэргийг цаашид анхааран үзэх хэрэгцээ шаардлага бас байна.

Монгол Улсын Засгийн газар өөрийн эрх мэдлийн хүрээнд ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх боломжит хувилбаруудыг судлан тэтгэврийн нэмэгдлийг бодит инфляц, амьжиргааны өртөгт нийцүүлэн дээр дурдсан 2 хувилбараас илүү дүнгээр нэмэгдүүлэхийн төлөө хичээн ажиллах нь зүйтэй юм.

2. Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах талаар.

Нийгмийн даатгалын сангаас энэ оны 6 дугаар сарын байдлаар 518,8 мянган хүн тэтгэвэр авч байна. Тэтгэвэр барьцаалсан зээлийн талаарх мэдээллийг 2024, 2025 оны эхний хагас жилийн байдлаарх тоон мэдээ судалгаанаас харахад 2024 онд нийт 271,2 мянган тэтгэвэр авагч 15,96 хувийн дундаж хүүтэйгээр нийт 1,63 их наяд төгрөгийн, 2025 оны эхний хагас жилд 275,5 мянган тэтгэвэр авагч 16,18 хувийн дундаж хүүтэйгээр 1,66 их наяд төгрөгийн зээл авсан байна. Тэтгэврийн зээл авсан тэтгэвэр авагчдын тоо 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2024 оны жилийн эцсийн тоотой харьцуулахад 1,6 хувиар нэмэгдсэн ба тэтгэврийн зээлийн хүүгийн 0,22 функтээр өссөн байгаа нь Монголбанкны мөнгөний бодлогын хүү 12 хувьтай холбоотой байна.

Үүнээс гадна Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зөвлөмжид үндэслэн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны энэ оны эхний хагас жилд гарсан ойр ойрхон, судалгаа муутай шийдвэрийн нөлөөгөөр ахмадын тэтгэврийн зээлийн хүү болон зээл олголтын нөхцөл байдалд хүндрэл учирсан байна.

Хэдийгээр Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар банкнаас олгох тэтгэврийн орлого барьцаалсан зээлийг хуучин нөхцөлөөр хэвийн олгох шийдвэр гаргасан боловч банк бүр өөрийн үзэмжээр харилцан адилгүй энэ шийдвэрийг хэрэгжүүлж, биелүүлж байна.

Арилжааны банкнуудаас тэтгэврийн зээлийн эх үүсвэрийг бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газраас баталгаа гаргах, эрсдэлийн хувьд зээлийн бүтээгдэхүүнтэй ижил түвшинд байлгах, заавал байлгах нөөцийг бууруулах замаар зээл хямд олгох эх үүсвэрийг арилжааны банкнуудад олгосноор зээлийн хүү буурах боломжтой талаар саналууд ирсэн байна. Иймд Монгол банкнаас тэтгэврийн зээлийг бууруулахад тодорхой алхмуудыг хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна. Үүнд:

1 дүгээрт тэтгэврийн зээлийн эргэн төлөлт 97-98 хувьтай байхад Монголбанкны тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэсэн активын хувь хэмжээг 150 хувь байгааг бууруулах, тэтгэврийн зээлд шаардагдах эх үүсвэрийг нь заавал байлгах нөөцийг бууруулах замаар зээл олгох хямд эх үүсвэрийг арилжааны банкнуудад олгох, тэтгэврийн зээлийн хүүг бууруулахад Монголбанкнаас авах арга хэмжээнээс гадна тэтгэврийн зээлийн зориулалтад хийсэн судалгаанд үндэслэн тодорхой арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй юм. Тухайлбал ипотекийн болон оюутны сургалтын төлбөрийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа юм. Тэтгэврийн зээлийн эх үүсвэрийг банкнуудад бий болгоход дэмжлэг үзүүлэх, төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын төсвийн сул эх үүсвэрийг татан төвлөрүүлж, Засгийн газар арилжааны банкнуудтай хэлэлцээр хийх замаар тогтмол дундаж дүнтэй сул эх үүсвэрийг дайчлах боломжтой.

Мөн ахмадуудад зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх болон бодит хүүгийн түвшинтэй ойрхон байлгаж хүүгийн зөрүүг төр тодорхой нөхцөлтэйгөөр хариуцах, батлан даагчийн шаардлагыг багасгах зэрэг зээлийн эх үүсвэр бий болгох хууль, эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ байна гэж үзлээ.

Банкны тухай хуульд зээлийн хүү болон эх үүсвэрийн зардал холбогдох бус зээлийн хүүг өндөрсгөх шалтгааныг судлах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах асуудлыг судалж үзэх шаардлагатай талаар ажлын хэсгийн гишүүд санал нэгдлээ.

Нөгөө талдаа банкнууд нийгмийн хариуцлагын хүрээнд тэтгэврийн зээлийн хувьд үйл ажиллагааны зардлаа тэглэх, ахмадууд өөрсдийн санаачилгаар тэтгэврийн зээлээ банк хооронд шилжүүлэхэд хүндрэл учруулахгүй байх, судалгаанд үндэслэсэн ахмадуудын хэрэгцээг хангах богино хугацаатай зээлийн бүтээгдэхүүний төрлүүдийг нэмэгдүүлэх нь зүйтэй зүйтэй юм.

3Ахмадуудын эрүүл мэндийн болон асрах үйлчилгээний талаар

Ахмадуудын зээл авах хэрэгцээ шаардлагын нэлээд дээгүүрт эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд зээл авч байгаа нь судалгаанаас харагдаж байна. Иймд ахмад настныг асрах үйлчилгээ эрхлэхээр оруулж буй хөрөнгө оруулалтыг төрөөс татварын бодлогоор дэмжих, асрах сувилах үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, цаашид жил бүрийн төсөвт ахмад настны асрах үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэн тусгах хэрэгтэй байна. Түүнчлэн, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгодог хэвтэн эмчлүүлэхэд архаг өвчинтэй хүмүүст тооны хязгаар тогтоосон нь ахмадууд эрүүл

мэндийн тусламж, үйлчилгээг улсын эмнэлгээр бус хувийн эмнэлэгт өндөр үнийн дүнтэй эмчилгээ үйлчилгээ авах хэрэгцээ үүсгэж буйг Эрүүл мэндийн яам эргэж харах шаардлагатай байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгийн санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Б.Найдалаа: Ажлын хэсгийн гишүүн Рэгдэл гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон энэ асуудалтай холбоотой албан тушаалтнуудаас асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт үг хамт явна шүү. Баясгалан гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн эхэлье.

А.Ариунзаяа: Бид эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгал энэ сангийн ажиллагаанд бол маш ихээр ноцтой халдаж, шимтгэл төлөгчдийнхөө эрхэд ноцтой халдаж байгаа үйлдлүүдийг явуулж байгаа. Улс төрчид. Эрүүл мэндийн даатгалын сангаас өнөөдөр эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг олгож байгаа нь үнэн. Төр төсвөөс өөрөө цалин хөлсний мөнгийг тавихгүй байгаа. Өнөөдөр эмч нарын, эмнэлгийн байгууллагын ажилтны цалинг нэмэгдүүлж байна гэдэг нь өөрөө эргээд Эрүүл мэндийн даатгалын сан дээр ачаалал үүсгэнэ. Шимтгэл төлөгч дээр ачаалал ирнэ. Энэ бол маш буруу. Ийм учраас Сангийн яам төр гэж өөрөө л байгаа юм бол төрийн албан хаагчийг ажиллуулж л байгаа юм бол төсөвтөө өөрөө тусдаа энэ харилцааг цалин хөлсний харилцааг суулгах үүрэгтэй. Тэрнээс биш шимтгэл төлөгчдийн нуруун дээр үүнийг үүрүүлэх нь буруу. Шимтгэл төлөгчид эрүүл мэндийн үйлчилгээгээ хүртэл авч чадахгүй нөхцөл байдалд өнөөдөр хүрч байгаа.

Үүнтэй нэгэн адилаар нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын сангийн харилцаа шимтгэл төлөгчдийн харилцаа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл өнөөдөр хэн хэдий хэмжээний шимтгэл төлж байна, түүн дээрээ бодлогоосоо хамаарч хэдэн хувиар тэтгэвэр нь тогтоогдох уу, хэдэн хувиар тэтгэвэр нь нэмэгдэх вэ гэдэг асуудлыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл уг нь бол ярьж тогтоох үүрэгтэй.

Би Хөдөлмөрийн сайдаар ажиллаж байсан. Намайг Хөдөлмөрийн сайдаар ажиллаж байхад би дан дээлтэй сайд байсан. Бид тэтгэврийн доод хэмжээг 500 мянгад хүргэсэн. Хүргэсэн нь сайн хэрэг. Бид нар бол маш олон жилийн хугацаанд 20 мянган төгрөг, 10 мянган төгрөгөөр нэмэгдүүлж явж байсныг эрс нэмэгдүүлсэн нь үнэн. Гэтэл бид нар бодлогын алдаа гаргасан. Би үүнийг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ энэ бодлогын алдаа яамны алдаа байгаагүй. Энэ бол улс төрчдийн алдаа байсан. Тодорхой төрийн бодлого явах ёстой шат дамжлагаараа яваагүй, мэргэжлийн яамны саналыг аваагүй байх үед нь нэгэн улс төрч олон нийтэд жиргэснээс үүдэж шийдвэр гараагүй байгаа дээр шахалтад орж, Ариунзаяа та нар дуугүй бай, бид нар улс төрийн шийдвэр гаргасан гэж яамны эрх болоод тэтгэвэр авагчдын эрхэд бол ноцтой халдсан. Үнэн. Бид нар үүнийг засаж ер нь чадахгүй байгаа. Дараа нь Булгантуяа сайд бас индексжүүлсэн. Индексийг бас өөрчлөлттэй засахыг тодорхой хэмжээнд оролдсон. Гэхдээ одоо хүртэл бид нар энэ зөрүүг буцаан арилгаж чадаагүй л байгаа. Яг энэнтэй нэгэн адилаар одоо тэтгэврийг нэмэгдүүлэх талаар төр ярьж байгаа бол суурь тэтгэврээ төрөөс олгодог байх зохицуулалт, Баялгийн сангаас тэтгэвэртээ авч болдог байх зохицуулалтыг төр өөрөө хийж байж сая өөрчлөгдөнө. Энэ дээр бодлого ямар байгаа вэ. Яам хуулиа оруулж ирэх үү /минут дуусав/

Б.Найдалаа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Аубакир сайд байхгүй билүү. Уг нь яг бодлогын асуудлыг сайд нь л хариулахгүй бол яамны аппаратаас хариулт авч болно. Хангалтгүй байхгүй юу. Төрийн нарийн байгаа юм уу. Микрофон 4. Өөрийгөө хэлээд тэгээд яриарай.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Лхагвасүрэн овогтой Мөнхзул байна. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Тэтгэврийн даатгалын тогтолцоонд өнгөрсөн хугацаанд 2000 оноос эхлэн Монгол Улс шинэчлэл хийх гэж зорилт дэвшүүлж ирсэн. Гэсэн хэдий боловч энэ шинэчлэлээсээ сонгуулийн цикл мөчлөгтэй уялдуулан дандаа ухралт хийж ирж байсан. 2002 онд нэрийн дансны даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн боловч өнөөдөр хойшлуулсан. Уг тогтолцоог цаашид авч явах нь төвөгтэй байдалтай байгаа. 2024 онд нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Уг шинэчилсэн найруулгын хүрээнд тогтолцооны хэд хэдэн шинэчлэлийн заалтууд оруулсан. Төсвийн байдлаас шалтгаалан мөн энэ хуулийн хэрэгжилт ч өнөөдөр амьдралд бүрэн бус байгаа.

Мөн түүнчлэн Монгол Улс цаашаа тэтгэврийн даатгалын тогтолцоогоо шинэчлээгүйн улмаас бусад орнуудад тулгамдаж байгаа бүх асуудлуудад ойрын хугацаанд Монгол Улсад нүүрлэх гэж байна. Тухайлбал насжилтын асуудал. Өнөөдөр 537 мянган хүн тэтгэвэр авдаг. Нийгмийн даатгалын сангаас. Энэ дээр нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа хүнийг нэмбэл 550 орчим мянган хүн, эдийн засгийн нийт ажиллагсдын тоо 1,2 сая орчим. Ингээд өөрөөр хэлбэл манайх эдийн засгийн бүтцийн хувьд албан сектор, албан бус секторын харьцаа бас төдийлөн сайн бус байдаг гэх мэт энэ зүйлүүдээс шалтгаалаад ирээдүйд шимтгэл төлөх даатгуулагчийн тоо төдийлөн дорвитой өсөхөөргүй байна. 2030 он гэхэд тэтгэвэр авагч, шимтгэл төлөгчдийн тоо ойролцоо түвшинд хүрнэ. Энэ бүхэн нь цаашдаа насжилтаас үүдсэн тэтгэврийн сангийн зардлыг өсгөнө. Ийм учраас тэтгэврийн даатгалын шинэчлэлийг бид гүнзгийрүүлэх шаардлага тулгарч байна.

Ийм учраас яамнаас бол бодлогоо боловсруулсан. Өмнөх Засгийн газрын үед бол Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан. Сая бол бас бид танилцуулсан байгаа. Тэгээд цаашдаа бол нийгмийн даатгалын реформыг үргэлжлүүлэх чиглэлээр зайлшгүй бас ийм бодлогын шийдлүүдийг яам боловсруулаад танилцуулж байгаа. Засгийн газар болон Их Хурал дээр хэлэлцэгдэх байх гэж үзэж байна.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Мөнхзул дарга аа, тэтгэврийн нэмэгдлийн талаар шимтгэл төлөгчдийн үүсгэж байгаа сан болон төсвийн харилцаан дээр ноцтой ийм зөрчил үүсээд байгаа байхгүй юу. Энийг мэргэжлийн яам яг тодорхой хэлээд өгмөөр байна. Тэгэхгүй бол улс төрчид энд ямар нэгэн шийдвэр гаргадаг. Сан өөрөө дангаараа сангийн үйл ажиллагаанд ноцтой халдаад байгаа байхгүй юу. Энэ бол буруу тогтолцоо яваад байгаа юм. Үүнийг шийдвэрлэх 1 арга зам нь бол төсвөөс төр өөрөө даадаг суурь тэтгэвэр. Энийгээ хуульдаа оруулсан уу. Хэзээ өргөн барих вэ.

2 дахь нь Сангийн яам. Баялгийн сангаас зөвхөн орон сууц, эрүүл мэнд, боловсрол бус бусад улс орон шигээ тэтгэврийн насандаа хүрэхээрээ тэтгэвэртээ авч болох уу. Энэ харилцааг оруулж өгөөч ээ. Ингэж байж бид Норвег шиг Сингапур шиг Баялгийн сангаасаа тэтгэврээ авдаг болно. Энэ дээр бодлогыг нь асууя.

Б.Найдалаа: Тэгэхээр асуулт нь тодорхой юм байна шүү дээ. Хэрвээ улс төрчид шийдвэр гаргаж байгаа бол улсын төсөв, нийгмийн даатгалын сангаас улс төрчид шийдвэр гаргаад байгаа нь холион бантан болоод алдаа хийгээд байна гэж. Энэ дээр яг тодорхой хариулаарай. Салгах талаар ч юм уу. Ямар шийдэл байгаа юм бэ. 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлж чадахгүй байгаа үндсэн шалтгаан бол ерөөсөө л шилжилтийн зардлаа улсын төсвөөс хангалттай гаргаж өгөхгүй байгаа. Яагаад гэхээр 1995 оноос эхэлж нийгмийн даатгалын шимтгэлд суурилсан тогтолцоо бий болсон. Тогтолцоо бий болсон өдрөөсөө эхлээд тэтгэврийн зардлаа хариуцаад явсан. Өнөөдөр тэтгэврийн даатгалын сан дээр 9195 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийн зардлыг хариуцаж байгаа боловч 1995 оноос өмнө хугацаанд ажилласан хугацааны зардлыг бас хариуцахгүй байгаа. Тэгэхээр Ариунзаяа гишүүний хэлж байгаа зүйл бол маш зүйтэй зүйл. Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын шимтгэлд суурилсан харилцаа, харин өмнөх тогтолцооны энэ тэтгэврийн харилцаагаа ялгаж салгаж ойлгооч ээ гээд энэ дээр бол санал 1 байна. Цаашдаа суурь тэтгэврийг бид нар санал болгож байгаа. Нийт суурь тэтгэврийн хэмжээний 80 хувийн зардлыг улсын төсвөөс 100 хувь хариуцаач ээ гэдэг ийм хувилбаруудыг бол бас санал болгоод, тооцооллуудаа хийгээд явж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Яг энэ үгийг сайд өөрөө хэлэх юм бол яг шийдэл болох гээд байгаа байхгүй юу. Яг энэ бодлогын шийдлээ ийм төсөл оруулах гэж байгаа гээд. Тэгээд тийм болохоор бид нар сайдыг асуугаад байгаа шүү. Сангийн яам. Микрофон 5.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол сангийн нийт зарлага өөрөө бол уг нь шимтгэлийн тогтолцоо дээр тусаж явах ёстой. Гэхдээ мэдээж хэрэг тодорхой иргэдийн шимтгэлийг төрөөс хариуцаад явчхаж байгаа учраас төрөөс татаас өгчхөж байгаа. Тэгээд дээр нь сан маань алдагдалтай болоод ирэнгүүт тодорхой хэмжээний алдагдлыг нөхөхөөр бид нар татаас өгөөд явчхаж байгаа. Тэгэхээр энэ бол шимтгэл, тэгээд олгож байгаа тэр тэтгэврийн зохистой хэмжээ бол арай өөр байна гэдэг хандлага гарч ирж байна л даа. Яг энийг өөр байгаагаас шалтгаалаад үргэлжлээд баялгийн сангаас тэтгэвэр өгнө гэдэг тэтгэврийг нэмэгдүүлэх суурь тэтгэвэр олгоно ч гэдэг юм уу ийм байдлаар үзэх нь бол бас өрөөсгөл болов уу гэж миний хувьд үзэж байна.

Яагаад гэхээр тэтгэврийн тогтолцоо гэдэг маань шимтгэлд суурилсан арай өөр тогтолцоо байгаад байгаа. Баялгийн сан гэдэг бол арай өөр. Та мэдэж байгаа хүүхдийн мөнгө бол жишээ нь анх яг ингэж байгалийн баялгаасаа өгнө гэж эхлээд гээд сүүлдээ бол улсын төсөв болоод ингээд тогтчихсон ийм зүйл байж байгаа. Тэгэхлээр энэ бол .../минут дуусав/

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулах уу.

А.Ариунзаяа: Санжаа чи хольж хутгаад байгаа байхгүй юу. Би болохоор юу гэж хэлж байна вэ гэхээр нэгэнтээ баялгийн сангаас Ариунзаяа гэдэг хүн дээр нэрийн данс үүсэж байгаа юм бол би эрүүл мэнддээ, боловсролдоо, орон сууцдаа зарцуулаагүй бол би тэтгэвэртээ гарахдаа тэр мөнгөө өөртөө ашигламаар байгаа байхгүй юу. Нэгэнтээ миний нэрийн данс дээр баялгийн сангаас хуримтлал үүсэж л байгаа юм бол. Одоогийн байдлаар 200-аад мянган төгрөг үүсчхээд байгаа шүү дээ. Би буруу хараагүй бол. Тэгээд энийгээ л би боловсрол, эрүүл мэнд орон сууцад

зарцуулаагүй бол би тэтгэвэр хэлбэрээр авмаар байгаа байхгүй юу. Энийг л би хэлээд байгаа юм. Энэ бол Норвегийн хэлбэр шүү дээ. Норвег ч байна. Казахстан ч байна. Ердөөсөө би өөр юм яриагүй.

Яам одоо 6 хувийн нэмэгдэл байна уу, 8 хувийн нэмэгдэл байна уу хамаагүй. Энэ тэтгэврийн хуулийнхаа 27.2 заалтыг хэрэгжүүлээрэй. Энэ бүгдэд адил тэгш хувиар нэмэгдүүлэх бус харин аргачлалаа тодорхой гаргаач ээ. Нийт сангийн дүнгээ 6 хувиараа нэмэгдүүлж болно.../минут дуусав/

Б.Найдалаа: Хариулт хэн хариулах билээ. Мөнхзул дарга. 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэврийг тухайн жилдээ хууль дээр бол ерөөсөө яг инфляцын түвшнээр гэсэн үг бол байхгүй. Инфляцын дундаж түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ гэж байгаа. Гишүүний хэлсэнчлэн Засгийн газраас тэтгэврийг нэмэгдүүлэх аргачлал бол батлагдсан. Энэ аргачлалын дагуу одоо хүчин төгөлдөр байгаа аргачлалын дагуу бол тухайн тэтгэвэр авагчийн тэтгэвэр нь өөрөө нэрлэсэн дүнгээрээ эдийн засгийн өсөлт, цалин хөлсний өсөлт тэр бүхнээ шингээчихсэн байдаг учраас бүгдэд ижил байдлаар ижил хувиар нэмэгдүүлэхээр аргачлал дээр бол орсон байгаа. Тэгэхээр аргачлалыг өөрчлөх асуудал бол Засгийн газар дээр өөрчлөх боломжтой.

Б.Найдалаа: Баярлалаа. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Өдрийн мэнд дэвшүүлье. Эрхэм гишүүд, ажлын хэсгийнхэнд. Бид яах вэ, нийгмийн даатгалын тогтолцоотой холбоотой зохих шинэчлэл хийгээд, үр дүнг нь бас эхнээс нь хараад явж байгаа гэдгээ байнга хэвлэлийнхэнд ч бай олон нийтэд ярьж баймаар байгаа юм. Тэгээд бид нийгмээр ийм мэдээлэл болохоор зэрэг ерөөсөө бүх юм болохоо байчихсан, бүтэхээ байчихсан. Тэгээд энэ улс орон ерөөсөө үндсэндээ хөмөрчихсөн юм шиг ийм байдлаар яриад байвал энэ сайн биш шүү. Өнгөрсөн хугацаанд энэ тогтолцоо чинь бас 30 жил энэ нийгмийг байж болох эрсдэлийг нь даагаад, ард нь гарчихсан байхгүй юу. Гэхдээ сорилт бол байнга байдаг. Тэр сорилтуудын л нэг. Тэр нь хүн ам зүйн шалтгаантай байна уу, эдийн засгийн шалтгаантай байна уу, тогтолцоо дахь ямар нэгэн улс төрийн нөлөөллөөс болсон шийдлээс болсон байна уу, тэрийг бид нар засах гэж энэ Их Хурал энд сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ талаас нь ярьж байгаа зүйлээ хэдүүлээ дандаа болж байгаа зүйлээс нь гадна болохгүй байгаа шалтгааныг нь бодитой яриад явах ёстой юм байна гэж би зүгээр оршил маягаар хэлж байгаа юм. Асуулт байна.

Ингээд бид бол яг өнөөдөр тэтгэврийн нэмэгдэлтэй холбоотой ярьж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас яг хуулиа бариад тэтгэврийг 10,3 хувиар нэмэгдүүлэх ийм санал оруулсан юм байгаа юм. Тэгээд энэ ингээд 6 хувь болчихсон. Яагаад 6 хувь байсан бэ гэдэг асуултыг Сангийн яамнаас асууя 1 дүгээрт.

2 дугаарт 10,3 хувиар нэмэгдүүлэхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамных нь санд ямар хэмжээний ачаалал ирэхээр байгаа вэ.

2 дугаарт сан энэ ачааллаа дааж чадахаар байгаа юу. Чадахаар болоод л та хэд энэ тооцооллыг оруулсан байх гэж бодож байна.

3 дахь асуулт ахиад 2 яамнаас аль алинаас нь. Энэ 515 мянган хүний чинь 460 мянга нь сангаас тэтгэвэр авч байгаа. Цаана нь 60-аад мянган хүн татаасаар

тэтгэвэр авах хүмүүс байгаа шүү дээ. Тэр нь бол цэргийн тэтгэвэрт гарсан хүмүүс буюу төр өөрөө хариуцаж байгаа. Тэгэхээр энэ цэргийн тэтгэврийнхний ачааллаас болоод тэтгэврийг бид бас саяын хэлбэрээр нэмж чадахгүй байгаа ийм нөхцөл байгаад байна уу. Энийг ер нь үнэн бодитоор нь та бүхэн бас хариулаад өгөөч гэсэн ийм асуулт байгаа юм.

Нөгөө нэг зүйл тэтгэврийн зээлтэй холбоотой зүйл байгаа юм. Энэ тэтгэврийн зээлтэй холбоотой тэр зээлийн хүүг тогтоох асуудал дээр энд банкны төлөөлөл байгаа юм байна гэж ойлголоо. Та бүхэн яг ямаршуу байдлаар энэ асуудалд хандаж байгаа вэ гэсэн ерөнхий асуулт байгаа юм. Та бүхний байр суурь ямар байгаа юм бэ. Баярлалаа.

Б.Найдалаа: Хариулт Сангийн яамнаас микрофон 5.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж олгох тухай хуулийн 27.1 дээр “тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлнэ” гээд хуулийн заалт байгаад байгаа юм. Тэгэхээр инфляцаас багагүй гэдэг ч юм уу, эсвэл яг инфляцын түвшнээр гэдэг ч юм уу ийм үг бол байхгүй инфляцын дундаж түвшинтэй уялдуулж гэххэж байгаа юм 1 дэх нь. Тэгэхээр 6 хувь дээр би бол хуулийн зөрчил байхгүй гэж хэлэх гээд байгаа юм.

2 дахь асуудал нь бол юу вэ гэхээр урсгал зардлын хэмжээг 2026 оны төсөв дээр бид нар 585 тэрбум төгрөгөөр нэмж оруулж ирсэн. Гэхдээ автоматаар нэмэгдэх болчихоод байгаа нь хүний тооны өсөлт, хүүхдийн тооны өсөлт, тэгээд инфляцтай уялдуулж бас нэмэх ёстой, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялддаг зардлууд маань нийлээд 1 их наяд төгрөгийн зарлага нэмэгдчихсэн гэсэн үг. Тэгэхээр бид нар товчхондоо бол орон зайн хувьд боломж байгаагүй гэдэг л зүйл хэлэх гээд байгаа юм. Орлогын хэмжээг 3 байгууллага бол улсын хэмжээнд тооцоод, одоо төсөв дээр бол тоогоо нэгтгээд бол оруулж ирж байгаа. 1 дүгээрт Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, 2 дугаарт Эдийн засаг, хөгжлийн яам, 3 дугаарт Сангийн яам. Эдгээр байгууллагуудын хувьд бол бид нар орлого энэ хэмжээнд байна гэдэг агуулгаар орж ирж байгаа. Бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр суурь зарлага гэдэг агуулгыг оруулаад ирчихсэн. Өөрөөр хэлбэл бид нар цалин, тэтгэвэр, тэтгэмжийг зээл аваад тавьж болохгүй гэдэг хуультай. Бид нар яг олсон орлогынхоо хэмжээндээ багтаад цалин, тэтгэвэр, тэтгэмжээ оруулж ирж шийдэх ёстой гэдэг л зүйл болчихож байгаа. Тэгэхээр өөр 1 зардлыг бид нар хасах болчихоод байгаа.

Нөгөө талдаа ер нь сая 2025 оны хувьд бид нар 1 удаа ингээд төсвөө тодотгосон. Өмнөх жил дээр бас төсвөө нэлээд бууруулсан ийм төсвүүд явчихсан учраас төсөв маань өөрөө бол тийм тэвчиж болох гэдэг зардал бол байхгүй болчихсон. Бүх зардлууд маань хуультай болчихсон байгаад байгаа учраас яг хуулийнх нь дагуу тавиад орж ирчихээр тэр дээр тэтгэврээ нэмэх ийм бодлогын орон зай гарч ирж чадахгүй болчихоод байгаа юм. Нөгөө талдаа бол мэдээж хэрэг улсын төсвийн орлогоос гадна шимтгэлийн орлогыг бол нэмэгдүүлэх боломж онолын хувьд эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг нэмэгдүүлэхэд ч тэр нийгмийн даатгалын сангийн төсвийг ч нэмэгдүүлэх дээр. Гэхдээ энэ маань өөрөө бас яг нийгэмд энэ цаг үедээ зөв үү, буруу юу гэдэг энэ асуудал бол гарч ирж байгаа. Нөгөө талдаа бид нар иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор татварын тогтолцооны хувьд шинэчлэлийг хэрэгжүүлнэ гэдэг ийм бодлого явчхаад байгаа юм. Өмнө нь төрийн зүгээс шийдвэр гаргаад жишээ нь цэргийн албан хаагчдыг бол

нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй. Тэтгэвэрт гарсан үед нь тэтгэврийг нь нэгэнт даана гээд ингээд бодлогоо зарлаад явчихсан учраас энэ бодлогоо бид нар эргэж харахад бас аягүй хүнд болов уу гэж бодож байна.

Тэгээд нөгөө талдаа зүгээр тэтгэврийг бид нар 6-8 хувиар нэмэгдүүлэх ийм бодлогын шийдвэр гараад явсан тохиолдолд яг энэ хэсэг дээрээ адилхан нэмээд явах нь л зөв болов уу гэж бодож байна.

Б.Найдалаа: Монголбанк уу. Микрофон 6. Өөрийгөө танилцуулаарай.

Г.Борхүү: Сайн байцгаана уу. Монголбанк Банкны бүтцийн өөрчлөлт бодлогын газар Борхүү. Гишүүний асуултад хариулъя. Зээлийн хүүтэй холбоотой тэтгэврийн зээлийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой эрсдэл бууруулахтай холбоотой нэлээд бас арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн 7 дугаар сард бол өр орлогын харьцаа болон тэтгэврийн зээлийн хугацаа дээр тавьдаг байсан хязгааруудыг бол цуцалсан байгаа. Тэрэнтэй холбоотойгоор 6-7 сар шилжих хугацаанд бол тэтгэврийн зээл бол огцом нэмэгдсэн. Яах вэ, эрсдэл багатай зээл гэдэг утгаараа эрсдэлийн сан гэж ойлголт байдаг. Тэр дээр байгуулдаг сан бол ерөнхийдөө хэвийн ангилалтай зээл бол 0 хувиар зардлыг эрсдэлийн сангийн зардал гэж байгуулагдаад явдаг учраас харьцангуй банкны үйл ажиллагаа дээр дарамт багатай ийм асуудал байгаа. Хүү бол яаж тогтож байгаа вэ гэхээр банкнуудын үйл ажиллагааны зардал дээр эх үүсвэрийн зардлыг нэмж тогтдог байж байгаа. Тэгээд тэтгэврийн зээл бол яг энэ жишгээрээ тогтоод явж байгаа ийм зээлийн хүү харьцангуй бага.../минут дуусав/

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулах уу. 3 номер.

Б.Батжаргал: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлнэ гэх юм бол яг нийгмийн даатгалын сан дээр 333,5 тэрбум төгрөгийн ачаалал нэмэлт зардал шаардлагатай. 8 хувь гэх юм бол 444,6 тэрбум төгрөг, 10,3 хувиар гэж тооцвол 572,5 тэрбум төгрөгийн ачаалал нэмж шаардлагатай гэсэн тооцоолол гарсан байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулна.

С.Зулпхар: Батжаргал дарга аа, 10,3 хувиар нэмэгдүүлэхэд сан бол ачааллаа дааж байгаа юу. Сангаас олгож байгаа тэтгэвэр авагч хэд байгаа юм. Тэрийг нь сонсчихъё.

2 дугаарт Санжаа дарга аа, яах вэ бид бол нөгөө нэг тэтгэвэр нэмээд байя гээд л бүгдээрээ л хэлээд, шаардаад байх бол амархан шүү дээ. Ер нь ямар нэгэн юмыг тэг гэж хэлэх бол амархан. Гэхдээ тэгж болж байна уу, үгүй юу гэдэг бол бодлогын шийдэл шүү дээ. Тэр бодлогын шийдлийг ярьдаг газар нь энэ Улсын Их Хурал бөгөөд мэргэжлийн Байнгын хороод. Тэгэхээр одоо бол бодлогын шийдлээ дахиад та бүхэн тайлбарлаад өгөөч. Хэрвээ ямар нэгэн байдлаар энэ тэтгэврийг 10,3 хувиар нэмэх бол татаас өгдөг тэр хэлбэр бол байгаа. Сан нь өөрөө байж байгаа. Тэгэхээр энэ бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн урсгал зардлын хязгаарыг давчхаад байгаа учраас хэрвээ бид нар бодлогын шийдэл хийнэ гэвэл энэ төсвийн тогтвортой байдлын хуулиар өөрчлөлт оруулахаас өөр аргагүй болж байна уу гэсэн ийм асуулт байгаа юм. Энэ дээр та тодорхой хариулаад өгөөч.

Б.Найдалаа: 5 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Одоо хэрвээ тэтгэвэр нэмэх асуудал ярих юм бол бид нар шимтгэлийг хий бол нэмэх боломжгүй. Энэ шимтгэлийн орлого маань бол тооцоод гараад ирчихсэн байгаа. Тийм учраас зөвхөн улсын төсвөөс татаас өгөх байдлаар л шийдвэрлэх боломжтой болчхож байгаа гэсэн үг. Нөгөө талдаа энэ 24 хувийн хязгаарлалт гэж нэг зүйл байгаа, дээр нь нөгөө суурь тэнцлийн 2 хувийн ашиг гээд энэ хязгаарлалтууд байгаа. Гэхдээ Сангийн яамны хувьд юу гэж үзэж байна вэ гэхээр урсгал зардлыг бид нар ер нь төсвийн бүтцийн хүрээнд юу гэж үзээд байна гэхээр урсгал зардлыг бол бид нар энэ ДНБ-ий 24 хувь дээр барьж байгаа энэ бодлогыг бол зөв гэж үзэж байгаа. Цаашаа бол энийгээ бид нар хадгалж яваад, одоо тэтгэвэр нэмэх юм бол урсгал зардлаа урсгал зардал дотор нь нэмэх байдлаар явуулаад, нөгөө талдаа юу хийж байна гэхээр хөрөнгө оруулалтын хэсэг дээр бид нар тодорхой хэмжээнд орон зай гаргаад, энэ хэмжээгээрээ эдийн засгийн өсөлтөө нэмж явж байж бид нар улс орныхоо ДНБ өсөлтийг хангаж байж дараа дараагийн тэтгэвэр нэмэх боломж .../минут дуусав/

Б.Найдалаа: Хариулт болсон уу. Тодруулах уу. Гүйцээх үү. 5 дугаар микрофон.

М.Санжаадорж: 24 хувиа бид нар ингэж хадгалж байж цаашдаа улс орныхоо ДНБ-ийг нэмэгдүүлэх ийм боломжтой болж байна гэж үзэж байна. Тэгэхээр ажлын хэсэгт манайхаас ороод ажиллах байх. Бид нар бол шаардлагатай тооцооллуудыг хийж өгнө. Мэдээж хэрэг шийдвэр гаргах нь Их Хурал дээр бүрэн эрхийнхээ хүрээнд эцсийн байдлаар шийдвэр гаргаад явах байх. Бидний хувьд илүү урсгал зардал дотроо энэ пропорцоо хадгалаад, төсвийн энэ пропорцоо хадгалаад нэмэх нь зүйтэй гэсэн ийм зүйл хэлэх байна.

Б.Найдалаа: Батжаргал дарга микрофон 3.

Б.Батжаргал: Гишүүний тодруулгад бас хариулт өгье. 2025 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуульд зааснаар энэ онд 1,4 их наяд төгрөгийн төсвийн дэмжлэгийг нийгмийн даатгалын сан авч ажиллаж байгаа. Энэ дүнгээс яг төрөөс зайлшгүй даах зардлыг хасаад, яг энэ сангийн алдагдалтай холбоотой дүн бол 360 тэрбум төгрөг байгаа. Тэгэхээр 10,3 хувиар хэрвээ нэмэгдүүлэх юм бол түрүүн Санжаадорж даргын хэлдгээр энэ дүн нэмэгдээд улсын төсвийн дэмжлэг бас нэмэгдэж орж ирнэ л гэсэн тооцоололтой байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулах 1 минут байна. Тодруулах уу. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Их тодорхой асуултад тодорхой бас хариултууд өгч байна. Бид бол яг ийм түвшинд мэдээллээ тал талдаа яримаар юм шиг байгаа юм. Тэгэхээр бид хэдийгээр нэмээд өг гээд хүссэн ч гэсэн, шаардсан ч гэсэн хуулийн хязгаарлалтууд бол байна. Тэр хуулийн хязгаарлалт нь өөрөө бодлогын хязгаарлалт байхгүй юу. Тэр бодлогын хязгаарлалтыг давахын тулд бид бол хууль дээр өөрчлөлт оруулахаас өөр аргагүй. Хэрвээ тэгэх болов уу л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энийг бид нар ярилцана гэсэн үг. Хэрвээ саяын зүйлүүдийг шийднэ гэвэл. Нөгөө талдаа бол бас олон нийт зөв ойлгох ёстой. Энд бол сангаас тэтгэвэр авдаг 460 гаруй мянган хүн, цаана нь улсын татаасаар буюу цэргийн тэтгэвэрт гараад төрөөс тэтгэврийг нь хариуцдаг 60-аад мянган хүний асуудал байгаа юм. Тэгэхээр

энэ 2-ын хооронд бас шийдэл хийхтэй холбоотой бэрхшээлүүд байгаа. Тэр бэрхшээлээ бас бид нар яримаар юм шиг байгаа юм. Сан бол дааж чаддагаа даагаад өгчхөж байхад нөгөө талд нь татаасаар өгч болохгүй юм нь нөгөө хуультайгаа зөрчилдөөд байна шүү дээ. Тэгэхээр энэ зүйлүүдийг яриад, тэгээд цаашдаа бол энийг хэрвээ хуулийн хувьд өөрчлөлт хийх бол энийгээ яриад л хийх ёстой л гэж бодож байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Товчхон 2 асуулт асуучихъя. Халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа хүмүүсийн асуудал дээр яг бодитойгоор хэдээс хэд болох вэ гэдэг тоо хэрэгтэй байгаа. Одоогийн байдлаар хэчнээн хүн байна вэ гэдэг ахмадуудын дунд тоог нь хэлээч.

2-т нь давхар зээлтэй, нөгөө тэтгэврийн зээл нь олдохгүй болохоор дахиад өөрөө гар утсаар, аппликэйшнээр маш их зээлүүд энэ тэр аваад байгаа байхгүй юу. Тэгэхээр ахмадуудынх дээр энэ асуудал дээр судалгаа байгаа юу гэдгийг асууя. Давхар давхар зээлийн өрөнд орсон ахмадуудын судалгаа мэдээллийг эхлээд сонсодохъё. Тэгээд дараа нь тодруулъя.

Б.Найдалаа: Хариулт. Микрофон 6.

Г.Борхүү: Гишүүний асуултад хариулъя. Давхар зээлтэй, банкнуудаас гадна бусад банк бус санхүүгийн байгууллагуудаас авсан зээлүүдтэй холбоотой судалгаанууд хийгдсэн. Гэхдээ энэ дээр бол яг тэтгэврийн зээлдэгч нар яг давхар давхар зээл авсан уу, үгүй юү гэдэг нарийвчилсан судалгаа бол байхгүй. Ерөнхий яг нийт банк болон банк бус санхүүгийн байгууллага болон бусад байгууллагуудаас аппликэйшн ашиглаж авсан давхар зээлийн судалгаа бол байгаа.

Б.Найдалаа: 1 дүгээр асуулт. Микрофон 4.

Л.Мөнхзул: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. Нийгмийн халамжийн тэтгэврийг 2025 оны тоон мэдээллээс үзэхэд 61,5 мянган хүн авч байна. 1 сард олгох нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ сарын хэмжээг 397,500, ингээд 6 хувиар нэмэгдүүлэхээр өргөн барьсан төсөл дээр тусгагдсан байгаа. Өргөдлийн байнгын хороо дээр гаргасан ажлын хэсгийн санал, дүгнэлт дээр манай яамнаас бол ажлын хэсэгт өгсөн санал нь амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундаж түвшинд хүргэн нэмэгдүүлэх ийм санал өгсөн байгаа. Энэ тохиолдолд 48,7 тэрбум төгрөг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж гээд мөн сар бүр олгодог. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээтэй тэнцүү 16,4 мянган хүүхдүүд авч байна. Төсөл дээр 6 хувь өргөн барихаар тусгагдсан. 13,2 тэрбум төгрөгийг нэмээд өгчихвөл амьжиргааны.../минут дуусав/

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулах уу. Тэгээд гүйцээгээд хариулчихъя. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: 397,500 төгрөг чинь 6 хувь нь нэмэгдэхээр 400 мянга дөнгөж давсан л дүн гарахаар харагдаад байна. Тэгэхээр ер нь энэ 61.500 хүн нь хүн 400 гаруй мянган төгрөгөөр нэмээд нэмээд амьдарч байгаа ийм л тоо гарч байгаа юм. Тэгэхээр энэ дээр та нар дахиад өөр ямар хувилбар тооцооллууд байгаад, тэр нь

хаа нэгтээ газар очоод рэжектэд болоод байгаа тухай бас сонсчихвол зүгээр байгаад байгаа.

Одоо нийт ахмадуудын хэд нь өнөөдөр зээлтэй байгаа вэ. Тоолж чадаж байгаа дан зээлээ хэлчих. Дан зээлтэй ахмадууд хэд байна. Давхар тоо нь байдаггүй юм байж. Тэрийг сонсьё хэдүүлээ.

Б.Найдалаа: 6 номер уу. Монголбанкнаас асууж байгаа юм уу. 6 номерыг нээгээрэй.

М.Батболд: Сайн байцгаана уу. Монголбанкнаас хэлтсийн захирал Батболд байна. Гишүүний асуултад хариулъя. Хамгийн сүүлийн статистик буюу 2025 оны 8 сарын байдлаар банкнаас тэтгэврийн зээл авсан зээлдэгчдийн тоо маань өөрөө 289.812 байгаа. Тэгээд энэ тоо маань болохоор энэ оны 6 сард болохоор 275.586 байсан. Тэгээд Монголбанкнаас түрүүн хэлсэн 7 сарын эхээр тэтгэврийн зээл тогтоосон байсан хязгаарлалтуудыг бол цуцалсан. Өөрөөр хэлэх юм бол Монголбанкнаас тогтоосон ямар нэгэн хязгаарлалтгүй болсон. Үүний нөлөөгөөр бол зээлдэгчдийн тоо маань эргэн нэмэгдсэн дүнтэй байгаад байгаа.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулна.

О.Саранчулуун: Тэгэхээр нөгөө миний хэлэх гээд байгаа санаа нь 61 мянган хүн хэчнээн төгрөгөөр амьдарч байгаа вэ гэж байгаа юм. Тэгэхээр энэ зээлдэгч дунд халамжийн тэтгэвэр авч байгаа хүмүүс байгаа юу. Яагаад гэвэл над дээр ирж байгаа гомдлууд болохоор группээс буюу хөдөлмөрийн чадвар алдалтаар тэтгэвэрт гарсан хүмүүс дээр банкнуудад зээл олгохгүй байна гэдэг ийм гомдлууд маш их ирж байгаа. Тэгэхээр зээлийн хүү 1 дүгээрт өндөр, дээрээс нь авч байгаа халамжийн мөнгө нь бага, тэгээд зээл авах гэхээр өөрийн чинь орлого хангалтгүй гээд зээл өгөхгүй байна гэдэг ийм гомдлууд маш их ирж байгаа. Банкнууд дээр. Тэгэхээр аль банк дээр халамжийн тэтгэвэр авдаг хүмүүс очиж зээл авах боломжтой юм. Аль банк нь арай жоохон юу гэдэг юм хүртээмжтэй үйлчилгээтэй юм. Энэ дээр мэдээлэл өгөөч.

Б.Найдалаа: Микрофон 6.

М.Батболд: Энэ дээр яг халамжийн тэтгэвэр авдаг гэдэг талаар бол яг нарийн мэдээлэл одоогоор байхгүй байгаад байна. Банкнуудын бас төлөөллүүдээс ирчихсэн байгаа. Эд нар маань яг ямар банк дээр халамжийн болон сангийн тэтгэврийг олгож байгаа гэдэг талаар бас дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжтой байгаа байх.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн уг нь тодруулах тоо бол болчихсон. Түрүүн минутаа бага авсан юм чинь гялс асуучих. Түрүүн товчхон ярьсан юм чинь Саранчулуун гишүүний микрофоныг нээе.

О.Саранчулуун: Тийм та нар нөгөө жагсаж дуугарч чадахгүй хүмүүсийн асуудлыг болохоор шийдэхгүй байгаа байхгүй юу ер нь бол. Одоо би орилж чарлах юм бол нэг юм ярьдаг. Тэгээд жагсаад дуугарч гарч ирж чадахгүй байгаа хүмүүсийн асуудлыг бол ерөнхийдөө орхичихно шүү дээ. Тоолдог ч үгүй, асуудал нь хаана байна гэдгийг хардаг ч үгүй ярьдаг ч үгүй. Би дараагийн удаа энэ дээр шийдэлтэй хариултыг сонсмоор байна. Хүмүүс яах вэ гэр гэрээсээ фэйсбүүк, арай чүү гэж дататай болоод утсаар энэ мэдээллүүдийг сонсож байгаа байх. Тэгэхээр хэдүүлээ энэ дээр нэг гаргалгаатай байя тэгэх үү. 400 мянган төгрөгөөр амьдраад, давхар

зээлийн судалгааг нь хийх хэрэгтэй шүү дээ. 1 ахмад зөвхөн дан мэдээллээр 289 мянган ахмад гэдэг чинь 2 ахмад тутмын 1 нь өнөөдөр зээлтэй байна гээд бод доо. 2 хүн тутмын 1 нь өртэй гэсэн үг байхгүй юу тэтгэврийн мөнгө нь. Тэгэхээр энэ дээр та хэд ийм бодлогын шийдэл гаргахгүй бол энэ тоо чинь юуг хэлээд байна гэдгийг эргэж хармаар байна. Ялангуяа энэ орхигдсон бүлэг дээр бол энэ нөхцөл бүр хатуу тусаж байгаа шүү дээ. Би энийг л хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүний энэ санал бол үнэхээр чухал санал. Миний яг асуух гэж байгаа асуултууд давхцаж байна. Би тодруулаад асуучихъя. Энэ тэтгэврийн зээл гэж байгаа яг үнэндээ 100 хувь тэтгэврийн зээл биш, цаана нь далд зээл явж байгаа. Монгол Улсад зээлийн харилцаа сайн хөгжөөгүйгээс эрсдэл, зээл олгох нөхцөл, бизнесийн орчин болохгүй байгаа болохоор тэтгэврийн зээл нэртэй боловч цаана нь бизнесийн зээл явж байгаа, орон сууцны зээл явж байгаа, машины лизингийн зээл явж байгаа, хэрэглээний зээл явж байгаа. Яг ахмадуудын нэрээр өөрсдөө аваад байна уу, хүүхдүүд нь аваад байна уу, өөр хүн аваад байна уу гэдэг нь далд байгаад байгаа юм. Энийг яг тодорхой мэдэж одоо Саранчулуун гишүүн ч ярьж байгаа тэр шүү дээ. Энийг тодорхой мэдээлэлтэй Монголбанк хариуцаж байгаа бол энийгээ хариуцсан шиг яагаад тодорхой судалгаатай, мэдээлэлтэй баймаар байна.

Тэгээд асуулт нь ирэх 5 жил яах юм ингээд л яваад байх юм уу. 10 жилийн дараа яах юм. Яг энд ингээд дахиад л тэтгэврийн зээлийн хүү яах юм гээд ярьж байх юм уу. Зээлийн нөхцөл нь Байнгын хороон дээр ярьж байх юм уу. Их Хурлын хуралдаан дээр ярьж байх юм уу. Монголбанкнаас би асуумаар байна. Уг нь Монголбанкны Ерөнхийлөгч л яг хариулбал зохих юм байгаа юм. Яг бодлогын хувьд энэ тэтгэврийн зээлийг цаашдаа дэлгэрүүлээд явах юм уу, хөгжүүлээд явах юм уу, хумих юм уу, ямар бодлого баримталж байгаа юм. 5 жилийн дараа байх юм уу, байхгүй юм уу, 20 жилийн дараа байх юм уу, байхгүй юм уу. Энэ дээр хариулаад өгөөч. Микрофон 6. Хэн нь хариулах юм.

Г.Борхүү: Асуултад хариулъя. Монголбанкны Ерөнхийлөгч бол яг өмнөх ажлын хэсгийн хурлууд дээр хэлэхдээ бол тэтгэврийн зээл бол ер нь бусад улс орнуудын жишигт байдаггүй ийм зээлийн төрөл гэж бол ярьсан. Гэсэн хэдий ч гэсэн яг одоогоор бол ритейл буюу жижиглэнгийн банк хариуцдаг банкнууд маань 5 банк дээр тэтгэврийн зээлүүдийг олгоод явж байгаа. Хамгийн гол асуудал нь болохоор яг сар болгон төлөх ёстой зээлийн хэмжээ нь яг дараа нь зээлээ төлчхөөд үлдэж байгаа бас яг тогтмол орлоготой байх хэмжээний ийм байдлаар зээлдэгчдэд өгч байгаа дарамтгүй байх байдлаар ийм зээлийн нөхцөлөө уян хатан байдлаар өөрчилдөг байх ийм тогтолцоо руу илүү шилжвэл оновчтой байгаа л гэж үзэж байгаа.

Дээр нь бас яг ажлын хэсгээс гаргасан саналын хүрээнд бас яг төрөөс яг хүүгийн татаас олгож байгаа ийм асуудлыг бас дэмжиж ажиллахад бас яг энэ зээлийн бүтээгдэхүүн бас цаашаа хөгжиж явах боломжтой л гэж харж байгаа.

Б.Найдалаа: Яг энэ дээр цаашдаа та хэд дотроо ярина биз. Ер нь бол тодорхойгүй л байна шүү дээ. Татаас өгөх гээд байгаа юм шиг, хөгжүүлэх гээд байгаа ч юм шиг, тэгсэн хэр нь байх ёсгүй ч гээд байгаа юм шиг. Ийм байхаар бид нар ийм асуудалд орчхоод байгаа байхгүй юу. Одоо яг зээлийн хүү яриад сууж байна шүү дээ энд. Тэгээд бодлогын түвшний цаашдаа ер нь яах юм гэдгийг нь алсуур нь хийгээд энд ярих асуугдах биш ингээд шийдээд явмаар байгаа байхгүй

юу. Монголбанк болон энэ банкныхантайгаа ярьж байгаад. Баярлалаа. Одоо Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэтгэвэр тэтгэмжийн энэ асуудлыг ярьж байгаа дээр нь бол хэлэх юм бол зөндөө байна. Нийт ахмадуудын 74 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг. 689 мянгаар. Тэгвэл энэ нэмэгдэхээр хэдэн хувь болох вэ. $6 \times 6 = 36$ мянга. Тэтгэвэр ингэж байна.

Тэгвэл өнөөдөр түрүүн Мөнхзул дарга халти ярилаа. Тэтгэмжийн асуудал энд байгаа. Тийм ээ. Тэтгэмжийн асуудал. 302 мянган төгрөгийн тэтгэмж аваад, хөгжлийн бэрхшээлтэй иргэнээ асарч байгаа тэр иргэн, тэр гэр бүл яаж амьдрах вэ.

1 дүгээр асуултад, дарга аа яг заавал хариулуулаад өгөөрэй. 302 мянган төгрөгөөр та амьдарч чадах уу гэдэг энэ үгэнд заавал хариулж өгөөрэй.

2 дугаарт 302 мянган төгрөгийн тэтгэмжтэй хүн дээр 6 хувь хэдэн төгрөг юм. $3 \times 6 = 18$ мянга, 18,200 төгрөг 1кг мах авч чадахгүй. 7 ширхэг талхны мөнгө шүү дээ. 7 ширхэг талхны мөнгө өгчхөөд энэ дээр нэмэлт хийсэн гэвэл энэ болохгүй. Удаа дараа яам руу бол хандаж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал яагаад яригдахгүй байна вэ гэвэл яг түрүүн хэлсэн жагсахгүй байгаа болохоор, үзэл бодлоо илэрхийлэхгүй байгаа учраас. Үгүй ээ, тэр чинь яаж жагсах юм бэ. Өвчтэй хүнээ хаячхаад тэр хүн яаж жагсах юм. Өвчтэй байгаа хүн хүртээмжгүй энэ нийгэмд гэрээсээ гараад яаж талбай дээр ирэх юм. Тийм боломж байхгүй. Тийм хүртээмж байхгүй. Тэгэхээр энэ асуудлаа шийдээч ээ. Амьжиргааны доод түвшин Улаанбаатар хотод 497 мянган төгрөг. Тэгэхэд энэ хүмүүсийг яаж амьдар гэж байгаа юм. Бид нар Үндсэн хуулиа зөрчөөд амь зогоо гэж байна. Эсвэл бүр тусад нь улс гаргах хэрэгтэй. Энэ дээр дорвитойхон шийдлийг гаргах хэрэгтэй байна. Бүгдээрээ нийлээд. Би бүр арга ядаад 30 хувь нэмж өгөөч ээ гээд Саранчулуун бид 2 саналаа гаргаад явж байгаа. Үгүй ээ, тэр Оюутолгойн гэрээн дээрээ анхаараад өгөөч ээ. Илүү тэр нөгөө нэмэлт зардлуудаас хасаад өгөөч ээ. Тэтгэвэр, тэтгэмжийн асуудал оруулаад ирсэн дээр энэ дээр хамтатгаад яваач ээ гэж байгаа.

302 мянган төгрөгөөр амьдарч чадах уу. Бид нар чадахгүй. Хэн нь ч чадахгүй, маш хэцүү байдаг. Энэ чинь ерөөсөө өвчтэй хүний сарын памперсны хэрэглээ шүү. Эм тариа, тэр хоол хүнс, нөгөө цахилгаан төлөх ямар ч боломжгүй. Дандаа ойр тойрныхноосоо мөнгө гуйдаг, эргээд тэр болгоноосоо хаягдаж байдаг. Нийгэмдээ хаягдаж байдаг. Тэгэхээр энэ дээр ялгаа байхгүй хөгжлийн бэрхшээлтэй ахмадууд энэ дунд маш их байгаа шүү дээ. 28,2 мянган ахмад настан амьжиргааны баталгаажих түвшнээс доор амьдарч байгаа.

Б.Найдалаа: Асуулт улс төрийн шинжтэй асуулт байна. Нөгөө нэг улс төрч хариулах ёстой. Микрофон 4.

Л.Мөнхзул: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. Маш зүйтэй асуудал хөндөж байна. Түрүүн дурдахад нийгмийн халамжийн тэтгэврийг барьцаалан ямар нэгэн зээл олгодоггүй. Яагаад гэхээр халамжийн тэтгэвэр гэдэг бол нэн шаардлагатай хэрэглээтэй амьжиргааны зардал байгаа. Тэгээд Баясгалан гишүүний хэлсэнчлэн бүсүүдийн амьжиргааны доод түвшний дундаж 488 мянган төгрөг байгаа. Хэрэв ажлын хэсэг

байгуулагдаад судлах тохиолдолд бид бол энэ нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг дор хаяж амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай уялдуулан 488 мянган төгрөгт хүргээч ээ гэдэг ийм саналыг бол оруулж ирж байгаа. Тэгээд 61,8 тэрбум төгрөг нэмж шаардлагатай юм. 1 дүгээрт.

2 дугаарт Монгол Улсын нийгмийн халамжийн зардал 2,6 их наяд боловч яг зорилтот бүлэгт энэ халамжийн зардлын 25 хувь нь очдог. Нийт халамжийн хамгийн бага амьжиргаатай хүн амын 40 хувь нь нийт халамжийн сангийн зардлын 37 хувийг авдаг бол өндөр амьжиргаатай хүн амын 40 хувь нь нийт халамжийн сангийн зардлыг мөн 30 хувийг авч байдаг. Тэгэхээр нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, шаардлагатай юманд нь зохистой хэмжээтэй болгоё, халамжийн шинэчлэлийн хуулийг шинэчилъё гэдэг энэ зорилтыг бол үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан. Тэгээд хуулийн төслийн шинэчлэлийг бол манай яамнаас боловсруулаад, яамны нэгдсэн веб хуудас дээр тавьж санал авч байгаа. Тэгэхээр удахгүй энийг бол Засгийн газраас оруулж ирэх төлөвлөгөөтэй байгаа.

Б.Найдалаа: Баясгалан гишүүн тодруулах уу. Баясгалан гишүүн та асуултаа дахиад тодорхой тавьж болно.

Ж.Баясгалан: Нөгөө асуултад та хариулсангүй. Та шударгаар хариулаарай. Иргэн хүнийхээ хувьд 302 мянган төгрөгөөр 1 гэр бүл, танай гэр бүл амьдарч чадах уу гэдэг асуулт байгаа. Энэ асуулт хариулчхаарай.

2 дугаарт гэвэл үнэхээр яг сая зөв хэллээ шүү дээ. Ядаж амьжиргааны доод түвшний хэмжээнд аваач гэж байгаа юм. Энэ бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 397 мянган төгрөгийг амьжиргааны доод түвшинд аваачъя. Гол нь тэр хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа хүн бол 24 цагийн турш тасралтгүй хүнд хөдөлмөр эрхэлж байгаа. Энэ хүмүүсийнхийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний түвшинд аваачаад өгөөч ээ гэсэн ийм саналтай байгаа. Хэрвээ үнэхээр Засгийн газар, яам энэ саналаа оруулаад ирвэл бүүр 100 хувь дэмжээд явна. 100 хувь түүчээлээд явна. 100 хувь энэ дээр санаачилгатай ажиллана шүү. Тэгэхээр сая таны амнаас маш гоё мэдээ сонслоо. Энийг олон хүн сонсож байгаа.

Б.Найдалаа: Хариулт 4 номер.

Л.Мөнхзул: Баясгалан гишүүний хэлж байгаа зүйл нь бас бодитой л доо. Нийт улсын түвшинд халамж хавтгайрлаа гэж ерөнхий яриа, зүйл нь яг нэн шаардлагатай бүлэгт зориулагдсан нийгмийн халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэх, байнгын асаргаа шаардлагатай иргэдийн сарын тэтгэмжийг нэмэгдүүлэхэд төвөгтэй байдалд оруулдаг. Бид саналаа боловсруулдаг. Энэ бол олон нийтийн дэмжлэг жишээлбэл авдаггүй. Тухайлбал төсвийн саналын хэлэлцүүлгээр хамгийн багасах ёстой зүйл маань нийгмийн халамж гэж олон нийтийн зүгээс дүгнэлт гарч ирсэн. Энэ нь ямар учиртай вэ гэхээр өнөөдөр хүүхдийн мөнгө 1,6 их наяд, цалинтай ээж хөтөлбөр гээд нийтлэг мөнгөн тусламжууд болон гэр бүлийг дэмжих чиглэлийн мөнгөн тусламжууд халамжийн мөнгөн тусламжууд нэг дор байгаа учраас энийгээ салгая гэдэг ийм зарчмын санал л тавиад байгаа. Нөгөөтээгүүр нийгмийн халамж бас олон жижиг хэмжээтэйг хуваагдмал болгоод байгаа юм. Нийгмийн халамжийн тэтгэвэр 395 мянгыг авна. Энэ дээр нэмээд байнгын асаргааны тэтгэмжээ .../минут дуусав/

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. 1 минут.

Л.Мөнхзул: Мөн түүнчлэн хөнгөлөлт тусламжийн хэмжээ авна. Түлээ нүүрсний мөнгө гэж жилд 1 удаа 140 мянган төгрөг, зарим тохиолдолд хараагүй иргэдэд зориулсан жилийн 20 мянган төгрөг гэх мэт нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж маань олон жижиг хуваагдмал байгаа нь бас их төвөгтэй байдалд оруулаад байгаа. Тэгэхээр эдгээрийг нэгтгээд, халамжийн тэтгэвэр тэтгэмжийг оновчтой түвшинд тогтоож, зохистой хэмжээгээр олгоё л гэж байгаа юм. Тэгэхдээ ажил хөдөлмөр эрхлэх боломжтой байгаад, ажил хөдөлмөр эрхлээгүй хүмүүст бол амьжиргааны түвшин ядуу бол олгоё, үгүй бол олгохгүй. Амьжиргааны түвшинтэй уялдуулъя гэдэг бас энэ зорилтыг оруулж ирж байгаа.

Б.Найдалаа: Баясгалан гишүүн тодруулна.

Ж.Баясгалан: Сайхан мэдээ өгч байгаад баярлалаа. Тэгэхдээ түрүүчийн асуусан ганцхан асуултад хариулаад өгөөч Та эх хүн ялгаагүй. Тийм болохоор 302 мянган төгрөгөөр 1 сар танай гэр бүл амьдарч чадах уу. Ганцхан асуулт.

Б.Найдалаа: Микрофон 4.

Л.Мөнхзул: Гишүүний асуулт илүү хувь хүний шинж чанартай асуудал байх шиг байна. Тэгэхээр 392 мянган төгрөг бол 1 хүнд олгож байгаа сарын тэтгэвэр. Энэ дээр нэмээд мөн 300 орчим мянган төгрөг тэтгэмж хэлбэрээр авна. Сарын тусламж хөнгөлөлт авна гэх мэт тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ямар гэр бүлд амьдарч байгаагаас шалтгаалан харилцан адилгүй хэмжээтэй авах учраас шууд ингэж тэд гэж хэлэх нь бол зохисгүй юм. Яамнаас барьж байгаа бодлого бол нийгмийн халамжийн тэтгэвэр наад захын хүний амьжиргааг хангасан байх ёстой буюу бүсүүдийн амьжиргааны доод түвшнийг ядаж хангаж байх ёстой гэдэг энэ бодлогоо л бид нар санал болгож байгаа. Тэгэхээр дор хаяж 90 мянган төгрөгөөр нэмэгдүүлээч ээ гэдэг саналыг бид нар төсвийн төсөл дээрээ ч тусгаж явж байгаа. Бүхий л түвшинд бол саналаа өргөөд л ингээд явж байгаа.

Н.Найдалаа: Тэгвэл тодруулаад би асуучихъя. Одоо яг энэ тэтгэмжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ рүү хүргэх бодлого байгаа юу, байхгүй юу. Микрофон 4.

Л.Мөнхзул: Яах вэ, шууд Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг тэд хүргэнэ гэхээс илүү нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд үндэслэсэн байх нь зүйтэй гэж бодлогын хувьд бол бид нар зорьж байгаа. Хэрвээ магадгүй насаараа хөдөлмөр эрхлээгүй, хүүхдээ харж байсан гэхдээ амьжиргааны хувьд боломжтой тэр хэсгийн бүлэгт заавал сарын 392 мянган төгрөгийг санал болгох нь зүйтэй юу. Магадгүй тухайн хүн өөрөө хүсэхгүй бол энийг заавал халамжийн тэтгэвэр өгөх ёстой юу. Магадгүй хувийнхаа орлогыг аваад явж байгаа тохиолдолд. Гэтэл байнгын асаргаа шаардлагатай, олон давхар эмчилгээ шаардлагатай энэ бүлгийн хувьд бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ байтугай хэрэгцээнд нь тохируулж л өгөх ёстой байдаг.

Бусад орнуудын жишиг нь ч тийм.

Б.Найдалаа: Ойлголоо. Маш их баярлалаа. Гэхдээ яах вэ, зүгээр одоо энд Их Хурлын гишүүд бодлогын түвшний юм ярих гээд яг ингээд бодлого хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчдаас шалгаагаад байхаар бас жоохон тохиромжгүй болчихоод байна л. Яг үнэнийг хэлэхэд. Сайд гэж хүн чинь улс төрч, гишүүн. Тэгээд яг энэ бодлогоо ярьдаг, яах гээд байгаагаа хэлдэг тэр газар нь Тэгэхээр асуулт нь

хаяг нь буруу болчихоод байна. Тэгээд та бүхнийг ойлгож байна. Зүгээр цаашдаа харин бид нар одоо жишээлбэл тэр халамжид нийт нийгэм дургүй болчихоод байна. Тэрийг хэн засах ёстой юм. Танай сайд, танай Засгийн газар. Бодлого нь зөв байх юм бол тэрийгээ итгэж яриад үнэмшүүлээд, муулуулаад, сайлуулаад явах ёстой байхгүй юу. Тэгэхээр төрийн албан хаагчид бол буруу байхгүй. Ойлгомжтой. Тэгээд тиймэрхүү болохоор би дахиад хэлэхэд дараа дараагийн удаа бас сайд нартай нь энэ гишүүд яримаар байгаа байхгүй юу. Бодлого л яримаар байгаа байхгүй юу. Яаж шинэчлэх гээд байгаа юм. Яаж нэмэх юм. Боломж байгаа юм уу, байхгүй юм уу. Баярлалаа. Дараагийн нь Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Тэтгэврийг тойроод бид нар бүтэн жил ярьж байна. Ярилцаж байна. Иргэд болон ахмадууд ямар шүүмжлэл хэлж байна вэ гэхээр та нар шийдэл гаргаад яваач ээ. Яриад л байх юм, яриад л байх юм. Хэдэн гишүүд тойроод л яриад байх юм. Яамны төрийн албан хаагчид хариулаад л байх юм. Шийдэл гаргая л даа. Засгийн газар хурдхан шиг юмаа өргөн барь. Өөр арга байхгүй. Одоо дахиад Байнгын хороо дээр энийг яримааргүй байна. 3 ярилаа шүү дээ. 3 удаа. Тэгээд ямар ч шийдэл байхгүй. Тэгээд энэ хэвлэл мэдээллээр гардаг. Бараг ичиж байна энэ асуудлаас.

Тэгэхээр би 1 дүгээрт ийм юм хэлмээр байгаа юм. Энэ тэтгэврийн хэмжээний асуудал ярьж байгаа юм. Тэгэхээр энэ хэмжээний нөгөө миний яриад байгаа инфляцтай уялдуулна гэдэг чинь буруу юм. Энэ хуулийн заалтыг их логикгүй хүн бичжээ. Мөнгө үнэгүйдэхээр тэтгэвэр нэмнэ гэдэг чинь буруу. Тэтгэврийн хэмжээг өнөөдрийн хөдөлмөрийн орлого буюу дундаж цалингийн хэдэн хувь байх вэ гэдгээр индексжүүлж улс орнууд жагсаадаг. Дунджаар бол өнөөдрийн хөдөлмөрийн орлого буюу дундаж цалингийн 60 орчим хувь гэж үзэж байгаа. Тэгэхээр 1,3 сая төгрөгийн дундаж тэтгэвэр гарч байгаа. Энэ 1,5 сая төгрөгийн тэтгэвэртэй больё гээд гадаа жагсаж байгаа ахмадууд бол зөв уриалга дэвшүүлж байгаа. Шинжлэх ухааны үндэстэй юм яриад байна. Тэгэхээр энийг нэмэгдүүлье гэхээр тэтгэврийн сангийн мөнгө хүрэхгүй байна шүү дээ. Төсвийн мөнгө хүрэхгүй байна. Бодит үнэнээ бид нар хүлээн зөвшөөрье. Энэ удаагийн Улсын Их Хурал 1 удаа Баялгийн сангийнхаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад, энэ уул уурхайн баялгийг энэ ахмад үедээ шударга, зөв хүртээх, ингээд нөгөө тэтгэврийн сангийн зузаатгалыг хийж болох байхгүй юу. Тэгэхээр бид нар бол энэ дээр зоригтой баймаар байна. Одоо нэгэнт төсвийн мөнгө хүрэхгүй. 5,6 их наяд байхгүй байна. Тэгэхээр яах юм бэ гээд тойрч яримааргүй байна. Шийдлүүдээ ярь. Баялгийн сантайгаа яаж уялдуулах юм бэ. Ингээд хөдөлмөрийн орлогын 60 хувь буюу 1,3 сая төгрөгийн тэтгэвэртэй болох боломж байна гэдгийг хэлье.

2 дугаарт нь энэ тэтгэврийн санг яамнууд булаацалдсанаас л болж байгаа шүү дээ. Энэ Хөдөлмөрийн яам мэдэх ёсгүй. Нийгэм хамгааллын яам мэдэх ёсгүй. Улс төрчид тэтгэврийн санг удирдсанаас болоод тэтгэврийн сан дампуурсан. Тэтгэврийн санг удирдах нь тэтгэврийн институт байх ёстой. Энэ мэргэжлийн байгууллага байх ёстой. Энэ менежмент хийгээд, тэр тэтгэврийн сангийн мөнгийг бүр өсгөдөг, өгөөж болгож өгдөг ийм сан байх ёстой. Ийм байгууллагыг байгуулъя л даа. Солонгос ийм байна. Япон ийм байна. Би ирэх 7 хоногт Солонгост энэ уулзалт хийх гэж байна. Би хуулийн төслийг нь бэлэн болгочихсон. Одоо та нар надаас шаардлагатай гэвэл ав. Би Засгийн газарт хуулийнхаа төслийг өгье. Монголчуудын тэтгэврийг сайхан болгоё.

3 дугаар асуудал юу юм бэ гэхээр энэ тэтгэврийн зээл гэдэг бүтээгдэхүүнийг банкаар дамжуулах юм бол банк л баяжиж байна. 16 хувийн хүү. Энэ тэтгэврийн зээлийг тэтгэврийн институт өөрөө .../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут нэмье.

Ц.Баатархүү: Солонгосын тэтгэврийн зээл 2-3 хувийн хүү байгаа. Энэ тэтгэврийн институт өгч байгаа. Гэхдээ тодорхой шалгууртай өгнө. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, яаралтай үе, гамшиг, боловсрол, гэр бүлд нь тохиолдсон янз бүрийн ийм нөхцөлүүдийг хангах юм бол маш бага хүүтэй 2-3 хувийн хүүтэй тэтгэврийн зээлийг өгдөг банк биш институт. Тэр хүн энийг тэтгэврийн зээл гэж нэрлэдэггүй. Тэтгэврийн урьдчилгаа гэж нэрлэдэг. Өөрийнхөө ажил хөдөлмөр хийж хадгалуулсан мөнгөнөөсөө тодорхой хэсгийг урьдчилж авч байгаа. 800 мянган тэтгэвэртэй хүн бол дараа сараас нь эхлүүлээд 700 мянга болгоод ингээд сар болгон 100 мянган төгрөг хасуулаад ингээд урьдчилгаа авсан мөнгөө төлдөг ийм систем рүү дэлхий явж байна. Энэ моделийг бүрэн өөрчилье. Энэ банкаар дамжуулахаа больё гэдэг саналыг хэлье. Энэ хуулийн төсөл бэлэн болж байгаа шүү гэдгийг хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Асуулт байхгүй. Үг хэллээ. Баярлалаа. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Юуны өмнө ажлын хэсэгт талархлаа илэрхийлье. Асуудлыг бас тодорхой шийдэл гарцтайгаар тодорхойлж оруулж ирсэн байна гэж харж байна. Ер нь бид нар нэг асуудал хөндөгдөхөөр ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсгийнхээ санал, дүгнэлтийг Байнгын хороогоор хэлэлцээд, төрийн албан хаагчид ирж хариулаад, гишүүд асуугаад, ингээд л шийдэл нь юу юм гэдэг нь тодорхойгүй л болчихоод байгаа юм, сарничаад байгаа юм. Тийм учраас би энэ ажлын хэсгийн ажлын үр дүнг бодит гүйцэтгэлд нь ойртуулж бас энэ ажлын хэсэг ажилласны үр дүн гаргахын тулд тодорхой бодлогын шийдэл гаргаасай гэж Байнгын хороодын дарга нараас хүсэж байна.

1 дүгээр асуудлын хувьд өнөөдөр төсөв дээр 6 хувиар тэтгэврийн нэмэгдэл орж ирсэн. Монгол Ардын намын бүлэг улс төрийн шийдэл гаргаж 8,5 хувь буюу тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, тэтгэвэр, тэтгэмжийн сангаас олгох энэ хуультай нийцэх ёстой гэдэг улс төрийн шийдэл гаргаж танилцуулсан. Ажлын хэсэг бол 10,3 гээд ингээд 3 хувийн асуудал яригдаж байна. Тэгэхээр энийг бол би төсвийн ажлын хэсэг рүү Улсын Их Хурлаас байгуулагдах төсвийн ажлын хэсэг рүү шилжүүлж, тэтгэврийн нэмэгдлийн асуудлыг авч үзэх нь зүйтэй гэдгийг хэлмээр байна.

2 дахь асуудал дээр яг энэ тэтгэвэртэй холбоотой асуудал дээр бол зээлтэй холбоотой, тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлыг Монголбанк руу, Засгийн газар луу ажлын хэсгийн гаргасан саналын дагуу тодорхой үүрэг чиглэл өгсөн тогтоол гаргах нь зүйтэй гэж бодож байна.

Дараа нь энэ үүргийнхээ хэрэгжилт, биелэлтийг шаарддаг, үздэг, хардаг, ямар өөрчлөлт гаргасан байна гэдгийг ингэж хянаж, ард нь хариуцлагын механизм ярьж байхгүй бол бид нар зүгээр л сайхан асуусан болоод, хариулсан болоод л ингээд дуусах гээд байна л даа.

Тэгэхээр энэ Байнгын хорооны хурал дээрээс 2 тодорхой бодлогын шийдэл гаргаасай гэдэг хүсэлтэй байгаагаа илэрхийлье. Төсвийн асуудлыг ер нь бид нар

өнөөдөр ингээд шаардаад, нэхээд, тодорхой тэтгэвэр тэтгэмжийг ч юм уу төрөл зүйлээр нь нэмэх ёстой гээд л нэхээд байгаа юм. Цаашдаа бид бол төсвийн бүтцээ, зардлын ангиллаа төсөвт тавигдаж байгаа энэ тусгай шаардлагынхаа шинэчлэлийг хийхгүйгээр төсөв дээр ямар нэгэн зардал нэмнэ гэдэг ойлголт байхгүй. Гарч чадахгүй ээ. Урд хормойгоо авч, хойд хормойгоо нөхөх тухай асуудал л ярьж байгаа юм. Өнөөдөр бол аргацааж байгаа.

Тэгэхээр энэ дээр манай Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудал, зардлын ангилал, төсвийн бүтэц, төсвийн тусгай шаардлагатай холбоотой хууль, эрх зүйн өөрчлөлтөө оруулж ирж байж энэ боломжууд нээгдэнэ. Өндөр настны тэтгэвэр ч тэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж ч тэр бүх төрлийн халамжууд, төрийн албан хаагчдын цалин хөлс .../минут дуусав/.

Б.Найдалаа: 1 минут нэмье. Үүрийнтуяа гишүүнд 1 минут.

Д.Үүрийнтуяа: Энэ бүх асуудлыг бодлогын өөрчлөлт хийсний дараа бид нар системтэйгээр дорвитой өөрчлөх боломж гарна уу гэхээс өнөөдөр зөвхөн өндөр насны тэтгэврийг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмжийг, багш, эмч нарын цалинг сугалж авч яриад бид нар асуудлыг шийдэхгүй. Тийм учраас энэ дээр бол дорвитой улс төрийн шийдлээ богино хугацаанд гаргаж ажиллаач ээ гэдгийг эрхэм сайд нараас хүсмээр байна.

Төрийн албан хаагчид, Монголбанкныханд би жоохон шүүмжлэлтэй хандах гээд байгаа нь хэдүүлээ хууль тайлбарлахгүй ээ. Тэтгэвэр, тэтгэмжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулж гэдгийг инфляцын түвшнээр биш гээд бид тайлбарлаад сууж байж болохгүй л дээ. Төрийн албан хаагч бол хууль хэрэгжүүлэх үүрэгтэй. Асуудал байгаа бол харин энийгээ өөрчлүүлэх саналаа оруулж ирэх хэрэгтэй. Тэрнээс өнөөдөр Байнгын хороо дээр ирчхээд хууль тайлбарлаад сууж байгаа нь эрхэм Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар аа, зохимжгүй байна шүү. Монголбанк энэ олон улсын жишгээ ярьдгаа болих хэрэгтэй шүү.../минут дуусав/

Б.Найдалаа: Үүрийнтуяа гишүүнд 1 минут.

Д.Үүрийнтуяа: Өмнөх Байнгын хорооны хурал дээр ч гэсэн Монголбанк энэ тэтгэврийн зээлийг олон улсын түвшинд харьцуулаад л олон улсад бид нар тэтгэврийн зээл гэдэг юм байдаггүй л гээд байгаа юм. Тэгвэл бид нар Монгол Улсад өөрсдийнхөө байгаа нөхцөл байдал дээр санхүүгийн зах зээлээ, мөнгөний бодлогоо тэр яриад байгаа олон улсынхаа түвшинд хүргэхээд тэр шаардлагаа тавимаар байгаа юм. Тэгээд өнөөдрийн байгаа нөхцөлд тэтгэврийн зээл юунд зарцуулагдаад байгаа вэ гэдгийг үз гэдэг бол зөв шүү. Тэтгэврийн зээл сургалтын төлбөрийн зардалд явж байгаа. Тэтгэврийн зээл эмчилгээний зардалд явж байгаа. Тэтгэврийн зээл үр хүүхдүүдийнх нь орон сууцын зээл рүү явж байгаа. Нэмэр болгох гээд өгч байгаа. Тэгэхээр энэ юунд яваад байгаа юм бэ. Энэ яг ямар зориулалттай зээл юм бэ гэдэг ухагдахуунаа гаргаж ирж байж үндсээр нь, углуургаар нь ярихгүй бол дөнгөж 1 үзүүрээс нь шүүрч аваад, саваад, сэвээд яваад байж болохгүй байх. Тэгээд энэ дээр манай бодлогын төрийн захиргааны төв байгууллагууд бодлогын шийдэл гаргаж ажиллахыг хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа. Үг хэллээ. Эрдэнэбат гишүүн байхгүй байна. Энхтуяа гишүүн.

Д.Энхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. 1 талаас манай ахмадууд маань тэтгэвэр тэтгэмжийг нэм, тэтгэврийн доод хэмжээг 1,5 болго гээд шаардаж байгаа. Салбарын яам бол тэтгэврийн доод хэмжээг 1,5 сая төгрөг болгоход 4 гаруй их наяд төгрөг хэрэгтэй. Энэ бол өнөөдөр бас улсын төсөвт маш хүнд ачаалал болохоор энэ бас боломжгүй юм гээд мэдэгдчихсэн байгаа. Нөгөө талаас улс төрч, гишүүний хувьд би энэ тэтгэврийн доод хэмжээг 1,5 болгох бүрэн боломжтой гээд бас хэлсэн. Энэ мэдээллүүд бол ахмадууд маань очсон байгаа. Өнөөдөр энэ төсвийн хэлэлцүүлэг дээр надад бол энэ төрийн албан хаагчид бас асуулт алга байна. Гэхдээ бид нар энэ 1,5 сая төгрөг болгох 4 их наяд төгрөгийг инфляцын түвшинд уялдуулж 6 хувиар нэмэхэд хэчнээн төгрөг хэрэгтэй байна вэ. Энийг аль төсвөөс яаж, аль салбараас танаж гаргах вэ гэдгээ бид нар бас үг уралдуулаад ярь гэж байна. Тэгэхдээ бас Үүрийнтуяа гишүүнтэй би санал нэг байна. Бид нар боломжит хувилбарыг углуургаар нь харах ёстой юм. Тэгэхгүй бол өнөөдөр аль нэгэн салбараас яг үйл ажиллагаа нь яваад, хэлбэржээд мөн дасан зохицоод болчихсон бүх энэ салбараас танана гэдэг бол бас үнэхээр байж боломгүй зүйл байгаа юм. Тэгэхээр өнөөдөр бол Монгол Улсад хэрэгжиж байгаа хуулиас би эш татаад боломжийг хаанаас харж байна вэ гэвэл Засгийн газарт бас Улсын Их Хурлын гишүүний хувиар бас Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж болох юм. Энэ дээр бол манайх уул уурхайн салбарт АМНАТ буюу энэ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэсэн энэ үгийг хэрэглэдэг. Өнөөдөр бол яг хэрэглэж байгаа хуулиар өнөөдөр Ашигт малтмалын тухай хуулиар өсөн нэмэгдэх АМНАТ гэж бид нар ярьдаг. Энэ өсөн нэмэгдэх АМНАТ-ийг бид нар ажил хэрэг, жишээлбэл Оюутолгойн гэрээг сайжруулах, шинэчлүүлэх 2 ажлын хэсэг Засгийн газар дээр гарсан гэж сонссон. Тэгэхээр энэ ажлын хэсэгт бид нар бас Байнгын хорооноосоо санал тавих ёстой. Улсын Их Хурлын тогтоолын төслийг бас боловсруулах ёстой юм болов уу гэж бодож байна. Өнөөдөр бас Ашигт малтмалын тухай хуулиар өсөн нэмэгдэх АМНАТ төлөх ёстой. Жишээлбэл энэ АМНАТ-ийг Эрдэнэт үйлдвэр төлж байгаа. Оюутолгойн гэрээнд бол маш олон зүйлийг сайжруулах, шинэчлэх, өөрчлөх шаардлагатай гэж бид үздэг. Тэгэхээр энэ мэтчилэн өнөөдөр бол энэ өсөн нэмэгдэх АМНАТ-ийг Оюутолгой компани бол төлөхгүй байгаа. Тийм учраас бид нар энэ боломжуудыг хараад үнэхээр л Үндсэн хууль дээрээ байгалийн газар доорх баялаг бүх ард түмний өмч л гэсэн юм бол Эрдэнэт үйлдвэр яагаад төлөөд, Оюутолгой компани яагаад гэрээндээ өөрчлөлт оруулж болдоггүй юм бэ гэдэг энэ асуудлыг бол тавих ёстой юм болов уу гэж бодож байна.

Тэгэхээр өнөөдөр бид нарт боломж байгаа гээд би хэлчихсэн байгаа. 1,5 сая төгрөг болгох бүрэн боломжтой гээд хэлчихсэн байгаа гэх мэтчилэн өнөөдөр манай Байнгын хорооноос Улсын Их Хурлын гишүүд маань .../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут нэмэх үү. Энхтуяа гишүүнд 1 минут.

Д.Энхтуяа: Улсын Их Хурлын тогтоолын төсөл бас боловсруулж, Засгийн газарт өгөх ёстой гэж би бодож байна. Одоо бол яг Оюутолгой дээр бас Оюутолгойн энэ гэрээг авч хэлэлцэх манай Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарчихсан байгаа. Засгийн газар дээр бас ажлын хэсэг гарсан гэж би түрүүн бас хэлсэн. Тийм учраас бид нар энэ баялгийн санг яаж арвижуулах вэ. Баялгийн сангаараа дамжуулаад өнөөдөр ахмад настныхаа тэтгэврийн доод хэмжээг 1,5 сая болгох ийм боломж бид нарт маш ойрын хугацаанд байна гэж би харж байна. Яг өнөөдөр биш юм гэхэд бид нар ирэх жил бас ахмадын хамгийн бага тэтгэврийг бол 1,5 сая болгох боломжтой байна.

Энэ дээр нөгөө саяын миний хэлсэн өсөн нэмэгдэх АМНАТ-ийн зохицуулалтыг энэ Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулж, тусгаж өгөх шаардлагатай гэсэн ийм саналыг гаргаж байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгээд сая гишүүдийн ярьсан бид нар бас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр олонтой ярилцсан санал нэг байгаа. Эмч, багш нарын цалин, тэтгэврийн хэмжээг нэмэх ёстой. Харин зүгээр яг одоогийн бид нарын төсөв боловсруулж байгаа яамдаас Засгийн газраас барьж байгаа бодлогын хүрээнд иймэрхүү бүтцээр, иймэрхүү маягаар төсвөө боогоод, иймэрхүү маягаар хэлэлцээд, иймэрхүү маягаар жагсаад байх юм бол цалинг ч, тэтгэврийг ч нэмэх боломж байхгүй. Угаасаа боломжгүй. Тэгэхээр бүтцийн гэдэг юм уу, зарчмын, үзэл санааны хандлагын өөрчлөлт гарч байж хийхээр байна. Жишээлбэл 6 хувь нэмлээ гэж бодъё тэтгэврийг. 6 хувь гээд жагсаж, жагсаж, бужигнаж, бужигнаж арайхийж 6 хувь нэмлээ. Үнийн түвшин 10 хувиар өснө. Энэ чинь угаасаа эдийн засгийн хууль шүү дээ. Тийм болохоор бодит тэтгэвэр, бодит цалин буурсаар яваад байгаа. Олон жилийн турш ингэж яваад байгаа юм. Тэгэхээр жагсахаас өөр арга байхгүй. Энийг харин жагсахгүйгээр, хэл ам хийхгүйгээр, ингэж зовохгүйгээр салбарын яамд маань бодлогоо гаргамаар байна. Би дахиад хэлье. Бодлогоо гаргамаар байна. Нийгмийн даатгалын сангийн шинэчлэлийг яаж хийх юм. Сая гишүүдийн яриад байгаа тэр эх үүсвэр дутах юм бол хаанаас авах нь Засгийн ажил. Боломж нь байгаа байхгүй юу. Сая нар АМНАТ байна уу, Баялгийн сан байна уу. Шинэчилъё л гэж байгаа бол төсвийг нь зоригтой тавьж байгаад шинэчлээд, үе шаттайгаар, хэл ам болохгүйгээр, жагсахгүйгээр нэмээд явах ёстой. Тэгэх юм бол инфляц болохгүй. Тэгэх юм бол үнийн өсөлтөд нөлөөлөх нь бага байх болно.

Тэгээд иймэрхүү төрлийн бодлогын гэдэг юм уу шийдлийг зоригтой хиймээр байна. Тэгээд Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас Батжаргал дарга аа, Мөнхзул дарга аа дараа нь яамаар байна. Уг нь сайдтай бас ярьсан. Гэхдээ манай Байнгын хороо дээр хамаг хүсэлт, өргөдлүүд байгаа. Бид нарт яг тэр яг яах гээд байгаа саяын тэр яриад байгаа бодлогын шийдлээ сайдтайгаа ярьж байгаад тодорхой танилцуулмаар байна. Тэгээд асуудлын шийдлийг түрүүний цалинтай адилхан би 2 түвшинд харж байна.

Эхнийх нь одоо бид нар санал хураагаад, энэ асуудал яг үнэнийг хэлэхэд бодлогын гэхээсээ илүү төсвийн асуудал байгаа. 2026 оны төсөвт суулгаач ээ гэсэн асуудал байгаа. Тийм болохоор Төсвийн байнгын хорооноос байгуулах төсөвтэй холбоотой ажлын хэсэгт энэ асуудлыг шилжүүлэх ёстой. Богино хугацаанд, ямар хэмжээгээр яаж нэмэх боломжтой юм. Нөөц эх үүсвэр нь юу байгаа юм.

2 дахь нь түрүүний миний хэлдэг бодлого. Нийгмийн даатгалын сангаа яаж өөрчлөөд, эх үүсвэрээ хаанаас олоод, түрүүний Баясгалан гишүүний яриад байгаа тэр халамжийг хөдөлмөр хөлсний доод хэмжээнд аваачиж чадах юм уу. Тэтгэврийг 1,5 сая болгож чадах юм уу. Чадахын тулд юу хийх ёстой юм гэдгийг тодорхой гаргаа, тэр дээр нь харин байнгын хороодоос дэмжлэгийг нь үзүүлээд бид нар ажиллана. Тэгээд энэ танилцуулгыг хийгээрэй гэж хүсье.

Гишүүд асуулт асууж үг хэлж дууссан байгаа. Удахгүй санал хураалт явна. Санал хураалтад бэлдье. Хуруугаа уншуулаарай.

Батжаргал дарга аа, энэ нийгмийн даатгалын сантай холбоотой, нийгмийн даатгалтай холбоотой хуулийн төслүүд бэлэн байгаа гэсэн тэр ямар шатанд, ямар түвшинд бэлэн байгаа вэ. Микрофон 3-ыг нээе.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл бэлэн болсон. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд ер нь бэлэн болсон байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Монголбанканд 1 асуулт мартчихаж. Асуулт ч юм уу, үг байна.

Тэтгэврийн зээлийн талаар та бүхэн маань нэгэнт бодлогыг барьж байгаа юм чинь тодорхой бодлоготой баймаар байна. Дараагийн удаа яг ингээд юу яримааргүй байна. Түрүүн асуусан асуултыг гишүүд, би ч гэсэн асууна. Тэтгэврийн зээлийг байлгах гээд байгаа юм уу, байлгамааргүй байгаа юм уу. Зөв юм уу, буруу юм уу. Хэрвээ байлгамааргүй байгаа бол тэрийгээ бодлогодоо тодорхой тусгаад, мэргэжлийн институт юм чинь шулуухан хэлэх хэрэгтэй шүү дээ. Үндэслэлээ хэлээд байлгахгүй талаас нь ажиллаад, бусад зээлийг яаж нээх юм. Эсвэл хүүг нь яаж бууруулах юм гээд тодорхой байхгүй бол асуудлаа дагаж ингэж урсаад байх юм аль ч биш, юу ч биш бөөн хэл ам бухимдал үүсгээд байна. Үгүй бол үгүй. Тийм бол тийм. Бодлогоо хэлмээр байна. Дараагийн удаа яг асууна шүү та бүхэн бэлэн болоорой.

Гишүүд санал хураалтад бэлдье. Хуруугаа уншуулаарай. Би одоо хэлнэ ээ. Байж байгаарай. Санал хураалт. Энэ чинь минийх шүү дээ. Санал хураалтад бэлдье. Санал хураалтын томъёоллыг би уншиж танилцуулъя. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Санал хураалтын томъёолол нь ийм байна.

Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт шилжүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. Нийт гишүүдийн 51,4 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

15.08 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ